*Назарын хөдөлгөөнийг Христийн Монгол чуулгантай хамтран цэнэглэх номыг уншигчыг практик, хамаарал болон зорилготой байдал нь мэргэн ухааны баялаг буюу туршлага хүлээх болно. Дагалдагч бэлдэх чуулганы үүрэгт хүсэл эрмэлзэлтэй шинэчлэлийн төлөө хүсэл агуулан бичсэн нь, энэ ном таны зүрх сэтгэлийг сориод зогсохгүй гайхал түрүүлэм зорилготой санаануудаар хангасанаар таньд нийгэмдээ нигүүсэл ба үнэнээр үйлчлэхэд тусална. Миний найз Ларри МасКайн болон Монгол Чуулганы пастор Батхуяг Болд нар чуулганд хайртай алсын хараатай удирдагчид ба энэхүү төслийг Монгол Удирдагчидыг ирээдүйд итгэлээр цэнэглэгдсэн байхын тулд давуулан ажилласанд талархаж байна.*

*Доктор Кэйт Ньюман, Ерөнхийлөгч*
*Southern Nazarene University*

*20-оод жилийн өмнө,Доктор Ларри МакКайн асуугаагүй байхад тэр өөрийн гараар оролцон шийдэх ёстой ажилыг хийх хэрэгтэйг бас бусад хүмүүсийн хамт олж харсан. Үүний үр дүнд ирэх 8 жилийн турш сүм тарих 25 урсгал чиглэлийн 5400 удирдагчдад нөлөөлөх сургаж бас дасгалжуулах сестим болгосон. АНУ дах хэд хэдэн дүүргүүдэд адил сонирхол байсан нь: том, үржсэн чуулгануудын таригчид ньДоктор Ларри МакКайнаар сургагдаж бас дасгалжуулагдсан байсан юм. Одоо ч тэр дахин хийсээр, Пастор Батхуягтай хамт Христийн Монгол чуулган дах шаардлагтай эх сурвалжын хэрэгцээг олж тодорхойлжэй. Тэд Христийн Монгол Чуулганы сургалт болон өсөлтөнд туслах зуун зуун цагыг өөрсдийн гараар оролцоход зарцуулжээ. Одоогоос 20 жилийн дараа үр дүн нь дахин харуулах болно гэдгийг хүлээж байна.*

*Доктор Скотт Шервүүд*
*NW Illinios District Superintendent*

*Би цоо шинэ чуулганд цоо шинэ пастороор очих үед Дк. Ларри МакКайн миний дасгалжуулагч байсанаар ерөөлтэй байсан. Тэр надад цаг үргэлж урам зоригын эх сурвалж байсан бөгөөд шинэ чуулган эхлүүлж шинэ хүмүүст Есүсийн хайраар хүрэх гэсэн хүсэл мөрөөдлөө хуваалцаж байсан. Пастор Батхуягтай бичсэн энэ ном бол Христийн Монгол Чуулганд эх сурвалж болхоор мөн үнэхээр Монголчуудад Есүсийн хайраар хүрж найдвар авчрахаар зориулагджээ, хамгийн сайн ирэхэд тун ойрхон байна!*

*Реврэн. Бретт Рики, Удирдах Пастор*
*Highland Park Church*
*Lakeland, Florida*

MULTIPLYNAZ

# НАЗАРЫН ХӨДӨЛГӨӨНИЙГ ХРИСТИЧ МОНГОЛ ЧУУЛГАНТАЙ ИДЭВХЖҮҮЛЭХ

ЛАРРИ МАСКАЙН, БАТХУЯГ БОЛД

MULTIPLYNAZ Цуврал – 6 дугаар ном

НАЗАРЫН ХӨДӨЛГӨӨНИЙГ ХРИСТИЙН МОНГОЛ ЧУУЛГАНТАЙ ХАМТРАН ЦЭНЭГЛЭХ
**MULTIPLYNAZ** Цуврал – 6 дугаар ном

Copyright 2020 by **MULTIPLYNAZ**
First Draft Printing, Fall 2020

Хүсэлтийг доорх хаягаар хүлээн авна:
The **MULTIPLYNAZ** Office
439 S. Main St.
Bourbonnais, IL 60914

MULTIPLYNAZ мишион: “эрүүл, Назарын чуулганууд болон дүүргүүдийн өсөлтийг эх сурвалжаар хангах”

Нэмэлт хуулбарыг захиалах хаяг www.multiplynaz.org буюу 312-255-0151 дугаараар авч болно.

ISBN

Бүх Ишлэл татсан, хэрэв өөрөөр тодорхойлогдоогүй бол, АРИУН БИБЛИ ээс авсан болно: New International Version, NIV. Copyright 1973, 1978, 1984, 2011 оны Библикагаас. Zondervan-ы зөвшөөрөлөөр хэрэглэсэн. Дэлхий даяарх эрхийн хадгалагдсан болно.

MSG тэмдэглэгээтэй нь The Messsage ээс Ишлэлийг иш татсан болно. Copyright 1993, 1994, 1995, 1996, 2000, 2001, 2002. NavPress Publishing Group зөвшөөрөлөөр хэрэглэсэн болно.

Бүх эрх хадгалагдсан. Энэ хэвлэлийн ямарч хэсэг дахин хэвлэгдэж болохгүй, сэргээх сестимд хадгалагдсан тул, мөн ямар нэгэн хэлбэрээр буюу бүх л хэлбэрээр – электроник: механикаар, дүрст хуулбар, бичлэг, эсвэл өөр бусдаар – хэвлэгдсэн жишэгээр хоромхон дурдахаас бусдаар, урьдаас нийтлэгчийн зөвшөөрөлгүй хэрэглэх.

Доторхи дизайныг Лиана Брүнэр

Америкын Нэгдсэн Улсад хэвлэв.

Бид эдгээр цуврал номыг бид бүхний дунд буй шинэ итгэгчиддээ эхлээд зориулсан. Чуулган таны төлөө оршин тогтдог. Бид ирж буй жилүүдэд хоёр сая гаруй нь ихэвчлэн дэлхий даяарх хотуудаас байх болно гэж харж байна! Бид таныг Бурханы хүмүүсээр дамжуулан дэлхий даяарх Бурханы хөдөлгөөнд тавтай морилохыг хүсч байна. Мөн бидний тухай илүү танин мэдэх урилгийг хүлээн авсанд талархаж байна. Та бидний дунд харяалагддаг шүү. Та дулаанхан нөхөрлөл, олон талын баялаг, нигүүлсэнгүй сэтгэл, дэлхий даяарх мишион болон бидний хийдэг бүхнийг Христтэй адил байх гэсэн хүслээр байдгийг олж харах болно.

Бид мөн энэ цуврал номыг Монголын торгоны урьд алхагч танигдаж амжаагүй баатрууд, ахлагчид, чуулган таригчид, урьд үйлчилж байсан буюу одоо ч үйлчилж байгаа том бага гэлгүй чуулганы пасторууд, алсын хараатай багш нар, ертөнцийг зөвхөн одоо байгаар нь биш харин ямар байж болохыг хардаг гал халуун оюутнууд, удирдагчидын хөдөлгөөн нь Христийн чуулган дах харааны төлөө долоо долоо хоногоох өөрсдийгөө харамгүй зориулагчдад зориулсан. Бурхан хүн болгоныг нэрээр нь мэддэг (Гэтлэл 33:17) ба “ Учир нь Бурхан бол та нарын ариун хүмүүст үйлчилсэн бөгөөд одоо ч үйлчлэн байгаагаараа Өөрийнх нь нэрийн төлөөх та нарын үйл хэргийг болон хайрыг тань мартахаар шударга бус биш.” (Еврей 6:10).

Эцэст нь бид энэ цуврал номыг АНУ дах өсөж буй Бурханы хүмүүсээр дамжуулан Бурханы хөдөлгөөнд нэгдэж байгаа Христийн Монгол Чуулгануудын удирдагчидаар дамжуулан бидний дунд болж буй мөн бас мөрөөдөж байсан ирээдүйг бүтээхийн тэлд зориулав. Бид хамтдаа гайхамшигтай аянд явж байна.  Жон Весли хэлэхдээ, “хамгийн гайхамшигтай зүйл бол, Бурхан бидэнтэй хамт юм!”

# Гарчиг

Өмнөх Үг – Яагаад бас Хэрхэн энэ цуврал ном гарах болсон…..

Хэрхэн энэ номыг хэрэглэх …………………………

Оршил — Чуулганд тавтай морил……………………..

**6 дугаар Ном – Христийн Монгол Чуулган**

1. Гайхалтай Ирээдүйг Хамтдаа …………………………………
2. Эдгээрээс Хамгийн Агуу нь – Хайр юм………………………
3. Гадны Хүмүүст Анхаарал Төвлөрүүлсэн Хөдөлгөөн ………
4. Чуулганы тухай Бидний Итгэл ……………………….......
5. Назарын Харилцан Хамааралыг Баримталдаг Шалтгаан ….
6. Үржиж Өсөх Тушаалыг Дэлгэрүүлэх…………………………
7. Нөлөөт Чуулганы Соёлыг Байгуулах ..................................

/Чуулганы нөлөөт уламжлалыг бий болгохуй/
Зөвөлгөө болон Засварын санал Хүлээн авах…………………....
Ишлэлийн Индэкс ……………………..........................................
Тэмдэглэл болон Кредит………………………………..........................

# Өмнөх Үг

Яагаад **MULTIPLYNAZ** Цуврал Бий Болов

Энд хэд хэдэн шалтгаанууд байсан тул бид чуулганы төлөө энэхүү цуврлыг бичигдэх цаг боллоо гэж үзсэний үүднээс бичсэн юм. Судар бидэнд хэлэхдээ, "Тэнгэрийн доорх бүх юмс цаг хугацаатай бөгөөд бүх юм тогтоогдсон цаг мөчтэй ажээ" (Номлогчын Үгс 3:1). Бид Назарын хөдөлгөөн бол дэлхийд нууцлагдсан нууцын нэг гэж итгэдэг буюу хэрэв олон хүмүүс бидний юу хийж байгааг, яагаад хийдгийг бас хэрхэн бид хийж байгааг мэддэг бол дэлхий даяар тархсан Христич Монгол Чуулганаас хураах үр дүн нь гайхалтай байна гэдэгт итгэж байна.

Олон чуулганы удирдагчидаас хүлээн авсан санал хүсэлтээс нэг MULTIPLYNAZ номноос үржин олон цуврал ном болох төсөл бий болсон юм. Өөр өөр номнууд хоорондоо ялгаатай сонсогчдын хэрэгцээнээс урсан гарсан юм. Үүнийг бичиж байхад дараах номнууд тухайн цагтаа бий болсон юм.

1-р Ном—Назарын Хөдөлгөөнийг **Хайраар** Цэнэглэх (төвлөрсөн) Сүнслэг Хөдөлгөөний Суурь нь (сонсогч) Хүн болгонд Зориулагдсан

2-р Ном—Назарын Хөдөлгөөнийг **Эрүүл ба Өсөх Үрждэг Чуулганаар** Цэнэглэх (төвлөрсөн) Нутгын Чуулганы Эрүүл байдал ба Чуулганы Дэвшил (сонсогч) Нутгын Пастор ба Ахлагчид

3-р Ном—Назарын Хөдөлгөөнийг **Чуулганы Хөгжлийн Төвөллөгөөгөөр** Цэнэглэх (төвлөрсөн) Нутгын Чуулганы Эрүүл байдал ба Чуулганы Хөгжил (сонсогч) Нутгын Пастор ба Ахлагчид

4-р Ном—Назарын Хөдөлгөөнийг **Эрүүл Дүүргүүдийн Хамт Цэнэглэх** (төвлөрсөн) Дүүргийн Эрүүл байдал ба Дүүргийн Хөгжлийн Төлөвлөгөө (сонсогч) Дүүргийн Эрхлэгч ба Дүүргийн Удирдагчид

5-р Ном—Назарын Хөдөлгөөнийг **Чуулганы Хэлбэржилтээр Цэнэглэх** (төвлөрсөн) Чуулганы Хөгжил дөх Хэлбэржилтын Үйл Явц (сонсогч) Хэлбэржиж буй Пастор ба Ахлагчид

6-р Ном – Назарын Хөдөлгөөнийг **Христич Монгол Чуулгантай Цэнэглэх** (төвлөрсөн) Христич Монгол Чуулганы Хөдөлгөөн (сонсогч) Дэлхий даяарх Христич Монгол Чуулганы Удирдагчид

MULTIPLYNAZ цуврал хэдийгээр бичигдэж эхэлсэн ч хараахан дуусаагүй байгаа. Бид энэ цуврал номыг ганц хүнийх байхаар биш харин дэлхий даяарх чуулганы удирдагчидаар бичигдсэн байхыг хүсч байна. Хэрэв бидэнд энэ боломж гарвал БҮХ пастор болон ахлагч нар оролцсон байх болно. Чуулган зөвхөн хэдхэн хүнд биш харин бүх хүнд хамааралтай байдаг. Хүн болгон түүхээ бичих хэрэгтэй, тэгээд хүн бүр үүгээр хаа сайгүй байх боломж юм. Бид дэлхий даяар байгаа 30,700-аас илүү чуулганд одоо болж байгаа бүх гайхамшигийг хэвлэхийг хүсдэгт **онцгойлон Бурханы Монголд босгож байгаа шинэ чуулганууд юм!**

Энэ номны тухай тайлбарын хуудас—д www.multiplynaz.org хуудасанд та хэрхэн оролцож болох тухай тайлбарласан байгаа мөн таны санал хүсэлтийг хүлээн авах болно. Энэхүү цуврлыг илүү дээр болгоход оруулсан таны зориулалтанд урьдаас талархсанаа илэрхийлж байна! Христич Монгол Чуулганы Удирдагчдад зориулан бичих болсон хэд хэдэн шалтгааныг доор дурдлаа.

**Бурханы Хөдөлгөөн Бурханы Хүмүүсээр**: Бид Назарын хөдөлгөөний талаар Христич Монгол Чуулганы Удирдагчдад бидний хөдөлгөөний талаар бага зэрэг болон ямарч ойлголтгүй байгаад танилцуулахыг хүссэн юм. Бид чуулган хэрхэн библи дээр сууриласан болон түүхэн үндэстэй байгаа байдлаар Монгол чуулганы удирдагчид ашиг тусыг нь авна гэдэгт итгэж байна.

**Бидний Мэдээ**: Бурханы Хайр: Бид бүх зүйлээс илүү Бурханы хайрыг хэрэгжүүлэх нь Есүсийн гол санаа байсаныг дахин онцгойлохыг хүссэн юм. Бид Христич Монгол Чуулганыг хайраар тэргүүлэхийг уриалж байна.

**Хувь Хүний Ашиг Сонирхол биш:** Хувь хүний бичсэн олон ном бичигдээд дуусаад, хэвлэгд ороод бас хэвлэгдээд дараа нь ашигтай зарагддаг. Энэ ном бол онцгой юм. Энэ номоор үнтэй хэвлэгддэг. Хэнч энэ номноос ашиг авахгүй. Ном зарагдах болгонд бүгд Христич Монгол

Чуулган болон удирдагчидыг босгон байгуулах Христич Монгол Чуулганы санд хандив болон очих болно. Номны үнэ тогтоосон нь бичсний төлөө хувийг гаргах гэж биш харин үнэ цэнийг тогтоохын тулд байв.

**Төгс биш Чуулганыг Хайрлах:** Бид Есүсийн үүсгэсэн чуулган үнэхээр төгс биш байсныг онцгойлохыг хүсч байгаач түүний хараа нь чуулганы төлөө “өөрийгөө бүрэн зориулах” –д өдөөсөн юм (Ефес 5:25-27). Бид чуулган дах хүн бүр Түүний жишигийг дагаж мөн адил зориулалтай байх хэрэгтэй гэж итгэж байна.

**Хамтын Ариусгал:** Бид хамтын ариусгалыг хэрэгжүүлсэн чуулган хэрхэн үржиж байгааг олонтаа харсан. Бид мөн бүх Христич Монгол Чуулганы удирдагч Есүс бидэнд заасанчлан (Иохан 12:24) хэрхэн ариусгал үржилтэй харилцан холбоотой байгааг ойлгоосой гэж хүсч байна.

**Есүстэй Зөвшөлцсөн Төлөвлөгөө:** Бид Христич Монгол Чуулганы удирдагчбиблисуурьтайзөвшөлцсөнтөлөвлөгөөнийталааройлголттой байхыг хүсч байгаа нь, хэрхэн үүнийг өвлөх нь сүнслэг цөмлөлт болон бүх Христич Монгол Чуулган хамтдаа ажиллан байгуулахад тустай байдал руу хөтөлдөг. Бид бас Христич Монгол Чуулганы хөдөлгөөн ямар харагдахыг, хэрэв удирдагчид нутгийн болон хувийн төлөвлөгөөгөө хажуу тавьж зөвхөн Есүсийн төвөллөгөөг чуулган нутагтаа болон ертөнцөд хоёуланд нь нөлөөлөхийг хураангуйлан хайх юм бол тодорхойлохыг хүссэн. Энэ бол цаг хугацаа шаарддаг бөгөөд дахин дахин өөрсдийн боддог аргаа өөрчлөх гэсэн хүсэл эрмэлзлийн үйл явц юм.

Бид бас Христич Монгол Чуулганы хөдөлгөөн ямар харагдахыг, хэрэв удирдагчид нутгийн болон хувийн төлөвлөгөөгөө хажуу тавьж зөвхөн Есүсийн төвөллөгөөг чуулган нутагтаа болон ертөнцөд хоёуланд нь нөлөөлөхийг хураангуйлан хайх юм бол тодорхойлохыг хүссэн.

**Харилцан Хамааралтай Байх Библийн Суур:** Бид бүгд анхны чуулган бие биентэйгээ харилцаж байсан аргийн тухай Библи юу зааж байгааг өөрсөддөө сануулж байх хэрэгтэй байх. 4-р бүлэг Христитгэлт

бид яагаад бие даасан байдлаар бус харин харилцан хамааралтай байх хэрэгтэйг тайлбарлана. Бид библийн болон үр ашигтай шалтгаануудыг хамруулан, яагаад бид харилцан хамааралтай байхыг эрхэмлэдэг болоод бид Бурханы хөдөлгөөнөөр мянга мянган илүү Монголчуудад Христийн нэрээр хүрч болхыг хангахыг хүссэн юм.

**Нөлөөтөй Уламжлал:** Бид Христич Чуулган бүр нөлөөтөй уламжлалыг байгуулахын давуу талыг ойлгоосой гэж хүсдэг. Бид мөн бас энэ нь хэрхэн биелэлээ олж болох талаарх ойлголтыг үр ашигтай түлхүүрийг пастор болон чуулганы удирдагчдад хүргэхийг хүссэн.

**Хөдөлгөөнт Хэвшилтэй Харилцах:** Христич Монгол Удирдагчид чуулган хэрхэн тэлж байгааг мэдэх хэрэгтэй. Дэлхий техник технилогын улмаас үргэлж агшаар байна, бид харин өөрсдийнхөө сайн мэдээ тараах болон амжилттай чуулган турилтаа хуваалцахдаа сайн ажиллах хэрэгтэй. Хоёр сая шинэ итгэгч нар ирэх хэдхэн жилийн дараа Назарын Хөдөлгөөнтэй нэгдэх болно. Бид харилцаагаа илүү сайжруулж бас бүх Христич Монгол Чуулганы удирдагч нарыг манай гэр бүлд хамрагдахыг бодолцож үзэх зуураа шаардлагат хэрэгцээгээр нь хангаж хаана үйлчилж байгаа тэр газартаа Бурханы хөдөлгөөнийг илүү нөлөөтөйгөөр цэнэглээсэй гэж хүсч байна.

**Бүх Улсад Тэнцвэртэй Ажиллах:** Америк бизнес шиг биш, манай чуулган олон улсын хэмжээнд байх замыг БҮХ улсад ба дэлхийн олон буурай оронд ч тэнцвэртэй ажиллахыг санаатайгаар сонгосон юм. Америк чуулганууд болон Монгол чуулганууд ч мөн үргэлж тэнцвэртэй бас адилхан хэмжээнд танигдах ёстой. Олон улсын чуулганы хувьд бидний шийдвэр бол үргэлж Хаанчлалын үнэ цэнэ байх болно.

**“Гадных” Тэмүүлэл:** Христич Монгол Чуулганууд сайн мэдээний төлөө зрх сэтгэлтэй, Хаанчлалаас гадуурх байгаад хүрэх чуулган тарилт юм. Чуулган удаан байх тусам гадныхны төлөө зүрх сэтгэл өөр бусад зүйлээр орлогдох нь амархан болдог. Бид энэ номоор Есүсийн “анхны хайр руугаа буцах” дуудлага болгон бас Түүний төлөвлөгөө байлгахыг хүссэн. Бид “Бурханы бэлгийн дөлийг бадраахыг” (2 Тимот 1:6) –ыг хадгалж бид бусдын төлөө зүрх сэтгэлээ цэнэгтэй байхыг хүсдэг.

**Гадных руу Хандсан Чуулганы Шинжүүд:** Бид гадных руу хандсан шинжүүдийг өргөн хүрээтэйгээр түгээхийг хүсдэг. Энэ хамрагдах шинжид: 1. их хүлээц, 2. сүнслэг байдлыг ойлгох, 3. Зочломтгой байх, 4. Зочиноо тухтай байлгах ба 5. Гадных руу зүрх сэтгэлтэй байх.

**Чуулган Бүр Дагалдагч Бэлтгэх "Дараагийн Шат" –ыг Бий Болгох:** Бид боловсрол болон бүх Христич Монгол Чуулган хоёрыг дагалдагч бэлтгэх үйл явцдаа бодолцож, "Дараагийн Шат" энгийн цувралыг боловсруулж шинэ хүмүүс чуулганд ирсэн үедээ л ойлгож дагаасай гэж хүсдэг.

**Хүн Бүр Илгээгдэгч шиг Бодож Сурах:** Бүх Христич Монгол Чуулганы удирдагчид илгээлтийн талбар дээр амьдарч байгаа. Бид чуулган болгонд байгаа хүн бүр илгээгдэгч шиг бодож сурахын чухлыг, үүнд бид уламжлалт бус микро-Монгол чуулганыг тарихад чадах чинээгээрээ буюу хэзээч хамаагүй оролцоотой байхыг дахин цохон тэмдэглэхийг хүсдэг.

**Төвөллөгөөнд хүрэх зам:** Бид Христич Монгол Чуулганд төлөвлөгөөнд хүрэх замыг танилцуулахыг хүсч байна. Бид 1. Залбирал 2. Бурханы Дуудлага 3. Бэлтгэл 4. Эрэгцүүлэл 5. Сургалт 6. Чуулган Байгуулах Төлөвлөлт болон 7. Ментор зэрэг нь дэлхий даяарх Монгол Чуулган бүрийн удаан хугацаанд чанартай байхад том нөлөөг оруулах болно.

**Сүнслэг Бэлтгэл:** Бид бүх Христич Монгол Чуулганд сүнслэг бэлтгэлийн талаар яагаад **залбирал** болон **төлөвлөх** нь хоёулаа чухал болохыг тайлбарлаж бас жил болгон шинэчлэх Чуулган Байгуулах Төлөвлөлтийг бий болгоход туслах энгийн аргачлалыг танилцуулахыг хүссэн. Чуулган байгуулалтанд гарах томоохон алдаа бол дутагдал төлөвлөгөөнөөс болдог.

**Монгол болон Оливет Назарын Их Сургуулийн Түншийн Харилцаа:** Дэлхий даяарх Назарын боловсролын төвүүдэд одоогоор 51,000 оюутаны элсэлттэй байна. Иллимойс мужын Чикаго хотын ойролцоо орших Оливет Назарын Их Суруувль бол тэдний нэг юм. Бидэнтэй хамтрагч Христич Монгол Чуулганаас Оливетын Их Сургуульд элсэх оюутанд төлбөрөөс нь 50% хөнгөлөлтийг санал

болгодог. Мэдээлэлийг **www.olivet.edu** цахим хуудасаар хүлээн авч болно.

Та уншиж бас танин мэдэх зуураа 6-р ном бол Христич Монгол Чуулганы төлөө бичигдсэнийг харж байгаа байх, Бурханы хүмүүсээр дамжуулан Бурханы энэ хөдөлгөөн ямар гайхамшигтай байгааг харна гэдэгт итгэж Есүсийн хайртай чуулганд сэтгэл татагдана гэдэгт мөн бас эргэлзэхгүй байна. Хэрэв та Христийн Сүйтэд зориулсан зориулалт чинь бадарсан бол Есүсийн төлөвлөгөөнд таны хайр улам гүнзгийрч бол бидний зорилго биелэлээ олжээ. Бид таны төлөө залбирч байна.

Дк. Ларри МакКайн
Пастор Батхуяг Болд

# Энэ Номыг Хэрхэн Ашиглах Тухай

Бид энэ номыг зөвхөн уншихад биш хэрэглүүлэхийг гэж хүсч байна. Ингэхийн тулд бидэнд үргэлж хамтдаа цугларч залбирах, библи уншиж бас номын тухай хэлэлцэн бие биенээсээ сурах пасторын бүлэг, гэрийн бүлэг, Хүүхдийн Цуглаан юм уу долоо хоногийн дундуурх цугларалтыг бодолцох шаардлагатай болсон. Бид бичиж байхдаа хүртэл үргэлж Есүсээс суралцахыг оюун санаандаа тээсэн.

Бид Есүсийн бэлтгэлийн жил түүний төрөлт (Лук 2:1-20) болон түүний үйлчлэлийн эхлэл (Лук 3:21-22)-ийн тухай багаханыг мэддэг. Бид түүнийг бага насандаа богино хугацаанд Есүс Египет рүү явсан (Матай 2:12-15) болон тэр буцаж ирээд Назарт өссөнийг мэднэ (Матай 2:19-22). Үүгээр бид **Назарын** Чуулган нэрийг авсан (Матай 2:23).

Бидний мэдэх өөр Есүсийн тухай хүүхэд насных нь тухай бичигдсэн тохиолдол бол тэр жил болгон Иерусалимд болдог Дээгүүр Өнгөрөх баярт оролцдог байсан (Лук 2:41). Чин сүжигт Еврей гэрт өссөнөөр Иерусалимд болдог Дээгүүр Өнгөрөх баярт олонтаа очсон. Еврей хүүхэд 12 нас хүрхэд тэр “хууль доорх хүү” болдог ба залуу Еврей байхын утга учир бүрэн хариуцлагийг хүлээн авдаг.

Түүнийг 12 настай байхад болсон Дээгүүр Өнгөрөх баярт Есүст юу болсныг бид мэдэхгүй, гэвч бид төрөл садан болон найз нөхдийн хамт МАШ үйл явдал болсон гэдгийг мэднэ. Тэнд 12 настай хүүд олон ёслолууд, багш нар хуулийг Еврейгээр уншиж тэнд Есүсч оролцсон цаг байсан. Тэнд түүний зөв гэж мэдэх зүйлийг хэрэгжүүлэх, дүү нартаа найрсаг байх, тусламж хэрэгтэйд туслах болон Абрахам, Исаак, Иокавын Бурханд итгэмжтэй байх шалгуур байсан байх.

Баяр дуусахад Есүсийн эцэг эх түүнийг бусад төрөл садан, найз нартайгаа байгаа гэж бодсон тул Назар руу буцах замдаа хамтдаа хөдөлж бүтэн нэг өдрийг түүнийг харалгүй аялсан байв. Тэд Есүсийг төрөл саданыхаа дунд хайсан боловч түүнийг олоогүй тул Иерусалим руу буцсан (Лук 2:42-45). Гурван өдрийн дараа тэд Есүсийг хоёр зүйлийг “багш нарын дунд хийж байхад олсон, 1) тэднийг **сонсож** 2) тэднээс **асуулт асууж**” (Лук 2:46).

Энэ бол Есүсийн сурах арга барил байв – сонсож бас асуулт асууж. Есүс амьдрлынхаа туршид сонсох болон асуулт асуухыг дадал болгосон. Хэрвээ бид түүнийг жишигийг мөрдөж мөн бас зүгээр л зөв асуултыг асууж сурвал, бид үргэлж тулгарч байгаа асуудлындаа зөв хариултыг авах болно. Доор бид бичиж байхдаа “уншигч” асуух

гурван асуултыг санаандаа тавьсан:

1. Ном юуг хэлээд байна?
2. Энэ санааны утга юу вэ?
3. Бид үүнийг чуулгандаа хэрхэн хэрэглэх вэ?

Уншигч таныг энэ номыг арай дээр ойлгож бас номыг зөв хялбарчилан хэрэглэхэд дараах асуултуудыг оруулсанаар пасторын бүлэг, гэрийн бүлэг, Хүүхдийн Цуглаан юм уу долоо хоногийн дундуурх цугларалтанд туслахын тулд оруулсан. Эдгээр нь бүлгээр эмхлэгдсэн.

**ЭргэцүүлэхАсуултууд – Гарчиг болон Өмнөх Үг**

1. Христич Монгол Чуулганд зориулан ном бичих нь сайн санаа байсан гэ та бодож байна уу? Яагаад эсвэл үгүй гэж? Энэ номыг сайжруулахад та хэрхэн илүү бас сайн санааг дэвшүүлэх вэ?
2. Энэ номыг гол зорилго бол эрүүл бас Христич Монгол Чуулганы өсөлт юм. Энэ зорилго дотор таны хувьд агуулга эсвэл гол асуудлыг дурдаагүй мэт мэдрэмж байв уу? Тийм бол юу вэ?
3. Энэ номны Өмнөх Үгийг уншиж байх зуур дурдаж байгаа цөөнгүй хэдэн асуудлууд тавигдахад ямар асуудал нь таны хувьд нөлөөлсөн бэ? Яагаад?
4. Энэ номны Өмнөх Үгийг уншиж байх зуур чуулганы тухай таны урьд өмнө мэдээгүй зүйлээ сурсан зүйл байв уу? Тийм бол юу вэ?

# Оршил

# Чуулганд Тавтай Морил

Есүс “Тэгээд Назар гэгдэх хотод очиж суурьшив. «Назарынх гэж Тэр дуудагдах болно» гэж эш үзүүлэгчдээр айлдуулсан нь ийнхүү биелэгджээ.” (Матай 2:23)

Хэрэв та манай чуулганд дэлхий даяарх мянга мянган хүмүүс шиг шинэ бол та өөрөөсөө “Назар гэж юу вэ?” гэж асууж байгаа байх. Бид өөрсдийгөө Назарын Чуулган гэж дууддаг учир нь бид Чуулганы Тэргүүн болох Назарын Есүсийг дагадаг (Ефес 4:15-16).

Хүмүүс Есүсийг дагахгүй байсан ч дийлэнх нь Есүс Христийг хамгийн аугаа удирдагч гэмээн хүлээн зөвшөөрдөг. Түүний дэлхий рүү ирэлт нь бидний он тоололыг хоёр хуваасан. Бид хэдэн он билээ гэж бодох болгонд Бурханы Хүү хүн төрлөхтний цусан холбоост нэгдсэн тул бид хичнээн жил өнгөрснийг санадаг билээ. Бурхан хүн болж (Иохан 1:1-14), тэр 2000 гаруй жилийн өмнө энэ ертөнцөд мэндэлсэн бөгөөд Египетэд хэдхэн жил амьдарсны дараа (Матай 2:19-22) Есүс болон түүний гэр бүл Назар гэгдэх тосгонд ирсэн.

Есүс гурван жилийн багшлах болон сургаалийн үйлчлэлээ эхлэхээс өмнө 30 жилийг Назарт өнгөрүүлсэн (Лук 3:23). Тэр Ромын загалмайд цовдлогдсон нь түүхэн баримт буюу өөрийн биш агууд оршуулагдсан бөгөөд гурван өдрийн дараа Есүс үхлээс амилж өнөөдөрч амьд байгаа!

Энэ бол “Назарын” Чуулганы библи дээрх суурь билээ. Бидний чуулганы суурь зөвхөн теологи эсвэл түүхэнд биш Хүн дээр баригдсан. Назарын Чуулган бол зөвхөн гайхалтай итгэлийн урсгал буюу гайхалтай нийгэмлэг биш. Бидний андгай зөвхөн хүний байгууллагат бас биш. Бид амьд бүр дахин амилсан хүн Есүсийг дагадаг. Та Назарын Чуулганы тухай сонсох болгондоо Есүсээр удирдуулсан Назарын чуулган гэдгийг хамгийн түрүүнд бодох байх гэдэгт итгэж байна! Бидний зорилго бол Түүнийг дагаж дэлхийн бүх үндэстэнд Христ шиг дагалдагчидыг төрүүлэх явдал юм.

Та Назарын Чуулганы тухай сонсох болгондоо Есүсээр удирдуулсан Назарын чуулган гэдгийг хамгийн түрүүнд бодох байх гэдэгт итгэж байна!

Манай чуулганы нэрэнд библийн болон түүхэн үндэстэй. Шинэ Гэрээнд арван хоёр удаа Назартай холбоотой дурдагдсан зүйлийг олдог. Библид Есүсийн дагалдагчид Христич гэж дуудагдахаас өмнө тэд Назарынхан гэдгээр дуудагддаг байсан. Библид Есүсийн дагалдагчид Христич гэж дуудагдахаас өмнө тэд Назарынхан гэдгээр дуудагддаг байсан. Дөрвөн дуртгалыг хэлж болно. Нэгд, иш үзүүлэгч нар Есүсийг Назар гэж дуудсан. Есүс "Назар гэгдэх хотод очиж суурьшив. «Назарынх гэж Тэр дуудагдах болно» гэж эш үзүүлэгчдээр айлдуулсан нь ийнхүү биелэгджээ" (Матай 2:23).

Библид Есүсийн дагалдагчид Христич гэж дуудагдахаас өмнө тэд Назарынхан гэдгээр дуудагддаг байсан.

Хоёрт, элч Паул "Назарын" чуулганы удирдагч байсан. Паул Кайсарид байхад захирагч Филиксийн өмнө зогсож, "зарим ахлагчид болон Тертул гэгч өмгөөлөгчийн хамтаар ирж, Паулын эсрэг захирагчид гомдол мэдүүлэв" (Үйлс 24:1). Тэдний буруутгал нь, "үймээнийг дэгдээгч бөгөөд Назарын бүлэглэлийн толгойлогч болохыг нь бид олж мэдсэн юм" байсан (Үйлс 24:5). Гуравт, Петр Есүсийг гурвантаа үгүйсгэх тэр шөнө, "тэргүүн тахилчийн шивэгчингүүдийн нэг нь ирж," (Марк 14:66). Тэр галын хажууд зогсож буй Петрийг сайтар хараад, "Чи ч бас Назарын Есүстэй хамт байсан шүү дээ" гэж хэлсэн(Марк 14:67).

Дөрөвт, хүний түүхэнд болсон хамгийн аугаа үйл явдал болсон тэр өглөө хоосон булшинд тэнгэр элч эмэгтэйд, "Назарын Есүсийг та нар хайж байгаа. Тэр амилсан, Тэр энд байхгүй" гэж хэлсэн (Марк16:6). Бурханы хүмүүсээр дамжуулан Бурханы хөдөлгөөн зөвхөн байгууллагад биш харин хүн дээр **Назарын Есүс** дээр төвлөрсөн!

Назарын Чуулган бол өнгөрсөн 2000 гаруй жилийн чуулганы түүхийн нэг хэсэг юм. Бид Үгийг номлохдоо түүхэн чуулгантай дүйцүү байгаагаа болон зан үйл удирдахдаа буюу хүмүүсийг Бурханд бүрэн зориулалтай ариун амьдрахыг уриалдаг. 18 зуунд Англид Жон болон Чарлис Весли нарын номлолоор дамжуулан мянга мянган хүмүүс гэмээсээ эргэж Христич үйлчлэлд хүчирхэгчсэн байдаг.

Жон Весли Библиэс заахдаа Христитгэлтнийг зөвхөн Есүсийг Аврагчаа болон хүлээн авах биш мөн бас амьдралаараа Түүнд бүрэн бууж өгөхийг уриалдаг байсан нь "**бүрэн ариусгал**" юм. Өөрөөр

хэлбэл өөрийнхөө хүслээр биш харин Есүсийн хүсэлд өөрийн амьдралаа бүрэн дүүрэн зориулах явдал гэж хэлмээр байна. Элч Паул тайлбарлахдаа бидний бүхийл сүнс, сэтгэл, болон бие Ариун Сүнсээр дүүрэн байхын тулд биднийг “дахин дахин ариусгахыг” Бурхан амалсан бөгөөд бидний хүсэл эрмэлзэл Есүсийн хүсэл болох юм (1 Тесалоник 5:23-24). “Бурханы бүхийл хүсэл” бүрэн ариусгал (Үйлс 20:27) бол манай чуулганы заах онцлог бөгөөд дэлхий даяарх Назарчуудын зориулалт юм.

Энэ бол мөн бас библи дээр сууриласан чуулганы өсөлтийн түлхүүр юм. Ариусгал үгийн утга бол “Бурханы зорилгын дагуу ариусгагдан тусгаарлагдсан” гэсэн үг юм. Хувь хүн ариусгагдах үед тэд Есүс ба түүний хүсэлд бүрэн зориулалтай болдог. Чуулган ариусгагдах үед чуулган ч мөн бас Есүс болон түүний хүсэлд бүрэн зориулалттай болдог. Чуулган зөвхөн өөрийнхөө төлөө санаа тавьдаггүй. Харин нутгийн чуулган ариугагдах үед өөрийнхөө зарим болон бүхийл зүйлээ хаанчлалын өсөлтөнд зориулахад бэлэн болдог (Иохан 12:24).

> Харин нутгийн чуулган ариусгагдах үед өөрийнхөө зарим болон бүхийл зүйлээ хаанчлалын өсөлтөнд зориулахад бэлэн болдог.

**M U L T I P L Y N A Z** термийг хэрэглэх болсон шалтгаан бол Назарын Чуулган өсөлтөнд зориулалттай Бурханы хүмүүсийн Бурханы хөдөлгөөн учраас юм. Би бол гадных руу төвлөрсөн хөдөлгөөн. Бид бол хүмүүсийг ариусгагдсан байхаар шалгуурт уриалдаг хөдөлгөөн, мөн бас нутгийн чуулганыг ч уриалдаг. Чуулган ариусгагдах үед тэд өөрсдийн хэв маяг болон өөрсдийгөө давуулан хардаг болдог. Тэд Хаанчлалд байгаа газраа үйлчилж байхад тэд Есүсийн даяарх харааг харж “ явж бүх үндэстнүүдийг дагалдагч болго” оор явдаг (Матай 28:19).

Энэхүү хараанд нэгдсэн нутгийн чуулганаар, Назарын Чуулган олон улсад илэрхий хурдацтайгаар тэрэлж байна. 1908 оны төлөв эхлэлээс өнөөдрийн байдлаар чуулган маань дэлхийн 160 гаруй орнуудад хүрлээ. Энэд олон оронд далд байдлаар удирдагч нар өөрсдийн эрсдэлтэй байвч чуулганаа явуулж сайн мэдээг тунхагласаар байна. Үүнийг бичиж байхад долоо хоног бүр Назарын Чуулган дотор 27 шинэ чуулганыг эхлүүлж байна. Долоо хоног бүр бид 2872 шинээр

хүмүүс чуулганд хамрагдаж байна. Назарын чуулган энэ хэмнэлээр өнгөрсөн 10 жилийг турш өсөж байна.

Бид таныг Бурханы хүмүүсээр дамжуулан хийх Бурханы хөдөлгөөнд уриж байна. Бид Назарын Чуулганаар долоо хоног бүрт Пентакостад чуулганд нэгдсэн адил тооны хүмүүс буюу 3000 хүмүүс нэгдэх өдөр удахгүй ирнэ гэдэгт эргэлзэхгүй байна! (Үйлс 2:41) Бид бол зөвхөн ганц чуулган биш, олон газарт Есүсийн олон чуулганаар дамжуулан хийж буй ажлын хэсэг юм.

Долоо хоног бүр Назарын Чуулган дотор 27 шинэ чуулганыг эхлүүлж байна. Долоо хоног бүр бид 2872 шинээр хүмүүс чуулганд хамрагдаж байна. Назарын чуулган энэ хэмнэлээр өнгөрсөн 10 жилийг турш өсөж байна.

Дэлхий даяар хүмүүс Есүсийг дагаж бас түүний чуулганд нэг нэгээрээ хамрагдсаар байна. Тэр бидний чуулганд байгаа хүн нэг бүрийг нэрээр нь мэддэг. Тэр мөн бас гадна байгаа хүн нэг бүрийн нэрийг мэддэг. Нэгдсэн Үндэсний байгууллагас гаргасан дэлхийн хүн амын тоог харвал 2024 он гэхэд найман тэрбүмд хүрч 2042 он гэхэд есөн тэрбүмд хүрэх бүрэн боломжтой байна. Есүс гишүүн болгонтой дотно харилцаатай байж бас халамжилж байхад Есүс бидний өөрөөнсөө гарч төөрсөн нэгнийг хайж гадна байгааг тэр олтол хайхыг хүсч байгаа гэдэгт итгэж байна (Лук 15:4-7). Тэр аль хэдийнээ тэдний нэрийг мэддэг бас хаана амьдардгийг нь ч мэддэг (Үйлс 17:26) бөгөөд тэр биднийг тэдэнтэй танилцуулахыг хүсдэг! Есүс тэдэнтэй танилцах үед тэр гадныхныг гараа дэлгэн хүлээн авч түүний аав нь алдагдсан хүүгээ хүлээн авч байгаа мэтээр хүлээн авдаг (Лук 15:17-32). Тэр тэднийг гэрт нь авчирч баярын цэнгээн хийдэг! Энэ бол Есүсийн хүсэл – ба учир нь энэ түүний хүсэл тул бид үүнийг өөрсдийн хүсэл болгосон.

Есүсийн хүсэл бол гадныхыг хүлээн авдаг ба учир нь энэ түүний хүсэл тул бид үүнийг өөрсдийн хүсэл болгосон.

Бурхан чуулганы төлөө зорилго агуулаагүй. Бурхан өөрийн зорилгын төлөө чуулганыг байлгадаг. Бид ичгүүргүй тэрхүү зорилгын төлөө оршдог, үг болон үйлсээр итгэлээс тусгаарлагдсан, итгэлийг үгүйсгэж бас тэдний төлөө Бурханы хайранд

сэрэмжгүй байгаа хүмүүст гэрчлэлийг өвөрлөдөг (1 Коринт 13:13). Есүс гадна байгсадын төлөө ирсэн. Бид “гадна байгсадтай” эсвэл “төөрсөн” гэх мэттэй харьцахад бидний байгаа тэр газар соёлоос хамааран хэлний бэрхшээл байгааг мэднэ. Бид хүрээлэн байгаа сонсогчтойгоо хэрэглэх хамгийн зөв үгийг олохыг хүсдэг. Энэ биднийг удирддаг хайр юм.

Библи хэлэхдээ “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул өөрийн цор Ганц Хүүгээ өгсөн” (Иохан 3.16). Абрахамд амласан амлалт бол “Чамайг ерөөгчдийг Би ерөөж, чамайг хараагчийг Би хараана. Газар дэлхийн бүх овог чамаар ерөөгдөх болно” (Эхлэл 12:3). Иш Үзүүлэгчид Бурханы авралын төлөвлөгөө бол гадна байгсадыг хамруулах юм гэдгийг Еврейчүүдэд дахин дахин сануулж байсан (Иона 4:11) ба энд бүхэл дэлхийг хамруулсан төлөвлөгөө юм (Исаиа 45:22). Есүс өөрийн дэлхий дээр байхдаа хийсэн үйлчлэлийнхээ турш “тэр алдагдсаныг хайж аврахаар ирсэн” (Лук 19:10) дахин дахин баталж байсан.

Есүсийн тухай бид бүхний дуртай тодорхойлолт бол “гэмтний найз” юм (Матай 11:19). Энэ нь Бурханаас алслагдсан мэт мэдэрдэг нэгэний төлөөх Есүсийн энэрэнгүй зүрхийг илчилж байгаа юм. Бидний Эзэн тэдний аврагч байхыг таньж мэдэхээс өмнө гэмт хүмүүсийн ойрын найз байсан. Энэ хэргэм нь анхнаасаа урмын үг байхаар хэлэгдээгүй. Харинч Есүсийн ёс суртахуун буюу түүний теологод үл нийцэх шашинлаг хүмүүсийн доромжлол байсан юм.

Есүсийн цаг үеийн гол шашинлаг удирдагч нар бол Фарисайчууд байсан. Тэд Бурханы хуулийг хүмүүст заах ёстой хүмүүс байсан. Татвар хураагчид болон гэмтнүүдийг Фарисайчууд хүлээн авдаггүй байсан. Есүс эдгээр гадныхныг хүрээлүүлэх үед (Лук 15:1), тэдэнтэй харилцаа тогтоож бас гэрт нь хооллоход (Матай 9:9-13), харин шашныхан гомдоллосон “Энэ хүн нүгэлтнүүдийг хүлээн авч тэдэнтэй хамт хооллодог” (Лук 15:2). Есүс шашны хүмүүст анхаарал хандуулдаггүй байсан. Харинч Есүсийн хатуу зүйлсийг инэнхдээ тэдэнд хэлдэг байсан. Есүсийн хүсэл үргэлж гадна байгсдадын төлөө байдаг байсан.

Хэрэвээ та энэ номыг уншиж байгаа бол та ч мөн чуулганд нэгэн цагт гадных байсан байж таарна. Элч Паул ч бас гадных байсан. Бид бүгдээрээ л бас гадных байсан. Харин сайн мэдээ байна! “харин одоо Есүс Христ дотор та **нэгэн цагт алслагдсан байсан** (гадных), Есүсийн цусаар **бид ойртох болсон**….тэр **тусгаарлаж байсан**

Одоо та Бурханы хүмүүсээр Бурханы хөдөлгөөний хэсэг юм. Чуулганд тавтай морил!

тэр **саадыг нурааж**, Тэр алслагдсан байсан тэдэн рүү ирж амар тайвныг тунхагласан....Тийм болхоор, та дахиж гадны юмуу харийнхаан байлгүй харин Бурханы хүмүүстэй хамт журмын иргэд бас Бурханы гэр бүлийн гишүүн болсон….түүн дотор та Бурхан өөрийн Сүнсээрээ орших байхын тулд хамтдаа босгогдсон" (Ефес 2:13-22).

**Эргэн дурсах Асуулт – Оршил**

1. Библи болон Есүсийн амьдрал хоёрт суурьласан "Назар"-ын Чуулганы библи болон түүхэн үндэсний талаарх танд төрсөн сонирхол юу вэ?
2. Та урьд нь мэддэггүй байсан ямар нэгэн зүйлийг сурсан уу? Юу танд шинэ байсан бэ? Та сурсанаа хэнтэй хуваалцах вэ?
3. Христич хүний хувьд, та хэр их Бурханы дэлхий даяарх хөдөлгөөний тухай бас Есүс Өөрийн чуулганыг дэлхийгээр тархахад юу хийж байна гэж боддог вэ?
4. "Бурхан чуулганы төлөө зорилго байхгүй. Бурхан өөрийн зорилгын төлөө чуулгантай байдаг!" Та тунхагийн талаарх таны бодол? Та хүлээн зөвшөөрөх үү? Яагаад эсвэл яагаад үгүй?
5. "Есүс гадна байгсдын төлөө ирсэн." Бид хүмүүсийг хайрлах гэж бид ямарч хэл хэрэглэсэнч бас хүрэхийг хүссэнч хангалтгүй. Та хэрхэн итгэлд хараахан ирээгүй хүмүүст хүрэх Есүсийн зорилгыг тодорхойлох вэ?
6. Номонд нилээн тооны библийн тулгууруудыг Хуучин Гэрээн дэх Бурхан ба Шинэ Гэрээн дэх Есүс хоёрын гол анхаарал түүнээс болон түүний чуулганаас тусгаар бас гадна байгсдад хүрч байгааг харж болно. Та үүнтэй санал нэг байна уу? Яагаад?
7. Таны чуулганы чин зорилго "дотор байгсад" руу эсвэл "гадна байгсад" руу илүүтэйгээр анхаарал хандуулдаг уу? Та яагаад ингэж боддог вэ? Үүний тухай Есүс юу гэж бодож байгаа бол? Өөрчилж болох арга замын тухай хэлэлцээрэй.
8. Та энэ номыг уншиж эхлэх үед, Есүс танд шивнэсэн зүйл буюу таныг бодоосой гэж хүссэн зүйл байгаа болов уу? Тунгаан бодох? Та сурсан сүнслэг зүйлээ хэнтэй хуваалцах вэ?

# 6-Р НОМ –
# ХРИСТИЧ МОНГОЛ ЧУУЛГАН

# 1

# Гайхалтай Ирээдүйг Хамтдаа

“Тийнхүү надад тушаасан ёсоор нь би эш үзүүлсэнд амьсгал тэдэнд орж, тэд амьд болов. Үлэмжийн их цэрэг хөл дээрээ босоцгоов.” (Езекиел 37:10)

Бид ирж буй шинэ хөдөлгөөний цуурайг сонсож байна! Цуурай нь сүсэгтнүүдийн байнга хийж ирсэн “чуулганы үйл” биш. Бидний сонсох цуурай нь өөр бөмбөрийн цохилтыг сонсоод алхах алхалт байна. Тэд бол бүтээгчид, эрсдэлийг тооцсон, адал явдалын хүслэн болсон нэгэнүүд юм.

Тэдний ихэнх нь Бурханы хөдөлгөөнд ба Христич Монгол Чуулганд шинэ. Тэд дуудагдсанаа мэддэг, сүнслэг бэлэгтэй бас Бурханаар удирдуулсан. Тэд дунд чуулганы үйлчлэгчид болон ахлагч нар хамрагддаг. Тэд бол дэлхий нийтийн хөдөлгөөн дотор өсч байгаа хэсэг хүмүүс юм. Тэд бол дэлхий даяар тархсан 30,000 гаруй Назарын чуулганы зарц удирдагчидын хөдөлгөөн юм.

> Тэр бол чуулганы удирдагчидын хөдөлгөөн бөгөөд бидний дундаас Бурханы босгож байгаа өсөлтөнд өөрийгөө зориулагчид юм.

Энэ хөдөлгөөнд байгаа хүмүүс бол аль хэдийн чуулган дах гишүүдээс онцгой. Тэд суралцахад бэлэн, оюун санаагаараа өсөж бас өөрчлөгддөг. Тэд Христийн чуулганы удаан хугацааны эрүүл байдал болон өсөлтөнд юу чухал болохыг ойлгож эхэлсэн хүмүүс. Тэд Христич Монгол Чуулган бүр эрүүл байдал болон хэмжээнээс үл хамааран өсдөг чуулган байж чадна гэдэгт итгэдэг. Яг Есүс шиг, тэд гадна байгсдын төлөө зүрх сэтгэлтэй. Тэдний зарим нь Бурханы онцгойлон өгсөн Христийн Хаанчлал руу өсөлтийн онцгой чигэлсэн өвөрмөц хос сүнслэг бэлэг авьяастай байдаг. Тэд сайн мэдээний зүрх сэтгэл, чуулган тарилт, шинэ удирдагчдад зөвлөгч, шинэ газар нутагт үржих, шинэ чуулган байгуулах г.м-ийн төлөө байдаг. Тэдний бодол ба үйлс нь Христич Монгол Чуулганы хөдөлгөөнийг цэнэглэх соёлыг

Тэд Христич Монгол Чуулган бүр эрүүл байдал болон хэмжээнээс үл хамааран өсдөг чуулган байж чадна гэдэгт итгэдэг.

байгуулахад тусалдаг.

Хэдийнээ тогтсон байдал болон хэвийн чуулганы хэв маягт сэтгэл хангалуун биш, тэд элч Паулын зүрх сэтгэлдээ мэдэрсэн тэрл адил өдөөлтийг мэдэрдэг. “Иймхүү би өөр хүний суурин дээр барихгүйн тулд Христийн нэр дуурсагдаагүй газарт л сайнмэдээг дэлгэрүүлэхийг хичээсэн” (Ром 15:20). Тэд Хаанчлалын гадна байгсдад анхаарал тавьдаг. Тэд өөрийн чуулганаа гадна байгсдад анхаарал тавихыг ятгасаар байдаг, чуулганы дөрвөн хананаас (Матай 18:10-14) давж Христ рүү итгэлээр хараахан ирж амжаагүй хүмүүсийг хардаг. Тэд “үл итгэгчдэд гүн хайртай,” төөрсөн хүмүүс ба тэдэнд аврал хэрэгтэй гэдэгт итгэдэг.

Энэ хөдөлгөөний бас нэгэн чанар бол тэдний ажил ихэнхдээ үл мэдэгддэг гэдгийг ойлгодог. Сайн мэдээ Үйлс номонд гайхамшигтай дэвших үед, Еврей бус (Кипр болон Курений хүмүүс) Антиох руу очоод Грекчүүдэд Есүсийн тухай ярьсан (Үйлс 11:20). Маш олон хүмүүс Антиохоос анхны чуулган тарилтын удирдагчид Паул болон Барнабын тухай илгээгдсэнийг сонссон байсан (Үйлс 13:2-3). Гэвч хэн Антиох чуулганыг эхлүүлсэн бэ? Бид тэдний нэрийг мэддэггүй. Гэвч бид “Эзэний гар тэдэнтэй хамт байж Антиохд олон хүмүүс итгэсэнийг мэднэ,” тэгээд “Иерусалим илгээлтийн төв” Барнабыг юу болсон тухай мэдэхээр илгээдэг (Үйлс 11:21-22).

Өсөлтийн хөдөлгөөн болж байгаа газар үргэлж арын албанд ажилсан нэргүй хүмүүсийн үр дүн байдаг. Тэд өөрсдийн ажлынхаа төлөө үл танигдаж бас бага хүндлэл авдаг. Гэвч тэд Аврагчтай уулзахдаа тэд бидний Аврагч “Сайн байна, итгэмжит сайн зарц минь!” гэж хэлэхийг сонсоно (Матай 25:21,23). Тэдний хувьд энэ бол хангалттай яагаад гэвэл тэдний амьдралын алсын зорилго бол Бурханд алдрыг авчрах юм (Ром 5:2, 8:17).

Бид хүмүүстэй тодорхой цаг зарцуулсаныхаа дараа нэг нэгэнтэйгээ ярилцахдаа эсвэл уншсан номоо хамт хуваалцах үед тэдний бодлыг ойлгож удалгүй бид тэдний хандлагыг, тэдний сүнс болон тэдний зүрхийг олж мэддэг. Паул бидэнд зааварчлахдаа, “юуч хийсэн, Бурханы алдарын төлөө хий” (1 Коринт 10:31). Бурхан бүхнийг өөрийн алдрын харуулахаар бүтээсэн.

Есүсийн агуу хүсэл бол Бурханд алдрыг авчрах байсан. Есүс

үхэхийн өмнөх орой, тэр өөрийн Аавдаа залбирсан, "Хий гэж Надад өгсөн ажлыг тань гүйцэтгэн Би Таныг газар дээр алдаршуулав" (Иохан 17:4). Багын хувьд бидний тэмүүлэл бол адил зүйлийг хийх—Бурханы бидэнд өгсөн ажлыг гүйцэтгэх юм.

Чуулган доторх туйлын зорилго бол Бурханд алдрыг авчрах юм.

"Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл мөн. Биднийг эдгээрийн дотор яваасай гэж Бурхан урьдаас бэлтгэсэн билээ" (Ефес 2:10). "Эдүгээ, дотор маань ажилладаг хүчний дагуу гуйх буюу бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай **Түүнд алдар нь чуулган дотор**, бүх үеийнхэнд Христ Есүс дотор үеийн үед байх болтугай. Амен" (Ефес 3:20-21). Бид бидний чуулганы амьдралын туйлын зорилго бол Бурханд алдрыг авчрах гэдэгт итгэдэг.

Энэ ном бол хэрхэн Христич Монгол Чуулганы хөдөлгөөнийг илүү цэнэглэх тухай юм. Гадуур чуулганы теологи болон стратегын тухай олон ном байдаг. Бидэнд шинэ чуулганд зориулан болон байгаа цуглааныг дахин хэлбэржүүлэх г.м хийдэг програмчилсан сургалтууд байдаг. Бурханы хүмүүсээр дамжуулан Бурханы хөдөлгөөнийг цэнэглэх шинэлэг стратегийн илүү давуу арга замуудыг чуулганууд олж авсаар байна. Чуулганууд хамтрах үед бид чуулган удирдагчидыг сургах онцгой сургалтуудаар хангах боломжтой болж байна. Хэдийгээр энэхүү номын хүрээнд, бидэнд стратег болон сургалтаас илүү зүйл хэрэгтэй байгаа нь Христич Монгол Чуулганы хөдөлгөөний байнга цэнэглэхэд орших юм.

Хөдөлгөөнийг цэнэглэх **тэмүүлэл, эх сурвалж** хангагдахад бидний дунд зөв орчин бий болох болно.

Бидний Ариун Сүнс хамтад нь авчирсан гэдэгт итгэж байна. Бид санаа нэгтэй тэмүүлэлийг хуваалцдаг. Бид Есүсийн ярьсан сүнслэг нэгдэлд байрладаг (Иохан 17:21-23). Бид өсөлтийн хөдөлгөөнд чуулганы удирдагчид хамтдаа ойр ажиллах шаардлагатайг мэддэг. Хөдөлгөөнийг цэнэглэх **тэмүүлэл, эх сурвалж** хангагдахад бидний дунд **зөв орчин** бий болох болдог. Бидний хөдөлгөөн олон янзын хүмүүст хүрэхийн тулд олон янзын чуулганыг олон янзын газарт тарих зорилгийг эрмэлздэг. Бидний хөдөлгөөн чуулган БҮР хамрагдах

боломжтой! Энэ бол энэ номын өргөж байгаа зорилт юм.

Христич Монголчуудын хувьд, бид чуулганы тухай юу гэж итгэж байгаагаараа чуулган дотроо хэрхэн зан араншинг өвөрлөж явахад нөлөөлөх болно. Бидний хөдөлгөөн библилэг чуулганы ойлголтоор ажилладаг. Есүс чуулганыг хайрласан шиг бид мөн адил байхыг сонгодог (Ефес 5:25-27). Бид Бурханы өсөлтйн хөдөлгөөн тасралтгүй байх болно гэдгийг ойлгодог бөгөөд бид заавал өөрсдийнхөө чуулганы теолгийн ойлголт болон ойлголтоо тодорхой байлгах хэрэгтэй.

Бидний хөдөлгөөн олон янзын хүмүүст хүрэхийн тулд олон янзын чуулганыг олон янзын газарт тарих зорилгийг эрмэлздэг.

Түүний нэр дээр Чуулганууд гараа холбон түүний Хаанчлал өсөх үед Бурхан алдаршуулагддаг бөгөөд **түүний зорилго дэлхий дээр гайхамшигтай дэвшдэг**. Бурханы хүмүүс нэгдэл болон зөвшөлцсөн төлөвлөгөөнд санаа нэгдэхэд тэднийг зогсоохын аргагүй!

Чуулганы тухай бидний итгэл чуулган дотор гаргах зан араншинд нөлөөлөх болно.

Давид ингэж бичсэн, “Харагтун, ах дүүс хамтдаа нэгдмэлээр амьдрах нь Хичнээн сайхан, хичнээн тааламжтай вэ!” (Дуулал 133:1). “Учир нь тэнд ЭЗЭН ерөөлийг, Мөнх амийг тушаасан билээ” (Дуулал 133:3). Дэлхий даяар манай дүүргүүд болон чуулганууд зөвшөлцсөн төлөвлөгөө олж байна! Тэгвэл зөвшөлцсөн төлөвлөгөө гэж юу вэ? Хамтдаа тодорхойльё.

**Төлөвлөгөө**: “тодруулсан бөгөөд хийгдэх ёстой зүйлсийн төлөвлөгөө”

**Зөвшөлцсөн:** “адил төвлөрдөтэй хэсэгийн нэгдсэн зохион байгуулалт”

Энэ хоёрын хамтад нь холбоход, зөвшилцсөн төлөвлөгөө нь ижил хараа, ижил зорилго, ижил сүнсээр нутгийн Христич Монгол Чуулганы гишүүд эсвэл хэсэг чуулганууд хамтдаа ажиллах үед гарч ирдэг.

Элч Паул чуулган дах зөвшилцсөн төлөвлөгөөний чухалыг

мэдсэн тул ийнхүү бичжээ, "Тиймээс Христ дотор ямар нэгэн зоригжуулал, хайрын тайвшрал, Сүнсний нөхөрлөл, энэрэнгүй болоод өрөвч сэтгэл бий бол 2адил сэтгэж, адил хайртай байж, нэгдэн, нэгэн бодолтой байж, баярыг минь гүйцээ" (Филиппой 2:1-2). Чуулганд эдгээр дөрвөн шинж чанар байх нь юутай сайн бас гайхамшигтай байх бол. Эдгээр нь 1) нэг санаатай, 2) адил хайртай байхад, 3) нэг сүнсээр 4) нэг зорилго.

> Эзэн Өөрийн ерөөлөө нэгдмэл байдал болон зөвшилцсөн төлөвлөгөө байгаа газарт бэлэглэдэг.

Удирдагчдын баг байхад бид энэ бол зөвхөн Бурханы санаа эсвэл зөвөлгөө биш гэдэгт итгэдэг. "Учир нь тэнд ЭЗЭН ерөөлийг, Мөнх амийг тушаасан билээ" (Дуулал 133:3), **зөвхөн нэгдмэл байдал ба зөвшилцсөн төлөвлөгөө** байгаа тэр газар. Хүмүүс нэг сүнсэнд ба нэг хайранд байхад эмтэрсэн бөгөөд алдагдсан хүмүүс Бурхан руу ирэхийг харах болно. Энэ нь Христич Монгол Чуулганууд тэр бидний байлгах гэж хүссэн Христийн чуулган байх үед "тэд бүрэн төгс нэг болж, Намайг хайрласны адилаар тэднийг хайрласныг ертөнц мэдэх болно" (Иохан 17:23). Бид нэгдлийг нутгийн маягаар буюу стратегийн төлөө байхаар тэмцдэггүй, харин нэгдлийг Есүсийн хүсэл болон бидний харилцан хамааралын зориулалтаар дамжуулж хуваалцдаг.

Паул бүх чуулганы удирдагчид сануулсан "хайранд аливаа даруу дөлгөөн зангаар бие биенээ хүлцэн тэвчиж. амар тайвны холбоосонд Сүнсний нэгдлийг хадгалахыг хичээгтүн" (Ефес 4:2). Сүнсний нэгдэл бол нэгэн жигд байхыг хэлдэггүй. Бид нүд нүдээрээ байнга харахгүй байвч гар гараа барин явж чадна. Бид Христич Монгол Чуулганы хөдөлгөөнийг нутгийн болон харилцан хамааралтай байдалд суурьлан эрүүл бас өсөлттэй чуулганыг босгон ажилладаг. Бурханы чуулганы эрүүл байдал болон зорилго нь үргэлж нутгийн чуулганаас эхэлдэг. Мөн түүний хажуугаар, Есүсийн хараа нутгийн чуулганы хараанаас хамаагүй аугаа юм. Ертөнцийн авралд дэнчин болж байгаа зүйл бол – "Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай дэлхийн хязгаар" (Үйлс 1:8).

Есүс Христич хүн болгон аугаа захирамжыг өгсөн "явж **бүх үндэстнийг** дагалдагч болго" (Матай 28:19). Энд бидний хүрээлэн амьдарч буй хүмүүс болон дэлхийг хүрээлэн амьдарч буй хүмүүс хамтдаа хамрагддаг.

Назарын өсөлтийн хөдөлгөөн бол Бурханы хүмүүсээр дамжуулан хийх Бурханы хөдөлгөөн юм. Назарын Чуулганы эхлэлээс хойш одоо 160 гаруй улсад, 480 дүүрэгтэй, 41 талбарт, дэлхийн 6 бүс хүртэл тархсан. Олон янзын нэгдмэл байдал болон зөвшилцсөн төлөвлөгөөгөөр дамжуулан Назар дэлхий даяарх итгэгчидын нөхөрлөл болсон бөгөөд дэлхий даяарх мянга мянган хүмүүс итгэл болон ариун амьдрал руу хөтлөгдсөн. Бурханы энэхүү хөдөлгөөнийг цэнэглэгдэхэд дүүрэг дүүрэгтээ хамааралтай байгаа нутгийн чуулганы дунд зөвшилцсөн төлөвлөгөө байх шаардлагатай.

> Стратег хичнээн сайн байсанч, хэрэвээ бид зөвшилцсөн төлөвлөгөөг цэнэглэж байхгүй бол энэ хэзээч хийх гэж хүссэн шиг нөлөөтэй байхгүй.

Бид Христич Монгол Чуулганы төлөө дараах дөрвөн санаа энэ номны зорилго байхыг хүсч байна: 1) Бурхан гадна байгсдын төлөө анхаарал тавьдаг шинэ чуулганы удирдагчыг босгож байна. 2) Тэдний ихэнх ажил танигдахгүй байх болно. 3) Тэдний хэтийн зорилго бол Бурханд алдрыг өгөх юм. 4) Зөвшилцсөн төлөвлөгөө нь өсөж буй Христич Монгол Чуулганы хөдөлгөөний дээр Бурханы ерөөл үргэлжлүүлэн байх шаардлагатай.

Чуулганы өсөлтийн тухай хэлэлцэх болгонд энэ нь биднийг шууд стратегийн тухай хэлэлцэхэд хүргэдэг. Энэ ном нөлөөлөхүйц стратегийн тухай зарим нэг сургамжуудыг бид уншиж байхад хөндөх болно. Бидэнд шинэ чуулганыг эхлүүлэх болон одоо байгаа чуулганыг дахин хэлбэржүүлэх буурьтай стратеги хэрэгтэй. Гэвч бид стратеги нь хичнээн сайн байсан ч, хэрэвээ бид зөвшилцсөн төлөвлөгөөг цэнэглэж байхгүй бол энэ хэзээч хийх гэж хүссэн шиг нөлөөтэй байхгүй байхыг сурсан.

Чуулганы удирдагчид зөвшилцсөн төлөвлөгөө өөрийн болгох үед шинэ эрүүл чуулган, хэлбэржсэн чуулган ба Монгол чуулганы бүлэг бий болдог. **Зөвшилцсөн төлөвлөгөөг өөрийн болгоно гэдэг бүлэг чуулган бүр цөмлөлтийг мэдрэх болно**. Бид Есүсийн дагалдагчдад итгэлийн залбиралаар дамжуулан Пентакостын өдөр энэ зүйл болсон гэж итгэж байна. “Пентэкостын өдөр болоход тэд цөмөөрөө нэг газар цугласан байлаа” (Үйлс 2:1). Бид гайхамшигтай зөвшилцсөн төлөвлөгөө хэзээч стратегиар дамжуулан өвлөгдөхгүй

гэдэгт итгэдэг. Чуулган зөвхөн стратегид анхааралаа хандуулах үед хавчигдмал байдаг. Бид зөвшилцсөн төлөвлөгөө бичээсийн хүч чадлаар дамжуулан "Христийн бие Ариун Сүнсээр хамтдаа дуудагдсан" үед л өөрийн болгож чаддагийг сурсан.

> Аугаа зөвшилцсөн төлөвлөгөө хэзээч стратегиар бий болохгүй. Энэ нь зөвхөн бичээсийн хүчээр дамжуулан "Ариун Сүнсээр дуудагдсан Христийн бие"-ээр бий болдог.

Энэ номын зохиогчын хувьд бид ийнхүү тунхагладаг, "Бид Чуулганд итгэдэг, Есүс Христийг Эзэн гэж хүлээн зөвшөөрсөн хүмүүсийн нөхөрлөл… **Үгээр дамжуулан** Ариун Сүнсээр дуудагдсан Христийн Бие" (Итгэлийн Тунхаг, Гарын Авлага, 11-р параграф). Бид Ариун Сүнс л оршин тогтнох, нэгдсэн бөгөөд бие даасан чуулган байлгадаг гэж итгэдэг.

Бид чуулганы тухай библид үндэслэсэн ойлголтыг хуваалцах үед зөвшилцсөн төлөвлөгөө урган гардаг. Сүнслэг хүч болон сүнслэг үр дүн нь Ариун Сүнс бидний дунд Үгийг дахин сануулах үед гарч ирдэг (Иохан 1:1, 14, 14:26). Энэ бол стратеги биш харин бичээсийн хүч бөгөөд энэ нь удирдагчын уламжлалыг хэлбэржүүлж бас чуулганы дотор болон гаднах хоёуланд нь зөвшилцсөн төлөвлөгөө цэнэглэгдэхэд хүмүүсийн амьдрал өөрчлөгддөг.

Энэ ном бол сүнслэг хөдөлгөөний суурийн тухай юм. Бидний юунд итгэдэг нь бидний хэрхэн авирлахад нөлөөлдөг гэдэгт итгэдэг. Зохиогчын хувьд бидний залбирал бол та энэ номыг уншиж байхдаа Есүс шиг цоо шинэ, бас өөр өнцгөөр чуулганыг харж бас хайрлах юм. Есүс ер нь "түүний төлөө өөрийгөө өгсөн" (Ефес 5:25). Тэрч биднийг адил байгаасай гэж хүлээдэг. Бидний тэмүүлэл бол Бурхан хуудас бүрийг авч бас эдгээрийг Монгол чуулганы өсөлтийн төлөө хэрэглэх, "Юу гэвэл далай усаар дүүрэн байдгийн адил Дэлхий ЭЗЭНий яруу алдрын мэдлэгээр дүүрэх болно," (Хабаккук 2:14) мөн бас "Долоо дахь тэнгэрэлч бүрээдэхэд тэнгэрт "Ертөнцийн хаанчлал нь бидний Эзэний болон Түүний Христийнх

> Есүс ер нь "түүний төлөө өөрийгөө өгсөн" бас Тэр биднийг адил байгаасай гэж хүлээдэг.

болсон. Тэр үеийн үед хаанчилна” гэх чанга дуу гарлаа” (Илчлэлт 11:15). Бидний залбирал таньтай хамт байгаа шүү.

**Эргэн дурсах Асуулт – 1-р Бүлэг**

1. Та өөрийгөө суралцахад хэзээч бэлэн бас сэтгэл зүйн байдлаараа өсч бас өөрчлөгддөг бас энэ номонд яригдаж байгаа хөдөлгөөний хэсэг гэж мэдэрсэн үү? Та тийм байхыг хүсч байна уу? Яагаад эсвэл яагаад үгүй?
2. Та Христич Монгол чуулган бүр эрүүл бас хэмжээнээс үл хамраараан өсдөг гэж итгэдэг үү? Яагаад бас яагаад үгүй?
3. 3. Та “хамааралтай гэсэн” эсвэл “энгийн чуулганы хэв маяг”-т дуртай эсвэл та чуулганы зарим нэгэн зүйл нь өөрчлөгдөхийг харахыг хүсдэг хүн үү? Яагаад эсвэл яагаад үгүй?
4. Энэ номыг уншихаасаа өмнө одоогоор дэлхий даяар 480 гаруй дүүрэгтэй “Назарын хөдөлгөөн”-ий тухай хэр танил байсан бэ?
5. Та хувьд энэ хөдөлгөөний нэг хэсэг болоход танд ямар санагдаж байна? Таны хамрагддаг чуулган Христич Монгол Чуулганы хөдөлгөөнд хамааралтай байж бас илүү нөлөөтэй байж чадна гэж бодож байна уу? Яагаад эсвэл яагаад үгүй?
6. Энэ номыг уншихаасаа өмнө та “зөвшилцсөн төлөвлөгөө” хэллэгийн тухай сонсож байсан уу? Хэзээ?
7. Та урьд нь Дуулал 133:1,3 бас Филиппой 2:1-2 хоёрын цаана орших сүнслэг нууцын тухай гүн уншиж бас бясалгаж байсан уу? Нэгдмэл байдал болон зөвшилцсөн төлөвлөгөө хэрхэн Бурханы чуулган зогсоохын аргагүй болгох вэ? Та өөрийн бодлоо эсийн бүлэг, анги, эсвэл үеийнхэнтэйгээ хуваалцаарай.
8. Хэрвээ таны чуулганд хүн бүр зөвшилцсөн төлөвлөгөөний нөлөөг харвал чуулган тань хэр өөр хэлбэлээр хөдлөх бол? Юу өөр харагдах бол? Юу өөр байх бол? Ямар өөрчлөлт нь илүү байх бол? Зөвшилцсөн төлөвлөгөөгөөр байна гэдгийг хэрхэн мэдэх вэ?
9. Урьд дурьдагдсан “Аугаа зөвшилцсөн төлөвлөгөө хэзээч стратегиар бий болохгүй. Энэ нь зөвхөн бичээсийн хүчээр дамжуулан “Ариун
10. Сүнсээр дуудагдсан Христийн бие”-ээр бий болдог. “ Та энэ тунхагыг юу гэж бодож байна вэ? Та өөрийн бодлоо бүлэгтэйгээ хуваалцаарай.

11. Та “сүнслэг хөдөлгөөн”-ий хэсэг байж үзсэн үү? Та үүнийг боломжтой гэдэгт итгэж байна уу “Юу гэвэл далай усаар дүүрэн байдгийн адил Дэлхий ЭЗЭНий яруу алдрын мэдлэгээр дүүрэх болно.” (Хабаккук)?

# ХАМГИЙН АГУУ НЬ ХАЙР МӨН

"Би та нарт бие биеэ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн шинэ тушаал өгч байна. Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно гэж хэллээ."
(Иохан 13:34-35)

"Эдүгээ итгэл, найдвар хайр гурав үлддэг боловч хамгийн агуу нь хайр мөн. (1 Коринт 13:13).

Шинэ Гэрээний бараг тал хувийг бичсэн Саул (элч Паул), сүмд анхандаа гадны хүн байсан тэрээр 1 Коринт 13 дээр бичсэн зүйлээ сүнслэг аянаа эхлүүлэхдээ хэрэгжүүлэгүй юм. Саул эхэндээ Христэд итгэгчдийг улайран алдаг нэгэн байсан бөгөөд тэр Стефаны үхлийн гол нөлөөлөгч нь байлаа (Үйлс 7:58). Стефан нас барсны дараа Саул сүмийн эсрэг маш их хавчлага удирдан өрнүүлэв.

"Элч нараас бусад нь бүгд Иудей болон Самарийн нутгуудад тархав." (Үйлс 8:1). Лук бидэнд "Саул сүмийг хоосруулж. айлаас айлд орж эр, эм гэлгүй баривчлан, шоронд хийж байлаа."(Үйлс 8: 3) гэжээ. Дамаск явах замд, Саул Бурхантай бурханлаг оршихуйд уулзсанаар бүх зүйл өөрчлөгдсөн. Тэнгэрээс гэрэл гялсхийж, "Саул аа, Саул аа, юунд чи Намайг хавчина вэ? ...**Би бол** чиний хавчиж мөшгөөд байгаа Есүс байна" гэх дуу гарав. (Үйлс 9: 4-5).

> Бурханы Нүдэнд, би сүмийн эсрэг ямар нэг буруу зүйл хийвэл, би Есүст хийлээ гэсэн үг.

Бичээс бидэнд чуулган гэж юу болох талаар заадаг болохоор бид сүм чуулганд хандах хандлагадаа маш болгоомжтой байдаг. Дээрх догол мөрөнд нүдэнд тусахаар нэгэн холбоосыг анзаарав уу? Саул сүмийг хавчиж (Үйлс 8:3) сүмийг устгахыг хичээж байв. Үйлс 9-р бүлэгт, Есүс Саулыг зүгээр нэг бүлэг ядарсан хүмүүсийг хавчаагүй шүү гэдгийг сайн ойлгуусан. Тэрбээр амаараа муулан, үг хэл болон үйлдлээрээ хавчин, сүмийн талаар буруу хандлага гаргаж байсан, Саул нэгэн дууг: "Би бол чиний хавчиж мөшгөөд байгаа Есүс байна" сонсжээ.

Судар тодорхой зааж байна. Бурханы нүдэнд, сүмийн эсрэг

ямар нэгэн буруу зүйл хийвэл, би Есүст хийлээ гэсэн үг. Христэд итгэгчдийг улайран алдаг байсан хүн хожим нь

"Энэ нууц бол агуу билээ, харин Христ ба түүний чуулган нэг махан бие болсон" (Ефес 5: 30-31). Түүний хандлага ямар их өөрчлөгдөө вэ! Есүстэй уулзаад, Саул сүмд хандах хандлагаа эрс өөрчилжээ.

Тэр өдөр Дамаскийн зам дээр болсон явдал Саулд "сүмийн уламжлалын"2 талаар ухаарал ойлголтын шинэ аяллыг эхлүүлсэн. Есүстэй уулзахаас өмнө, тэр Есүсийг хэн болохыг мэддэггүй байв. Тэр Есүсийг, гадны хүмүүсийг ч, Өөрийн амиа өргөсөн сүмийг ч хайрладаггүй байв (Ефес 5:25). Тэрбээр дээд өрөөнд эхэлсэн хөдөлгөөнийг юу өдөөсөн болохыг хараахан ойлгоогүй байв. Есүс нас барахынхаа өмнөх шөнө шавь нартаа "Би та нарт шинэ тушаал өгч байна: Бие биеэ хайрлагтун. Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун. **"Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно гэж хэллээ"** (Иохан 13: 34-35). Саул хайраар удирдана гэж юу болохыг мэдэхгүй байв. Тэр хатуу ширүүн элч байсан. Хайр бол Саулын хувьд сурах ёстой зүйл байв. Бидний амьдралтай адил, энэ нь тодорхой хугацаа орсон нь эргэлзээгүй.

Хайр бол Саулын хувьд сурах ёстой зүйл байв. Бидний амьдралтай адил, энэ нь тодорхой цаг хугацаа орсон нь эргэлзээгүй.

Саул Есүстэй уулзсаны дараа, Есүсийг үхлээс амилсан, удаан хүлээсэн Мессиа гэдгийг мэдсэн. Тиймээс, нэгэнтээ улайран хавчиж байсан тэрээр бүр Иерусалимд хүртэл Есүсийн тухай нээлттэй мэтгэлцдэг, улайран номлодог нэгэн болжээ. Саулын ширүүн дориун арга нь иудейчүүдийг Христэд итгэгчдийг бүр илүү их алахыг хүсэхэд хүргэсэн (Үйлс 9:29). Энэ нь Иерусалим дахь сүмийнхэн Саулыг Тарсус дахь гэр рүү нь буцаахад хүргэсэн бөгөөд тэгэж байж сая нэг сүмд амар амгалан тогтов! (Үйлс 9:31)

Антиох руу явж, Грекчүүдэд Есүсийн тухай ярьсан еврей бус хүмүүсийн дунд сайн мэдээ хамгийн их дэлгэрч байсныг санаж байна уу? (Үйлс 11:20) Иерусалимын чуулган Антиоход хөдөлгөөн өрнөж байгааг сонссон тул энэ ажлыг удирдан явуулах хүнээр тэд Барнабыг итгэн явуулсан (Үйлс 11:22). Түүнийг "Ариун Сүнс, итгэлээр дүүрэн

очиход ... олон тооны хүн Эзэнд нэмэгдэв" (Үйлс 11:24). Барнаб Хаанчлал өсөх сүнслэг боломжуудыг олж харсан бөгөөд ганцаараа удирдаж чадахгүй гэдгээ мэдэж байв. Түүнд тусламж хэрэгтэй байсан.

Барнаб Саулд хүмүүсийн хараагүй далд авьяас байгааг олж харжээ (Үйлс 9:27). Тэр Саулын ярьж байхыг нь харсан бөгөөд Назарын хөдөлгөөний агуу удирдагч болох бололцоотой гэж боджээ. Тиймээс, Барнаб Тарсусд Саулыг хайж олоод, түүнд сүмийн нэг хэсэг гэж итгүүлэв. Зарим эрдэмтэд, Иерусалимын сүм Саулыг хэтэрхий "алсын хараа зөнтэй", сөргөлдөөнч араншинтай гэж үзээд найман жилийн турш сүмийн хяналт хараан дор байсан байж болох юм гэж үздэг (Үйлс 9: 29-30).

> Барнаб Саулыг Антиохт дагуулан ирж чуулганд хамруулж, түүний зөвлөгч нь болж, үйлчлэх боломж өгч түүнийг аварсан юм.

Барнаб Саулыг Антиохт дагуулан ирж чуулганд хамруулж, түүний зөвлөгч болж, үйлчлэх газрыг өгч түүнийг аварсан юм (Үйлс 11:25-26)

Барнаб, Саул нар анхны сайн мэдээний аянаа эхлэхэд (Үйлс 13: 2-3), Саул бодвол Сүнсний үр жимсийг хэрэгжүүлэхдээ болхи ширүүн хэвээр байсан байх (Галат 5: 22-23). Хайр нь түүний сургаалийн нэг хэсэг байсан ч хайр нь Саулын хамгийн том сэдэв нь байсангүй. Еврей нэрээ Ромын нэрээр (Паул) сольсон, Кипрт Паул Елумийг "диаволын хүү, аливаа зөвт байдлын дайсан" гэж дуудав (Үйлс 13:10). Писидийн Антиохт, ард олонд сургах зүйл байвал ярина уу гэж урихад (Үйлс 13: 14-15), Паул иудейчүүдийг "доромжилж, гайхаж, мөхөх ёсгүй" гэж ярьж, анхааруулав. Бүс нутгийн сайн мэдээний номлол амжилттай болоод (Үйлс 13:49), хэсэг хугацааны дараа Паулын Антиохт хийсэн сургаал "хавчлагыг өдөөж, тэд хөөгдсөн" (Үйлс 13:50). Икониумд "тэднийг айлган сүрдүүлж, чулуудахаар төлөвлөсөн байсан" (Үйлс 14:5). Листра хотод Паулыг чулуугаар шидэж, хотоос гарган хаяв (Үйлс 14:19). Иерусалимын зөвлөлийн дараа, Паул Маркын талаарх хандлагаас болж Барнабтай хурц санал зөрөлдсөний улмаас тэд бие биенээсээ салж явжээ (Үйлс 15:39). Сүүлд Паул Маркийн талаарх хандлагаа эрс өөрчилсөн гэдгээ илэрхийлсэн (2 Тимот 4:11).

Паулын анхандаа номлох арга нь ийм байлаа. " … тэр синагогт орж, амралтын өдөр олон удаа Еврейчүүдтэй судруудаас ярилцаж,

Мессиа зовж, үхлээс амилах ёстойг **тайлбарлаж, нотолдог** байв" (Үйлс 17:2-3). Паул анх номлож эхлэхэд түүний гол сэдэв буруу байсангүй. Сайн мэдээ, Есүс ба амилалтын тухай сайн мэдээ, Есүс бол амлагдсан Мессиа гэх мэт. Гэхдээ Паул өдөр бүр Есүстэй хамт явахдаа Паулын хандлага аажмаар өөрчлөгдсөн юм.

1Коринт 13 бүлэг нь Бурханы хүмүүсээр дамжуулан сүүлийн 2000 жилийн турш Бурханы хөдөлгөөнийг идэвхжүүлсэн.

Гурав дахь сайн мэдээний аяллаараа 55-иад оны үед, Паул суугаад эхэн үедээ мэдэлгүй өнгөрөөсөн сургаалиа захиа болгон бичжээ. Өнөөгийн чуулгануудын нэгэн адил Коринт чуулганы хэлэлцэх асуудал бол зохицол байв. Паул захидалдаа эхэлж хэлэхдээ, "Ах дүү нар аа, та бидний Эзэн Есүс Христийн нэрийн өмнөөс дахин уриалж байна. Та нар бүгдээрээ **бие биентэйгээ нэг санаатай бай**, тэгвэл та нарын дунд хуваагдал байхгүй, та нар оюун ухаан, бодлоороо төгс нэгдмэл байж чадна" (1 Коринт 1:10).

Паул Ариун Сүнс түүнд Өөрийнхөө талаар заахад нь яаж тусгаж хүлээж авч байгааг нь харж байна уу? Түүний номлох арга барил нь эхэндээ сөргөлдөөн, зөрчилдөөнөөр дүүрэн, иудейчүүд ба харь үндэстнүүдийг Христэд итгэгч болох ёстой гэж маргаж, нотлохыг хичээдэг байснаа хожим нь Паул Ариун Сүнснээс шинэ урам зоригийг олж авав.

Есүсийн хэлсэн "Ариун Сүнс та нарт **бүх зүйлийг** заах бөгөөд Миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно" (Иохан 14:26) амлалт үнэн байсан!

"Ефес дэх бичгийн ширээн дээр Паул Коринтчуудад сүнслэг бэлэгний талаар захидал бичихдээ "Би та нарт **илүү давуу замыг** харуулъя" (1 Коринт 12:31) гэж бичжээ. Дараахь үгс нь сүүлийн 2000 жилийн туршид Бурханы хүмүүсээр дамжуулан Бурханы хөдөлгөөнийг өдөөсөн.

"Хэрэв би хүмүүсийн болон тэнгэр элч нарын хэлээр ярьсан ч, надад хайр байхгүй бол би нүргэлэх харанга, хангинах цан болох байсан. Хэрэв би эш үзүүлэх чадвартай, мөн бүх нууцууд болон, бүх мэдлэгийг мэддэг байгаад, уулыг нүүлгэх бүрэн итгэлтэй байлаа ч, надад хайр байхгүй бол би юу ч биш. Хэрэв би өөрийн бүх л өмч хөрөнгөө тараан өгч, өөрийн биеийг шатаахаар тушаасан ч надад хайр

байхгүй бол энэ нь надад ямар ч ашиггүй юм.

"Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй, зохисгүй авирладаггүй, өөрийнхийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй, зөвт бус байдалд баярладаггүй, харин үнэнд баярладаг, бүгдийг далдалдаг, бүгдэд итгэдэг, бүгдэд найддаг, бүгдийг тэсвэрлэдэг. Хайр хэзээ ч дуусдаггүй. ... Эдүгээ итгэл, найдвар, хайр гурав үлддэг боловч хамгийн агуу нь хайр мөн. Гэхдээ эдгээрээс хамгийн агуу нь хайр мөн" (1 Коринт 13:1-8, 13).

Бурханд харилцаа нь амжилтаас илүү чухал.

Бидний хөдөлгөөнийг өдөөж буй үг юу вэ? Есүс хамгийн агуу тушаал бол "Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла" гэж **хэлсэн** (Матай 22: 37,39). Тэрээр хэлэхдээ, "Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно" гэж хэлсэн (Иохан 13:35). Энэ хөдөлгөөн эхэлсэн цагаас сүмийн хамгийн гол сургаал нь ариун хайрын тухай байсаар ирсэн. Энэ 1р Коринт 13-т Паул ариун хайр нь яагаад бидний гол сургаал болох талаар таван учир шалтгааныг өгүүлдэг.

Нэгдүгээрт, хайргүйгээр бидний хэлсэн бүхэн **үр дүнгүй** болно. "Хэрэв би хүмүүсийн болон тэнгэр элч нарын хэлээр ярьсан ч надад хайр байхгүй бол би нүргэлэх харанга, хангинах цан болох байсан" (1 Коринт 13: 1). Хайргүйгээр хэлэгдсэн үгс хоосон, тэд зүгээр л шуугиан болдог. Хайр байхгүй бол үгс юу ч биш, үр жимсгүй юм.

Хайргүйгээр бидний хэлсэн бүхэн үр дүнгүй бөгөөд бидний мэддэг бүхэн ч бүрэн биш байх болно.

Коринтчууд хэлээр ярьдаг болоод - тэд сүнслэг уран яруу хэлээрээ Бахархаж "Бид хүн ба тэнгэр элчүүдийн хэлээр ярьж чаддаг" гэв. Гэтэл Паул "Та нар жаахан юман дээр анхаараад байна, учир нь хэлээр ярих нь хайртай харьцуулашгүй." Хайр байхгүй бол бидний хэлсэн бүхэн үр дүнгүй.

Хоёрт, хайр байхгүй бол бидний **мэддэг** бүхэн **бүрэн бүтэн**

**биш**. “Хэрэв би эш үзүүлэх чадвартай, мөн бүх нууцууд болон бүх мэдлэгийг мэддэг байгаад … надад хайр байхгүй бол би юу ч биш” (1 Коринт 13:2). Бид коллежийн, магистрын, докторын зэрэгтэй байсан ч, бид Библийн суутан байгаад, хэдэн зуун Библийн ишлэл цээжилж, иш татаж чадах байлаа ч энэ бүхэн хайртай харьцуулахад хамаагүй гэж Бурхан хэлж байна. “Мэдлэг ихэрхэг болгодог, харин хайр сургамжилдаг аж” (1 Коринт 8:1). Хайр байхгүй бол бидний мэддэг бүхэн хангалтгүй.

Гуравт, хайр байхгүй бол бидний бүх итгэл хангалтгүй. “Хэрэв би уулыг нүүлгэх бүрэн итгэлтэй байлаа ч, надад хайр байхгүй бол би юу ч биш” (1 Коринт 13:2). Хэрэв хайр байхгүй бол бидний итгэл хэр хүчтэй байх нь хамаагүй. “Хайраар дамжуулан ажиллаж буй итгэл л чухал юм. “(Галат 5: 6). Паул хэлэхдээ итгэл чухал боловч хайргүйгээр бидний бүх итгэл хангалттай биш юм.

> Хайргүйгээр бидний итгэл хангалтгүй бөгөөд бидний өгдөг бүх зүйл ач холбогдолгүй юм.

Дөрөвт, хайр байхгүй бол бидний **өгдөг** бүх зүйл ач холбогдолгүй юм. “Хэрэв би байгаа бүхнээ ядууст өсөн ч ... надад хайр байхгүй бол надад ямар ч ашиггүй юм” (1 Коринт 13: 3). Бид байгаа бүхнээ өгч болно, зөвхөн аравны нэг биш, түүнээс ч илүүгээр. Хүмүүс янз янзын шалтгаанаар өгдөг. Дэлхий дээр зарим нь нэр хүнд, алдар нэр, эрх мэдэл, засгийн газарт нөлөөлөх зорилгоор өгдөг. Бид өгч байгаа нь заавал хайртай гэсэн үг биш юм. Бид хайргүйгээр өгөх боломжтой ч, өгөхгүйгээр хайрлах боломжгүй. Хайр байхгүй бол бидний өгдөг бүх зүйл **ач холбогдолгүй** юм.

Тавд, хайр байхгүй бол бид бидний **хийж бүтээсэн бүхэн хангалтгүй** юм. “Хэрэв би өөрийн биеийг шатаахаар тушаасан ч надад хайр байхгүй бол энэ нь надад ямар ч ашиггүй юм. (1 Коринт 13:3). Бид гайхалтай амжилтуудын жагсаалтыг гаргаж, асар их амжилтыг ухаарч, агуу байгууллагуудыг байгуулж, дэлхийн хамгийн том зүйлийн төлөө амиа золиосолж чадах ч, бид хайрын сүнсийг хөгжүүлж, төлөвшүүлэхгүй л бол бид амьдралын хамгийн чухал зүйлийг гээх болно. Паулын гаргаж буй гол санаа нь Бурханд, харилцаа нь ололт амжилтаас илүү чухал зүйл юм.

Бид хэл ярианы уран чадварт сураад, суут ухаантны мэдлэгтэй

болоод, гайхамшгийг хийдэг ажилчны итгэлтэй байгаад, филантроп хүний өгөөмөр сэтгэлтэй байж, амиа өргөгчийн зориулах сэтгэлтэй байж чадна, гэхдээ биднийг мэддэг, хамт амьдардаг бөгөөд хамт ажилладаг хүмүүстээ Христ адил хайрлах хайраа тууштай үзүүлж дадал болгох нь биднийг Христ адил дагалдагч гэдгийг харуулдаг.

Есүс биднийг хайрладаг шиг бусдыг хайрлах нь. Амьдралд хайраас илүү чухал зүйл гэж байдаггүй.

Бурхан бол хайр. Иохан "Бурханд хайр бий" гэж хэлээгүй. Иохан "Бурхан бол хайр" гэж хэлжээ (1 Иохан 4:16). Түүний оршихуйд бид хайрыг мэдэрдэг. Энэ хайр үүрд мөнх үргэлжлэх болно! Христ адил хайр, Бурханы төгс хайр нь Ариун Сүнсээр дамжуулан бидний зүрхэнд цутгагдсан байдаг (Ром 5: 5). Түүний төгс хайраар дүүргэгдсэн зүрхтэй болж чадах нь бидний хөдөлгөөнийг хөдөлгөх хүч болдог байна.

> Энэ бол бидний хөдөлгөөний гол санаа юм. Бурханы хайр бидний зүрх сэтгэлийг бүрэн дүүргэж чадна. Энэ бол биднийг хөдөлгөх хүч - Бурханы хайранд дадлагажих юм.

"Эрхэм найз нар аа, Бурхан биднийг ийнхүү хайрласан бол бид ч бие биеэ хайрлах ёстой. Хэн ч, хэзээ ч, Бурханыг хараагүй. Хэрэв бид бие биеэ хайрлавал Бурхан бидний дотор байж, Түүний хайр бидний дотор бүрэн төгс болно ... биднийг зоригтой байлгахын тулд бид энэ ертөнцөд Түүн шиг байдаг "(1 Иохан 4:11-12,18). Энэ бол бидний хөдөлгөөний гол санаа юм. Бурхны хайр бидний зүрх сэтгэлийг бүрэн дүүргэж чадна! (Марк 12: 28-31) Энэ бол биднийг хөдөлгөх хүч болох - Бурханы хайранд дадлагажих юм. Бид хайраар удирддаг.

**Эргэцүүлэх асуултууд. 2-р бүлэг**

1. Та яагаад Саулыг тийм улайрсан алуурчин байсан гэж та бодож байна? Түүний - гарал үндэс, зан чанар, итгэл үнэмшил, шүтлэгийнх нь бэлтгэл байвуу эсвэл энэ бүгдийн нэгдэл түүнийг тэгэж их улайруулав гэж та бодож байна?
2. Саул сүмийг хавчиж, сүмийг устгахыг оролдож байв. Гэвч тэнгэрээс дуу чимээ гарч түүнд "Би чиний хавчиж мөшгөөд байгаа Есүс байна." Энэ нь бидний мэдэх төгс биш, биет "сүм" болон Есүс

хоёрын хоорондох холбоосын талаар юу өгүүлнэ вэ? Энэ чиний хувьд шинэ бодол мөн үү? Бүлгээрээ санал бодлоо хуваалцаарай.

3. Өнөөдөр яагаад ихэнх хүмүүст сүмээ хайрлахаас илүү Есүсийг хайрлах нь илүү хялбар болсон гэж та бодож байна? Есүс энэ хоёрын хооронд ялгаа бий гэж хэлсэн үү? Сүмийн талаар бидний хандлага ямар байх ёстой вэ?
4. Паулын сүнслэг хөгжилд Барнабын ямар зан чанар гүн гүнзгий нөлөөлсөн бэ?
5. Энэ бүлгийг уншаад Паулын талаар урьд нь мэдээгүй байсан ямар нэгэн сурсан зүйл байсан уу? Хэрэв тийм бол үүнийг хамт олон, бүлэг эсвэл ангийнхаа хэн нэгэнтэй хуваалцаарай.
6. Есүстэй хамт алхаж, ярилцаж цаг хугацааг өнгөрөөсөн нь элч Паулын хандлагыг болон сургаалыг хэрхэн өөрчилсөн бэ? Та өөрийн амьдралдаа иймэрхүү аяллыг ямар нэгэн байдлаар таньж олж харж чадаж байна уу? Яагаад, яагаад үгүй гэж?
7. Номын зохиогчид яагаад ариун хайр бол бидний гол сургаал болох талаар таван шалтгааныг өгүүлсэн. Эдгээр таваас аль нь таны амьдрал, сэтгэлгээнд хамгийн их нөлөөлсөн бэ? Яаж?
8. Зохиогчид “Христ адил хайрыг биднийг мэддэг, бидэнтэй хамт амьдардаг хүмүүстээ тууштай үзүүлж дадал болгох нь биднийг Христ адил дагалдагч гэдгийг харуулдаг гэсэн. Есүс биднийг хайрладаг шиг бусад хүмүүсийг хайрладаг. Хайраас илүү чухал зүйл гэж амьдралд байхгүй!” Энэ мэдэгдэл танд ямар сэтгэгдэл төрүүлсэн вэ? Та үүнтэй санал нэг байна уу? Яагаад, яагаад үгүй гэж?
9. Зохиогчид “Бурханы төгс хайр Ариун Сүнсээр дамжуулан бидний зүрх сэтгэлд цутгаж дүүргэдэг бөгөөд энэ хайр бидний хөдөлгөөнийг хөдөлгөх хүч болдог.” Та энэ мэдэгдэлд санал нийлж байна уу? Яагаад, яагаад үгүй гэж?
10. Та болон танай сүм хэрхэн Бурханы хайрыг илүү сайн хэрэгжүүлж чадах вэ? Ариун Сүнс танд өөрчлөх эсвэл өөрөөр хийх хэрэгтэй гэж шивнэж байгаа юм юу байна? Хэрэв тийм бол үүнийг хамт олон, бүлэг эсвэл ангийнхаа гишүүдтэй зоригтой хуваалцаарай.

# Гадны Хүмүүст Анхаарал Төвлөрүүлсэн Хөдөлгөөн

"Леви Есүст зориулж гэртээ том зоог барив. Тэнд олон татвар хураагчид болон өөр хүмүүс тэдэнтэй хамт ширээнд тухлан сууж байжээ. Фарисайчууд, мөн тэдний хуулийн багш нар "Та нар чинь яагаад татвар хураагчид болон нүгэлтнүүдийн хамт идэж, ууж байдаг билээ? гэж Түүний шавь нарт дургүйцэн хэлэхэд Есүс тэдэнд "**Эрүүл хүмүүст бус өвчтэй хүмүүст** эмч хэрэгтэй. Би зөвт хүнийг бус, харин нүгэлтнүүдийг гэмшилд дуудахаар ирсэн юм гэв. (Лук 5:29-32).

**Дагалдагч бэлтгэх нь нигүүлслийн аялал юм.** Христэч эцэг эхийн үйлддэгийн адил, зориудаар дагалдагч бэлтгэх нь итгэлээ өгөхөөс эхэлдэггүй, анхны мэдэгдэхүүнээс эхэлдэг. Хүн Христэд итгэхийн өмнө **тааламжит нигүүлсэл** тэднийг татаж эхэлдэг. **Авралын нигүүлсэл** нь сүмийн нөхөрлөл дунд Есүсийн хамт ивээлээр дүүрэн аялалд хүргэдэг. **Ариусгалын нигүүлсэл** нь хүн Есүсийн төлөвлөгөөг бүрэн дагаж, амьдралаараа Бурханы хүсэлд бүрэн ариуссан байх Бурханлаг мөч, үйл явц юм. **Нигүүлсэл доторх өсөлт** нь Есүстэй нүүр тулан уулзтал үргэлжлэх болно.

Дагалдагч бэлтгэх нь итгэлээ өгөхөөс эхэлдэггүй, анхны мэдэгдэхүүнээс эхэлдэг. Хүн Христэд итгэхийн өмнө, тааламжит нигүүлсэл тэднийг татаж эхэлдэг.

Есүсийн хамтаар дагалдагч бэлтгэх аялал нь нигүүлслээр дүүрэн байдаг! Энэ аялал нь итгэлээ өгөхөөс эхлэхгүй, харин аль эртнээс эхэлсэн байдаг! Паул "Македоноос хүн ирнэ" гэж үзэгдэл үзэхэд (Үйлс 16:10), Бурхан сүмийн ажил үйлчлэлийг эр хүн төвтэй байхыг хэзээ ч төлөвлөгөөгүй. Бурханы анхны итгэлээ өгсөн хүн бол Лидия хэмээх эмэгтэй байсан бөгөөд "Их Эзэн Паулын захиаг сонсоод зүрх сэтгэлээ нээсэн" (Үйлс 16:14). Паул Македоноос ирэх хүний тухай үзэгдэл үзэхээс өмнө Лидиягийн нигүүлсэлийн аялал хэдийнээ эхэлсэн байв!

Бичээсийн турш бид нигүүлсэлийн аяны тухай Бурханы төлөвлөгөөг олж мэдэх боломжтой. "Учир нь бүх хүмүүст авралыг авчрагч Бурханы нигүүлсэл үзэгдэн" (Тит 2:11). Нигүүлсэл (харис) гэдэг үг нь Лук, Иохан, Үйлс, Петрийн бичээсүүдэд, болон Паулын бичээсүүдэд 100 удаа гардаг. Нигүүлсэлийн тухай лавлагаанаас гадна Библи дээр "Бурханд тааламжтай" ба "хүмүүст тааламжтай" гэсэн хоёуланг нь дурдсан 158 ишлэл байдаг. Нигүүлсэл нь хүн бүрийн амьдрал дахь үйл хөдлөл дэх Бурханы хайр ба хүч юм. "Бурхан биднийг өөрийн ёс суртахуунтайгаа холбож өгөхийн тулд биднийг нигүүлсэнгүй хардаг…Нигүүлсэл нь биднийг өөрчлөх зорилготой юм; энэ нь биднийг хаа байгаа газар үлдээхгүй."

Есүс энэхүү нигүүлслийн аяндаа өөртөө татсан хэдэн арван мянган хүмүүсийн зөвхөн түүхийн нэгийг энд яръя. Төв Чикаго нь жил бүрийн нэгдсэн цуглаанд цуглардаг дэлхийн өнцөг булан бүрээс ирдэг 480 гаруй дүүргийн нэг юм. Ихэнх дүүргүүдийн нэгэн адил тэд, итгэлээ өгөх, баптисм, шинэ гишүүд, тэдгээрийн гишүүнчлэл, шүтлэг зэрэг нийтлэг зүйлүүдэд анхаарлаа төвлөрүүлдэг бөгөөд жил бүр энэ **нигүүлслийн аянаа** эхлүүлсэн 800-1,000 хүнийг тэмдэглэх нь ховор тохиолдол биш юм. 80 гаруй сүмүүд гадны хүмүүст анхаарлаа төвлөрүүлж жил бүр хэдэн зуун хүмүүс нигүүлсэлийн аянаа эхэлж, баптисм хүртдэг.

Дүүргийн Тэргүүлэгч Ларри МакКейн чуулгандаа шинэ итгэгчдийн нэгтэй хувийн дотно харилцаатай байдаг тул өөрийн түүхэ дүүргийнхээ нэгдсэн цуглаан дээр түүхээ сүмийн гадна байсан хүний үзэл бодлоор хуваалцахыг хүсэв. Түүнийг Тамми Селви гэдэг. Тэр Иллинойс мужийн Брэдли дэх Бейкерс талбайн ресторанд үйлчлэгч юм. Тэд хамгийн түрүүнд Зөвлөлдөх зөвлөлийн дарга Барри Хуэбнер, Ларри нар өглөөний цай уухаар уулзсан. Тэд үргэлж нэг ширээнд суудаг байсан, тэр ихэвчлэн тэдний зөөгч нь байсан. Тамми цуглаанд иинхүү ярьсан юм.

> Би 5-р ангид байхдаа сүмд автобусаар нэг жил явснаас бусдаар хүүхэд байхдаа сүмд хэзээ ч явдаггүй байсан.

"Миний нэр Тэмми Селвэй, би шинэ итгэгч байна. Би хүүхэд байхдаа Баптист сүмд 5-р ангидаа явснаас бусдаар хүүхэд байхдаа сүмд хэзээ ч явдаггүй байсан. Бид сүмийн автобусаар явдаг байлаа.

Тэд ирж биднийг авдаг байсан. Миний эцэг эх салсан, аав маань христчин байгаагүй. Тэр хойд ээжтэй хамт байх гэж л биднийг ням гарагийн өглөө явуулдаг байсан. Тэр нь нэг жил орчим үргэлжилсэн.

Би арван жилдээ Бурханы юмуу сүмийн амьдрал үзсэнгүй. Глен бид хоёр 21 настай байхдаа гэрлэсэн. Тэр сүмийн суурь хүмүүжилтэй байлаа; өвөө, эмээтэйгээ хамт сүмд хамрагддаг. Манайх дөрвөн хүүхэдтэй, гурван охин, нэг хүүтэй. Амьдрал бүрэн дүүрэн байлаа. Ням гарагт би байнга ажиллаж Глен хүүхдүүд хардаг байсан тул Бурхан болон Ням гарагийн сүм бидний хуваарьтай таарахгүй байв.

Манай хүү Жастин ахлах сургуульд ороход амьдрал үнэхээр хэцүү болсон. Архи согтууруулах ундаа нь түүний амьдралыг сүйтгэж байсан. Тэр хулгай хийж хар тамхи хэрэглэж байсан. Манай гэр бүл сүйрч байв. Гурван охин түүний эргэн тойронд байхыг хүсэхгүй байсан тул түүний муу нөлөө, сонголтоос болж тэрэнтэй ярихаа больсон байлаа.

Энэ бүхэн миний амьдралд тохиолдож байхад би үргэлжлүүлэн ажилласаар байв. Би дотороо хөл толгой нь олдохгүй эмх замбараагүй байсан ч үүнийгээ харуулахгүй байлаа. Пастор Ларри ба Барри хоёр ирж ямар байгааг минь асуухад би өөрийгөө нээж сэтгэлээ уудалсан. Тэд миний төлөө тэр ресторанд шууд залбирсан. Энэ миний сэтгэлд их хүрсэн. Христэч хүн бүр гадна байгаа хүмүүстэй үргэлж холбоо барьж байх ёстой гэж би боддог. Тэд хийсэн болохоор миний амьдрал өөрчлөгдсөн. Хүмүүс ямар байгааг бид асууж байх ёстой. Энэ асуулт намайг тухгүй болгоогүй. Надад ярилцах хүн хэрэгтэй байсан тул энэ нь надад сэтгэлийн дэмжлэг өгсөн. Манай гэр бүлд тусламж хэрэгтэй байсан.

Жастин орон гэргүй хүн болсон. Тэр эцэст нь бидэнтэй хамт амьдрахаар гудамжнаас буцаж ирээд тусламж авахаар тохирсон тул би түүнийг Бурбоннаис дахь Цуглах цэг сүм дээр Эдгэрэлтийг тэмдэглэх арга хэмжээнд аваачдаг болов. Олон хоног Жастиныг сүм рүү хүргэж өгсөн ч би орохгүй байлаа. Би айж байсан. Гэхдээ би Жастиний амьдралыг, миний хүүгийн хийж байсан зүйлсийг харж байсан, тэр өөр хүн болсон. Миний өмнө яаж өөрчлөгдөхийг нь харсан!

Би хэнийг ч танихгүй тул би их сандарч байсан. Гэхдээ би эцэст нь "Би орж, юу болж байгааг харах хэрэгтэй." гэж бодсон. Тиймээс би зориг ороод сүм рүү орсон. Энэ миний бодож байснаас өөр байлаа. Би цуглааны туршид уйлаад л суугаад байсан. Харин одоо би цуглаан

дуустал уйлахгүй байж чаддаг болсон. Би ням гараг ажлаасаа чөлөө авч сүмд явдаг болсон. Энэ нь миний хувьд анхны тохиолдол байлаа! Одоо би сүмд явах дуртай. Дуунууд нь надтай холбоотой юм шиг санагддаг. Бурханы талаар мэдэх нь миний хувьд цоо шинэ зүйл юм. Пастор Пол Жонсоны ярьж байгаа нь, үргэлж надад ярьдаг юм шиг санагддаг.

Зөвхөн Жастиний өөрчлөлтийг үзээд зогсохгүй, хэрэв Бурхан Жастиныг уучилж байгаа юм чинь намайг уучилж чадах юм байна гэж би бодож эхэлсэн. Түүнчлэн, Жастин сүмд очиж, Эдгэрэлтийг тэмдэглэх үеэр хэн ч түүнийг шүүхгүй байгааг би анзаарсан. Тэд түүнийг үнэхээр сайхан хүлээж авсан. Би ч бас үүнийг хүсч байсан.

Чуулган манай гэр бүлийг хамтад нь нэгтгэсэн. Би чуулганд хамрагддаг Расселл МакДауэллтэй хамт ажилладаг. Тэрээр Жастины ивээн тэтгэгч нь болжээ. Бид Жастинд олон удаа туслахыг хичээсэн боловч өөрсдөө хийж чадахгүй байсан. Чуулган манай хүүг дахин эрүүл болоход тусалсан. Жастин гэрчлэлээ хуваалцаж баптизм хүртсэн өдрийг би хэзээ ч мартахгүй.

> Христэд итгэгч бүр гадны хүмүүст хүрээсэй гэж би боддог. Тэд тэгснээр миний амьдрал өөрчлөгдсөн.

Би одоо хүүгээ буцааж авсан болохоор сүмд маш их талархаж байна! Тэр дахин манай гэр бүлийн нэг хэсэг болсон. Пастор Ларри, Барри нар миний төлөө залбирсанд талархлаа хэлмээр байна. Би гэр бүлийн минь төлөө санаа тавьдаг Расс болон сүмийнхнийхөө төлөө Бурханд талархахыг хүсч байна. Мөн та бүхэндээ, над шиг гадны хүмүүст хүрч үйлчилдэг сүм болгонд, талархаж байна.

Би Библийн талаар сайн мэддэггүй. Гэхдээ би энэ үгийг хараад Пастор Ларри руу мессежээр илгээв. “Та сударыг хэр мэддэгээр биш, хэр судараар амьдарч байгаа чинь юм.” Би сүм дээр баптисм хүртсэн бөгөөд Есүс миний амьдралд гаргасан өөрчлөлтийн талаар олон нийтэд гэрчлэхэд маш их баяртай байдаг. Анхаарал халамж тавьдаг та бүхэндээ баярлалаа!”

Таны түүх Тэммигийн түүхтэй адил төстэй байвал сүмд тавтай морилно уу. Манай сүм таны хамт байхаар бүтээгдсэн юм шүү. Таныг анх сүмд ирэхэд, бидний дунд анх удаа ирсэн зочид байгааг хүлээн аваагүй бол уучлал гуйж байна. Бид тантай ярихдаа тайлбарлаагүй

байж ойлгомжгүй нэр томъёо хэрэглэсэн бол, эсвэл таныг хэдэн жилийн турш сүмд явсан хүн шиг ойлгоно гэж бид санаандгүй хийдэг үйлдэлдээ харамсаж байна. Бидний хүсч буй зүйл бол гадны хүмүүст анхаарлаа төвлөрүүлсэн, нигүүлсэлийн аялалаар яваа хүмүүсээр дүүрэн сүм байх явдал юм.

> Та судрыг хэр их мэддэгээр биш, хэр их судраар амьдарч байгаа чинь юм.

"Хамтдаа. Том Райнер сүмүүд сайн мэдээг тунхаглахгүй байх, гадны хүмүүст анхаарлаа төвлөрүүлэхгүй байх үндсэн шалтгааныг тодруулсан. буруу хандлага, итгэл үнэмшил, зан төлөвт зохион байгуулагдсан.

## Алдаатай Хандлага

1. Зарим Христэд итгэгчид сүнслэг байдлын хувьд алдагдсан хүмүүст яаралтай хандах мэдрэмжгүй байдаг
2. Христэд итгэгчид болон сүмийн зарим гишүүд үл тоомсорлосон хандлагатай байдаг.
3. Зарим сүмийн гишүүд гаднах хүмүүстэй харьцахаас илүүтэйгээр "өөрийн хэрэгцээг хангахад" илүү их анхаардаг.

## Алдаатай Итгэл Үнэмшил

1. Зарим сүмүүд юуны төлөө гэхээс илүү өөрсдийн эсрэг байгаа зүйлдээ илүүтэй анхаарлаа төвлөрүүлдэг итгэл үнэмшилтэй байдаг
2. Зарим сүмүүд Христэд итгэгчдийг "бид явна" гэж заахаас илүүтэйгээр "та ирээрэй" гэсэн үр дүн муутай стратеги ашигладаг.
3. Зарим сүмийн гишүүд сайн мэдээг зөвхөн пастор ба цалинтай сүмийн ажилтнуудын үүрэг гэж буруугаар итгэдэг
4. Зарим сүмийн гишүүд Христ бол авралын цорын ганц зам гэдэгт итгэхээ больсон.
5. Зарим Христэд итгэгчид бусад хүмүүсийг гомдоохгүйн тулд сайн мэдээний үнэнд итгэхээ больж хуваалцахаа больсон. Хэт олон газарт улс төрийн асуудлаар партизан үзэл бодол сайн мэдээг орлож байна.

## Алдаатай зан байдал

1. Зарим сүмүүд алдагдсан хүмүүст хүрэх “залбирлын өргөө” байхаа больсон байдаг.
2. Зарим христэд итгэгчид ба сүмийн гишүүд, гадны хүмүүстэй найзалж хамт цагийг өнгөрөөдөггүй.
3. Сүмийн соёл улам библийн дагуу биш, дэлхийн шинжтэй болох хэрээр зарим гишүүд “хойш сууж” эхэлдэг.
4. Зарим сүмүүд маш олон үйл ажиллагаа явуулдаг болохоор сайн мэдээ тунхаглах, гадны хүмүүсээ эн тэргүүнд тавих завгүй байдаг.5.

Сайн мэдээг дэлгэрүүлэх, гадны хүмүүст хүрч харж хандах нь Монголын Христийн сүмүүдийн үндсэн чиг байгаад нь би хувьдаа их талархалтай байдаг. Дэлхий даяар эрүүл, өсч, үржиж буй сүмүүдийг судалж үзэхэд эдгээр нь **“онцлох зүйлгүйгээр**” гадны хүмүүст анхаарлаа төвлөрүүлдэг сүмүүд юм. Тэд бол төвөгтэй сүмүүд биш юм. Тэдэнд хөгжин цэцэглэхэд хүргэдэг нийтлэг шинж чанарууд байдаг бөгөөд тэдгээр нь 1) өндөр хүлээлт, 2) сүнслэг бодит байдлыг ойлгох, 3) зочломтгой, 4) зочидтой найрсаг байх, 5) гадны хүмүүсийг хайрлах тэмүүлэл.

> Бид дэлхий даяар эрүүл, өсч, үржиж буй сүмүүдийг судалж үзэхэд эдгээр нь гадны хүмүүст анхаарлаа төвлөрүүлдэг сүмүүд юм.

Нэгдүгээрт, эдгээр нь **өндөр хүлээлттэй** сүмүүд юм. Эдгээр гадны хүмүүст анхаардаг сүмүүд нь Бурхан биднийг Хаанчлалдаа агуу их хөрөнгө оруулалт хийхээр дууддаг гэж итгэдэг. Эдгээр сүмүүд нь хүн бүрийн зүрх сэтгэлийн гүнд нь Бурханы тааламжтай нигүүлсэл байдаг бөгөөд тэднийг татаж, тэдний дотор Бурханы төлөө агуу их амьдрах хүсэл эрмэлзлийг бий болгодог гэдэгт итгэдэг. Есүсийн нүдээр, хүн бүрт янз бүрийн авъяас чадвар байгаа бөгөөд эдгээр нь агуу болох чадварыг өгдөг. Эдгээр сүмүүд хүн бүр сайхан амьдрахыг хүсдэг гэдэгт итгэдэг. Шөнийн цагаар хэн ч сэрээд дундаж өнгөрүүлсэн амьдралдаа хэн нэгнийг урамшуулж, босгон байгуулаагүй амьдралыг мөрөөдөж хэвтэхгүй. Би төвтэй амьдралаар хэн ч амьдрахыг хүсэхгүй. Үүний урт хугацааны үр дүн бол зовлон зүдүүр юм. Гадны хүмүүст анхаарлаа төвлөрүүлдэг сүмүүд хүн нэг бүрийг Бурхан дундажаас

илүүгээр бүтээсэн гэж үздэг!

Тэд хүмүүсийг энэ дэлхийд өөрчлөлтийг хийхээр; хаанчлалын төлөө амьдралаараа хувь нэмэрээ оруулахаар бүтээгдсэн гэж итгэдэг. Хэрэв бид дундаж амьдралд л хөрөнгө оруулалт хийвэл бид хэзээ ч агуу амьдралаар амьдрахгүй. Гадны хүмүүст төвлөрдөг сүмүүд нь хүмүүсийг том зориулалт, **агуу үйл хэрэгт** асар их хөрөнгө оруулалт хийхийг уриалдаг - Есүс Христийн төлөвлөгөө! Дэлхий дээр бидэнд амиа өгөхөд илүү чухал зүйл гэж байхгүй.

Тэд хүмүүсийг энэ дэлхийд өөрчлөлтийг хийхээр, хаанчлалын төлөө амьдралаараа хувь нэмэрээ оруулахаар бүтээгдсэн гэж итгэдэг.

Бидний дэлхий "Христ ажиллагаа!"-г харах, хайрыг нь мэдрэх нь туйлын чухал юм. Есүсийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, бүх хүмүүст Христийн хайрыг харуулдаг Христэд итгэгчдээр бидний ертөнц дутагдаж байна. Чуулганд хэрэгцээг харж, тэр хэрэгцээг хангахын тулд, шарх байгаа газарт найдвар авчирдаг, тусгаарлагдсан хүмүүстэй холбоо барьдаг, айдас байгаа газар тайвшрал, эвдэрсэн газар нөхөн сэргээлт, ганцаардал байгаа газар нөхөрлөл, өлсгөлөн байгаа газар хоол хүнс, аюул заналхийлсан орчинд аюулгүй байдал, орон гэргүй хүмүүст хоргодох газар бий болгох гээд чадах бүхнээ хийж чаддаг итгэгчид хэрэгтэй. Христ ажиллагаа нь биднийг амаа нээж, Есүст итгэх итгэлийнхээ тухай ярихаас өмнө үргэлж болох ёстой.

Христийн ажиллагаа нь биднийг амаа нээж, Есүст итгэх итгэлийнхээ тухай ярихаас өмнө үргэлж болох ёстой.

Эрүүл, өсөн нэмэгдэж буй Монголын Христийн Сүмүүдийн зорилго бол "бүх хүмүүст бүх зүйл нь болох, ингэснээр бүх боломжоороо **дахин хэн нэгнийг** аврах явдал юм" (1 Коринт 9:22). Энэ нь хүний нэгдэх хамгийн том шалтгаан болдог бөгөөд, бидний хамгийн том хөрөнгө оруулалт болох үнэ цэнэтэй юм!

Эдгээр өндөр хүлээлттэй сүмүүд бол **өгөөмөр сүмүүд юм.** Өгөөмөр зангийн эсрэг нь юу вэ? Хувиа хичээх, харамч байх. Хэн нь илүү айдсандаа дарлуулдаг вэ? Хэн илүү баяр жаргалтай вэ? Хэн нь их инээмсэглэдэг вэ? Хэний найзууд нь илүү талархдаг вэ? Хэний

гэр бүл илүү аз жаргалтай вэ? Хэний сэтгэл хөдлөл нь илүү эрүүл вэ? Хэний амьдрал илүү их нөлөө үзүүлдэг вэ? Хувиа хичээсэн хүн үү эсвэл өгөөмөр хүн үү? Амьдралын гол түлхүүр бол амиа өгөх явдал юм гэж Есүс сургасан (Марк 8:35).

Өгөөмөр сэтгэл бол гэр бүл, дэлхийдээ үлдээх хамгийн том өв хөрөнгийн нэг юм. Манай чуулганд нярав байх тухай зааж, өгөөмөр сэтгэлийн тухай их ярьдаг. Энэ бол Христэч хүн бүрийн үргэлжлүүлэн өсдөг газар юм. Бурхны аврал бол Бурхны өгөөмөр сэтгэлийн илэрхийлэл юм (Иохан 3:16). Чуулган бол Бурханы өгөөмөр сэтгэлийн илэрхийлэл юм. Бидний амьдралд тохиолддог бүх сайхан зүйл бол Бурхны өгөөмөр сэтгэлийн ач тус юм.

Өндөр хүлээлттэй сүмүүд **хүмүүсээс** хөрөнгө оруулалт хийх, оролцохыг байнга хүсдэг. Тэд хүн бүрийг сайн дурын ажил хийж, үйлчлэх газраа олохыг уриалдаг.

Тэд цаг зав, мөнгөөрөө сүмийн зорилгод дэмжлэг үзүүлэхийг хүмүүсээс гуйхдаа хэзээ ч уучлал гуйдаггүй. Яагаад вэ гэжүү? Учир нь тэд сүмийн зорилгын үнэ цэнэ тэнгэрийн орноос илчлэгдэнэ гэдэгт гүнээ итгэдэг.

Эдгээр хүлээлт өндөртэй сүмүүд, Бурхан Христэч хүн бүрийг Агуу Тушаалыг (Матай 22:37-40) дагаж, Агуу Захирамжыг биелүүлэхээр дууддаг гэж итгэдэг (Матай 28:18-20). Эдгээр хэдэн зуун сүмүүд (том жижиг бүгд) хүмүүсийг том зорилгод том хөрөнгө оруулалт хийхэд зориулж бэлтгэж байгааг бид харсан. Эрүүл, өсөн нэмэгдэж буй сүм бүрт Есүсийн энэ хөтөлбөр гол цөмд нь агуулагддаг. Энэ төрлийн сүм бол **дэлхийн найдвар** болдог юм!

> Есүсийн төлөвлөгөөг баримталсан эрүүл, өсөн нэмэгдэж буй сүмүүд бол дэлхийн найдвар юм!

Бид Христийн Монгол сүмүүд Есүсийг дахин хэлэхийг сонсохыг уриалж байна: “Би та нарт хэлье. Хараагаа дээшлүүлж, талбайг харагтун. Учир нь талбай цайрч хураалтанд бэлэн болжээ” (Иохан 4:35). Анхаарлаа “өөрийн хүмүүс” ээс “гаднах хүмүүс” рүү чиглүүлэхэд төвлөрүүлэх бэрхшээлийг даван туулдаг сүм нь Есүсийн төлөвлөгөөг баримталдаг сүм болой. Зөвхөн өөрийн хүмүүстээ зориулагдсан сүм нь гишүүнчлэлийн онцгой эрхийн талаар ихэвчлэн ярьдаг. Гадны хүмүүсийг багтаасан сүм нь өөрийгөө үгүйсгэх,

золиослох, хаант улсыг өргөжүүлэх тухай ярьдаг.

Чуулганы анхаарлыг тааруулах нь үнэтэй, бас тав тухгүй байж болно. Зөвхөн өөрийн хүмүүсээ анхаарсан төвтэй байх нь илүү хялбар бөгөөд стресс багатай байдаг. Чуулганы удирдагчид хүмүүсээ хүлээлт өндөртэй сүм болгоход, агуу зорилгын төлөө агуу их зориулалт гаргаж, маш их хувь нэмэрээ оруулахад нь нигүүлслээр удирдан чиглүүлэхэд Есүсийн төлөвөгөө өсөж дэвжих болно! Гадагш анхааралтай байдаг сүмүүд бол хүлээлт өндөртэй сүмүүд юм.

Хоёрт, эдгээр сүмүүд гадны хүмүүстэй уулзахдаа ямар **сүнслэг бодит байдалд** ордогоо сайн мэддэг. Тэд Судрыг уншиж байхдаа Есүс үүнийг хэзээ ч аюулгүй хийж байгаагүй бөгөөд тэд ч бас чадахгүй гэдгээ мэддэг. Тэд Есүсийн төлөвлөгөө баримталдаг тул тулалдаан хичнээн хэцүү, аюултай байсан ч хамаагүй тулааны шугамд ойртдог. Сүмүүд дотогш анхаарлаа төвлөрүүлдэг бол сүм дотор уруу таталт болон нүгэлд хүргэдэг чухал биш зүйлсийн талаар хэл амаа билүүддэг.

Хуучин Гэрээнд, Давид хаан хавар, бүх хаад дайнд явсан үеэр гэртээ байсан (2 Самуел 11:1). Дэвид яагаад энэ хавар гэртээ үлдэхийг сонгосныг бид мэдэхгүй ч, гэхдээ энэ хавар тэрээр хөрш, мөн түүний өмнөөс тэмцэлдэж байсан түүний үнэнч цэргүүдийн нэгийн эхнэртэй янаг амрагын харьцаанд орсон юм. Нүглээ нуун дарагдуулахын тулд, тэр эмэгтэйг жирэмсэн болохыг олж мэдсэний дараа Давид Уриаг хөнөөлгөсөн билээ

(2 Самуел 11: 2–27). Дэвид хийх ёстой зүйлээ хийгээгүй тул зөв тулалдаанд анхаарлаа төвлөрүүлэлгүй, уруу таталт, нүгэлд өөрийгөө тавьж өгсөн юм. Хэрэв бид сүмд нүүрлэдэг жинхэнэ сүнслэг бодит байдалд анхаарлаа хандуулахгүй бол сорилт, нүгэл үргэлж гарч ирэх болно.

Хэрэв бид сүмд нүүрлэдэг жинхэнэ сүнслэг бодит байдалд анхаарлаа хандуулахгүй бол сорилт, нүгэл үргэлж гарч ирэх болно.

Эдгээр сүнслэг бодит байдлуудыг баримсталсан сүмүүд нь “цэвэр, цэмбэгэр, төгс сүмийн” дүр төрхийг орхиж, бодит ертөнцөд бодит асуудалтай тулгардаг “эмх замбараагүй сүмийн” соёлоор солигдох ёстой. Зөвхөн Бурханаас ирэх Бурханлаг хором л эдгээр асуудлыг шийдэж чадна! Бүх зүйлд бидний тулгардаг хамгийн том тэмцлүүд бол сүнслэг тэмцлэг юм (Эфес 6:10-12). Муу ёрын сүнсний хүч нь маш их нөлөөтэй хэвээр байгаа бөгөөд бид том дүр

зургаас томруулах үед Сатан хэтэрхий их зөрчилдөөнийг ялж байгаа мэт санагддаг. Бидний аль ч соёлд долоо хоногийн аль ч өдрийн мэдээг харахад, Сатан олон хүний амийг устгаж байгааг харж болно.

Эдгээр сүнслэг бодит байдлуудыг баримталсан сүмүүд нь "цэвэр, цэмбэгэр, төгс сүмийн" дүр төрхийг орхиж, бодит ертөнцөд бодит асуудалтай тулгардаг "эмх замбараагүй сүмийн" соёлоор солигдох ёстой. Чөтгөр гэгддэг Сатан бол жинхэнэ юм. Тэр бол Бурханы эсрэг тэрсэлсэн унасан тэнгэр элч юм. "Шинэ Гэрээнд Эхлэл 3:1-ийн могой бол Сатан гэж таних баталгааг өгдөг (Иохан 8:44; 2 Коринт 11:3, 14; Илчлэлт 12:9; 20:2)6. Тэр харанхуйн хунтайж гэж нэрлэгддэг бөгөөд тэр оршин байдаг. Тэр хулгайлан, алж, сүйтгэхээр ирдэг хулгайч юм. (Иохан 10:10). "Бурхан Назарын Есүсийг Ариун Сүнс ба хүчээр тослон ... сайныг үйлдэж, **диаволд дарлагдсан бүгдийг эдгээн**, байсан учир нь Бурхан Түүнтэй хамт байсан" (Үйлс 10:38) Есүсийн амьдрал ба нас баралтын туршид "энэ дэлхийн ханхүү зайлуулагдсан" (Иохан 12:31).

Элч Паул эдгээр сүнслэг бодит байдлыг маш сайн ойлгож, "Захирагчид болоод эрх баригчдыг зэвсэггүй болгоод, Есүс тэднийг загалмай дээр ялж, тэднийг нийтэд үзүүлэн болгов" (Колоссай 2:15)." Учир нь Бурхан биднийг харанхуйн эрх мэдлээс авраад, Өөрийн хайрт Хүүгийнхээ хаанчлалд шилжүүлсэн "(Колоссай 1:13). Судартт "цайзуудыг эвдэж нураах Бурханы хүчит сүнслэг зэвсэг", "ямар ч бодол санааг Христэд дуулгавартай байдалд олзлуулах" талаар эшлэлээр баялаг байдаг (2 Корин 10: 4-5).

> Нэг хэсэгээ болгох уур амьсгалыг бүрдүүлэхэд сүмээс өөрийн теологи эсвэл итгэл үнэмшлээ өөрчлөхийг шаарддаггүй. Энэ нь бид бүх хүмүүсийг Христэд итгэгч хүн шиг итгэх эсвэл биеэ авч явах байдлаас нь үл хамааран бидний дунд сүнсний аяллаа эхлүүлэх боломжийг олгоно гэсэн үг юм.

Эдгээр гадагш чиглэсэн сүмүүд эдгээр **сүнслэг биет байдлыг** цаг ямагт сайн мэддэг.

Гуравт, эдгээр гадагш чиглэсэн сүмүүд зочломтгой байдаг. Тэд хүн бүрийг хүлээн авдаг. Хүмүүс ирээд удалгүй уригдаж хамрагддаг.

Дотогшоогоо чиглэсэн олон тооны сүмүүдэд хүмүүс нэг хэсэг нь болохоосоо өмнө адил итгэж, биеэ авч явах ёстой болдог. Эдгээр

гадагшаа чиглэсэн сүмүүдийн зочломтгой байх ухагдахуун нь тэр хуучинсаг сэтгэлгээг өөрчилдөг. Үүний оронд хүмүүс итгэж, Христэд итгэгчид шиг биеэ авч явахаас нь өмнө тэр даруй нэгэн хэсэгээ болгодог.

Нэг хэсэгээ болгох уур амьсгалыг бүрдүүлэхэд сүмээс өөрийн теологи эсвэл итгэл үнэмшлээ өөрчлөхийг шаарддаггүй. Зочломтгой байна гэдэг нь зүгээр л бид хүмүүсийг Христэд итгэсэн эсэхээс үл хамааран бидний дунд сүнслэг аяллаа эхлүүлэх боломжийг олгоно гэсэн үг юм. Есүсийн төлөвлөгөө болон үйлчлэлийг дагаж, бид хүмүүсийг итгэлийн төвшнөөс үл хамааран урьж, Есүсийн хэн болохыг хүсдэг хүн болох аялалд гаргах цагийг тэдэнд зөвшөөрдөг.

Зочломтгой байх нь үргэлж гайхмаар хольмог хүмүүстэй болгох нь зайлшгүй, ба хольмог хүмүүстэй сүм болоход зориудын зорилттой байхыг шаарддаг. Бидний хольмог сүмийн тухай алсын хараа тэнгэрээс ирдэг: "Харагтун, үүний дараа намайг харахад, сэнтийн өмнө болон Хурганы өмнө зогсон, цагаан дээл өмссөн, гартаа далдуу модны найлзуур барьсан, **үндэстэн бүрээс, бүх овгоос, бүх ард түмнээс, бүх хэлтнээс** ирсэн үй олон хүн байв. Хэн ч тэднийг тоолж чадамгүй ажээ" Илчлэлт 7:9). Иймээс бид Монголын Христийн Сүмүүдийг хотдоо хамгийн олон үндэстэн ястан, арьсны өнгө, суурь боловсрол, улс төрийн харьяалал, ажил мэргэжил, нас, нийгмийн давхарга, хувцаслах хэв маяг, үсний өнгө, тэр ч байтугай дуртай Америк хөлбөмбөг, бейсбол, хөл бөмбөгийн багууд нь хүртэл өөр өөр хольмог хүнтэй сүм болоосой гэж бид хүсч байна.

Хольмог сүм байснаар бид өөр хүн бүрээс суралцах зүйл бий гэдэгт итгэдэг. Есүс "Энэ хашаан дахь хонин сүргээс өөр хонин сүрэг Надад бий. Би тэднийг бас авчрах ёстой. Тэд Миний дууг сонсоно. Тэгээд тэд нэг хоньчинтой нэг хонин сүрэг болно" гэж заасан (Иохан 40:16). Хольмог сүм байх нь эмх замбараагүй байж болно. Гэхдээ сүм **өөр өөр хүн** бүхнийг үнэлж, хайрлаж, хүндэтгэхэд хангалттай сурч боловсорсон үед үзэсгэлэнтэй байх болно. Манай сүм бидэнд "Итгэлийг Эхлүүлэгч, бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч болох Есүс уруу хараагаа чиглүүлье" гэж заадаг (Еврей 12:2).

Бид нигүүлслийн дуусаагүй бүтээгдэхүүний хувьд Есүстэй ойр байвал "Сэтгэлээр унахгүй байж тэнхээгээ барахгүй"(Еврей 12: 3) байх юм. Ийм зочломтгой сүмүүдийг ихэвчлэн сүмийг энгийн, ойлгомжтой байлгадаг пасторууд удирддаг. Ингэснээр хүн бүр сүмийн зорилгыг ойлгож чаддаг бас оролцдог юм! Гадагш анхаарлаа

төвлөрүүлдэг сүмүүд өөрсдийн гишүүдээ ажиллуулахгүй байх биш харин Христ ажиллагаатай байхаар гишүүдээ сургадаг.

Христ ажиллагаатай хүмүүс өөрсдийн гэр бүл, эцэг эх, сүм, нийгэм, дэлхийд үйлчилдэг. Тэд амьдралаа төлөвлөн тооцоолж, эргэн тойрныхоо хүмүүстээ **ЯМАР НЭГ ЮМ ХИЙЖ ӨГӨХӨӨР** хуваарь гаргадаг. Тэд авдаг биш, харин өгөгч байхыг сонгосон. Тэд Библийг судлахдаа, Есүс бидэнд бүх зүйлийг өгсөн гэдгийг мэдсэн учраас бид үнэгүйгээр өгдөг (Мат 10:8). Христ ажиллагаатай Христэд итгэгчид сүм дотор болон гадна талд үйлчлэх олон арга замыг олдог. Бүх хандлага, үйлдлээрээ тэд **зочломтгой** байдаг.

Сүм хольмог болоход эмх замбараагүй болдог. Гэхдээ сүм өөр өөр хүн бүхнийг үнэлж, хайрлаж, хүндэтгэхэд хангалттай сурч боловсорсон үед үзэсгэлэнтэй байх болно.

Дөрөвдүгээрт, эдгээр гадагш чиглэсэн сүмүүд **зочдод ээлтэй** байдаг. Эдгээр сүм бүрийн ашигладаг судрын ишлэл нь Лук 5:31-32 юм. "Есүс үүнийг сонсоод,"Хэнд нь эмч хэрэгтэй вэ: эрүүл үү эсвэл өвчтэй хүнд үү? **Би өөрийн биш харин гадны хүмүүсийг урьж байна** - энэ бол өөрчлөгдсөн, дотоод болон гадаад байдлаараа өөрчлөгдсөн амьдралын урилга юм.

"Амьдралынхаа аль нэг үед, ихэнх хүмүүс гадны хүн байх ямар байдгыг мэдэрдэг. Зарим хүмүүсийн хувьд энийг харилцаандаа, бусад хүмүүсийн хувьд сүнслэг байдалдаа, боловсрол эсвэл эдийн засгийн байдалдаа - олон шалтгаан байдаг боловч бидний ихэнх нь иймэрхүү мэдрэмжийг мэдэрсэн өдрүүд байдаг. Хөрөнгөтэй бизнес эрхлэгчид зөвхөн ажлаа сайн хийж байхад л хайрлагдана гэсэн бодолтой ганцаардмал хүмүүс байх нь бий. Дэлхийн жишгээр царайлаг, үзэсгэлэнтэй хүмүүс өөрсдийгөө зохицож нийцэхгүй байна гэсэн эргэлзээ, тусгаарлалттай тэмцдэг.

Амжилттай тамирчдыг уухайлан дэмжсэн хүмүүсийн хүсэл эрмэлзэл нь нэгэн цагт зогсдог. Тэр үед тэд ганцаардах, өөртөө эргэлзэх, өөрийгөө тусгаарлах зэрэгтэй тэмцэлддэг. Хөгжлийн бэрхшээлтэй, ядуу, гадуурхагдсан, нийгэмшихэд тохиромжгүй гэж боддог хэсэг хүмүүс гээд энэ бүх хүмүүс нийгмийн тусгаарлалттай тэмцдэг. Хүний харьяалагдах, итгэх энэ далай шиг их хэрэгцээн дунд Есүс хүмүүсийг холбож, тэднийг эдгэрэх боломжтой сүнсний хамт олонтой

нь нэгтгэхээр ирдэг. Сатан үргэлж хулгайлан, алж, сүйтгэхийн тулд хүмүүсийг салгаж, тусгаарлахыг эрэлхийлж байдаг (Иохан 10:10).

Гадагш анхаарлаа төвлөрүүлдэг сүмүүд хүмүүсийнхээ амьдралыг илүү хялбар болохын төлөө залбирдаггүй, харин тэднийг Христ ажиллагаатай байж маш их баяр хөөрөөр үйлчилдэг хүмүүсийг Бурхан ивээх болно гэж залбирдаг. Эдгээр зочдод ээлтэй сүмүүд Есүсийн жишээг дагаж, сүмийг энгийн байлгахыг эрмэлздэг. Есүс Хуучин Гэрээний маш төвөгтэй тогтолцоог авч, энгийн болгосон: "Бурханаа хайрла, хөршөө хайрла" (Марк 12: 28-31). Зарим сүмүүд олон удаа өөрийн мэдэлгүйгээр хүмүүсийг нэгэн хэсэг болоход нь бэрхшээл учруулж, итгэхэд бэрхшээл учруулдаг. Зочдод ээлтэй сүмүүд энгийн хэвээр үлддэг. Энгийн гэдэг нь хялбарчилсан гэсэн үг биш. Энгийн болгох нь хүмүүсийг төөрөлдүүлэхээс илүү хэцүү байдаг.

Зочдод ээлтэй сүмүүд энгийн хэвээр үлддэг. Энгийн гэдэг нь хялбарчилсан гэсэн үг биш. Энгийн болгох нь хүмүүсийг төөрөлдүүлэхээс илүү хэцүү байдаг.

Зочдод ээлтэй сүмүүд нь хүмүүст Библийг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх энгийн мессежүүдийг санал болгодог. Хэцүү зүйл нь бол нигүүлсэл ба үнэнийг тэнцвэржүүлж (Иохан 1:14) Есүст бүрэн дуулгавартай амьдрахад нь хүмүүст тусалдаг. Эдгээр сүмүүд Христэд итгэгчийн хувьд өсч хөгжих, төлөвших энгийн төлөвлөгөөг санал болгодог. Тэд дагалдагч бэлтгэх энгийн тогтолцоог бий болгож, ердийн бүтцийг ашигладаг. Тэд төвөгтэй байдлыг арилгаснаар, үржих төлөвлөгөөтэй эрүүл чийрэг сүмүүдийн эгнээнд нэгдэж чаддаг.

Хүний харьялагдах, итгэх энэ далай шиг их хэрэгцээн дунд Есүс хүмүүсийг холбож, тэднийг эдгэрэх боломжтой сүнслэг хамт олонтой нь нэгтгэхээр ирдэг.

Манай **MULTIPLYNAZ** сургалтанд, сүмд шинээр ирж байгаа хүмүүст "дараагийн алхмуудыг" хийлгэхийн тулд дагалдагч бэлтгэх арга зам хэрэгтэй болох талаар ярилцдаг. Олон сүмүүд дагалдагч бэлтгэх замналаар таван зуршлыг хэрэгжүүлдэг: 1) **магтаалд оролцож**

(мөн баптисмаар итгэлээ хүлээн зөвшөөрөх), 2) **үйлчлэж** (сайн дурын ажилтан болж, сүмийн үйлчлэлд оролцдог), 3) жижиг бүлгүүдэд **өсөж** 4) тогтмол **өгж** 5) бусдыг **урьдаг**. Энэхүү энгийн арга замын талаархи зарим зүйл номлол болгон дээр долоо хоног бүр яригддаг. Гадагш анхаарлаа төвлөрүүлдэг эдгээр сүмүүдэд ням гараг бүр хүмүүсийг дагалдагч бэлтгэхэд хийх дараагийн алхамаа хийхийг уриалдаг.

Сүмийн гадагш чиглэсэн анхаарал бүдгэрч эхлэхэд юу болдог вэ? Нэгэн пасторын шинэ үеийн хүү гэрээсээ хол өөр мужид байрласан байв. Тэр хүү ааваасаа, ямар сүмд очих талаар зөвлөгөө хүсжээ. Аав нь ч нэг газрыг санал болгоод хүү сүмд очоод юу тохиолдсоныг сонирхож байв. Хүү аавдаа ийнхүү тайлангаа хуваалцав:

Гадагш анхаарлаа төвлөрүүлсэн сүмүүдэд дагалдагч бэлтгэх арга замын талаар номлол болгон дээр яригддаг. Ням гараг бүр хүмүүс дагалдагч бэлтгэх дараагийн алхам хийхийг уриалдаг.

“Аав аа, тэд сүмдээ шивээстэй хүн ирлээ гээд бүгд над руу ширтээд байсан. Цуглаан 1 цаг 45 минут үргэлжилсэн бас намайг ингэж хэлж байгаад уучлаарай аваа, гэхдээ уйтгартай байлаа. Би дуусахыг нь тэсэн ядан хүлээж байлаа. Пастор нь бүх зүйлийг бэлтгэл муутай хааш яаш хийж байгаа юм шиг санагдсан. Би хэтэрхий шүүмжлэлтэй хандаагүй гэж найдаж байна. Миний ойлгосноор, тэр сүмд хүмүүс ямар сүнслэгээ харуулдаг ч, гадны хүмүүсийг угтан авдаг чуулган биш байсан. Шинэ хүний хувьд миний сонирхол унтарсан” гэв. Дараа нь хүү ингэж хэлэв: “Хэрэв би Христэд итгэгч биш байсан бол тэр сүмд очсоны дараа тэр сүм рүү буцаж очохгүй. Христэд итгээгүй найзуудаа тэр сүмд хамт явахыг лав урихгүй.”

Ирэх долоо хоногт танай сүмд зочилсон гадны хүн юу гэж хэлэх бол? Тэдэнд сүм чинь зочдод ээлтэй санагдах болов уу? Зочдыхоо талаар өөрөөр бодож сурч мэдсэн сүмүүд бол өөрчлөлт хийх шаардлагатай анхны сүм биш гэдгийг мэддэг. Шинэ Гэрээнд, анхны сүм нь Есүсийн номлолыг маш нухацтай авч байсан бөгөөд иудейчүүд, харь үндэстнүүд хоёулаа Есүс рүү эргэж, сүмд элсэж эхлэв.

Эдгээр шинэ гадны хүмүүс сүмийн удирдагчдыг анхаарлаа төвлөрүүлж, тэднийг талцуулж байгаа том асуудлыг хэлэлцэхээр Иерусалимд цугларахад хүргэв. Зарим еврей итгэгчид харь үндэстнүүдийг Христэд итгэсэн нь гайхалтай гэж бодож байсан ч

эдгээр шинэ харь үндэстнүүдийн дагалдагчид хөвч хөндүүлэх нь чухал гэж үзсэн. Гишүүн байх ямар хэцүү шаардлага вэ! Нилээд маргаан хэлэлцүүлэг өрнөж, эцэст нь Пастор Жэймс өөрийн бодлоо хэлэв:

“Тиймээс миний санаа бол харь үндэстнүүдийн дундаас **Бурхан уруу эргэж буй хүмүүст бид саад болохгүй байх нь дээр.** Харин бид тэдэнд шүтээнээр бузарлагдсан зүйлс, садар самуун, боомилогдсон зүйл болон цуснаас цээрлэж явахыг бичье. Учир нь Амралтын өдөр бүр синагогуудад Мосе уншигддаг тул эрт үеэс эхлэн хот болгонд түүнийг тунхаглагчид нь байдаг гэв” (Үйлс 15:19-21).

Танай сүм гадны хүмүүсийг хэрхэн оролцуулах талаар ярилцдаг уу? Тэдний төлөө хэрхэн бэлдэх вэ? Тэдний төлөө залбирах уу? Тэднийг залбирахыг хүлээх үү? Энэ бүгд чухал асуултууд юм. Хэрэв Бурхан сүм хайж буй хүнийг холбох сүмийг сонгохоор бол тэр хүнийг хүлээн авахад бэлтгэсэн газрыг сонгох болно. Зочдод ээлтэй сүмүүдэд сүмийн сайн дурынхан шинэ хүмүүст Бурханруу эргэж “Бурханлаг мөчийг” мэдрэхийг боломжтой болгохын төлөө залбирч, төлөвлөж, ажилладаг. Бурханаас холдсон гадны хүмүүст Түүнрүү эргэхэд боломжтой болгохын тулд хайрладаг, залбирдаг, өгдөг, үйлчилдэг хүмүүс бол сайн дурын ажилтнууд юм.

> Хэрэв Бурхан сүм хайж буй хүнийг холбох сүмийг сонгоор бол тэр хүнийг хүлээн авахад бэлтгэсэн газрыг сонгох болно.

Долоо хоног бүр хэдэн арван сүмд хэдэн зуун Монголын Христийн Сүмийн сайн дурын ажилтнууд Монголын хөдөлгөөнд оролцож гадны хүмүүст анхаарлаа төвлөрүүлэхэд нь тусалдаг. Манай сүмүүд **зочдод ээлтэй** байхыг уриалдаг, учир нь дэлхий дээрх хүн бүрийг аврах нь Есүсийн зорилго юм (Иохан 3:16).

Тавдугаарт, эдгээр гадагш төвтэй сүмүүд нь **гадагш хүсэл тэмүүлэл** өндөр байдаг. Паул бичихдээ “Учир нь би бүхнээс чөлөөтэй атлаа илүү олныг талдаа оруулахын тулд өөрийгөө бүгдэд боол болгов. Иудейчүүдийг талдаа оруулахын тулд Иудейчүүдэд Иудей хүн адил, хуулийн дор байгсдыг талдаа оруулахын тулд ... би хуулийн дор байгч мэт, хуульгүй хүмүүсийг талдаа оруулахын тулд би … хуульгүй хүн адил, мөхөс хүмүүсийг талдаа оруулахын тулд … би мөхөс хүн адил болсон. Яалаа ч гэсэн заримыг нь аврахын тулд бүх хүнд би бүх

юм болж байлаа. Би сайн мэдээний хамсаатан болохын тулд сайн мэдээний төлөө бүх юмсыг хийдэг "(1 Коринт 9:19- 23) гэжээ.

Яалаа ч гэсэн **дахин хэн нэгнийг** аврахын тулд бүх хүнд би бүх юм болж байлаа (1 Коринт 9:22). Есүс нэг хүний сүнслэг амьдрал бүх ертөнцөөс илүү үнэ цэнэтэй гэж заасан (Марк 8: 36-37). Гадагш анхаарлаа төвлөрүүлдэг сүмүүдийн эрхэм зорилго бол Есүсийн адил алдагдсан нэг хүнийг олох хүртлээ явах юм (Лук 15:4).

Гадагш хүсэл тэмүүлэлтэй **сүмүүд аюулыг** үл хайхардаг. Анхны чуулган хүнд хэцүү хавчлагад өртөж байсан бөгөөд Паул Есүсийн тухай чадахаараа хүн бүрт зааж ярин аялдаг байв. Тэр хүмүүстээ Иерусалим руу явна гэж мэдэгдэхэд түүнийг алагдана гэж тэд айсан учир битгий яваач гэж гуйсан. Тэгэхэд Паул ингэж хариулсан:

Тэгтэл Паул "Юунд уйлж, та нар зүрхийг минь өвтгөнө вэ? Би Эзэн Есүсийн нэрийн төлөө хүлүүлэх нь байтугай Иерусалимд үхэхэд бэлэн байна." Тэр нэгэнт ятгалгад автахгүй тул бид бууж өгөөд "Эзэний хүслээр болтугай" гэж хэлсэн (Үйлс 21:13 –14).

Паул Бурханы түүнд өгсөн аюултай даалгаврыг хүлээж авсан ... яалаа ч гэсэн дахин хэн нэгнийг аврахын тулд бүх хүнд би бүх юм болж байлаа. Энэ бол аюултай залбирал: "Эзэн минь, би Таны зорилгыг биелүүлэхийн тулд үхэхэд бэлэн байна." АНУ-ын ихэнх нутаг дэвсгэр дээр Христэч итгэлийн аюулгүй хэлбэр байдаг. Дэлхийн бусад олон оронд харин үгүй.

Паул Иерусалимд очиж, итгэл нэгтнүүддээ урам өгч, тэднийг Христ дотор өсөхөд нь тусалжээ. "Тэгээд бараг долоо хоног өнгөрч байтал Азиас ирсэн иудейчүүд түүнийг сүмд байхыг хараад цугласан бүгдийг үймүүлж, … Хот бүхэлдээ хөдөлж, хүмүүс олноороо цуглан **Паулыг барьж аваад,** сүмээс **чирч гаргахад** тэр даруй хаалганууд хаагдсан байлаа. Тэд **түүнийг алахыг завдан** байх үед Иерусалим хот тэр чигээрээ үймээн самуунд автсан гэсэн мэдээ Ромын ангийн мянгатын даргад хүрэв. Тэрээр тэр даруй цэргүүд, зуутын дарга нарыг авч тэдэн уруу гүйн очив. Хүмүүс мянгатын даргыг болон цэргүүдийг хармагцаа **Паулыг занчихаа болив"** (Үйлс 21:27, 30-32).

Паул баривчлагдсан бөгөөд үүнийгээ ямар шударга бус байсныг гомдоллохын оронд тэр боломжийг ашиглан цугласан олонд итгэлээ хуваалцжээ! (Үйлс 22:1-22) Маргааш өдөр нь Паул тэргүүн тахилчид болон Санхедриний бүх гишүүдийн өмнө зогсож, Христэд итгэсэн түүхээ хуваалцажхад, маргаан эхлэв. "Маргаан ширүүсэж эхэлсэнд, тэд **Паулыг тастчих вий гэж айж байв"** (Үйлс 23:10).

Шоронд байхад нь ч Паулыг алах хуйвалдаан гарсан тул тэд түүнийг Кайсари руу шилжүүлжээ (Үйлс 23:12-35). Паулыг хилсээр хоёр жил шоронд хийсний эцэст Фест, хаан Агрийп нарын өмнө авчирсан бөгөөд тэр бүрд нь адил зүйлээ хийдэг байсан нь тэр Есүст итгэсэн түүхээ хуваалцдаг байсан!

> Зарим хүмүүс хурдан итгэдэг хэдий ч;
> олон жил зарцуулдаг хүн ч бий.
> Харин **хэн ч хэтэрхий хол биш!**

Паул өөрчлөгдсөн амьдралынхаа түүх болох Христэд итгэгчдийг хавчиж, Есүстэй уулзаад амьдрал нь 180 градусын эргэсэнээ хуваалцаж байхад "Агрийп Паулд - Богинохон хугацаанд чи чинь намайг Христийнх болгох нь ээ? гэхэд" Паул "- Богинохон ч бай, удаан хугацаанд ч бай зөвхөн та ч биш, харин өнөөдөр энд намайг сонсогсод бүгдээрээ энэхүү гинжнээс бусдаар надтай адил болоосой гэж би Бурханд залбирмаар байна гэв" (Үйлс 26: 28-29).

Өндөр түвшний **гадагш хүсэл эрмэлзэлтэй сүмүүд**, гадны хүмүүсийг Христ болон сүмийн гэр бүлтэй холбогдоход нь туслахыг хүсдэг тийм адил сэтгэлтэй байдаг. Тэд хүмүүсийг хайрлаж,

Бурхан тэднийг хэн болохоор бүтээсэн түүндээ хүрэхэд нь тусладаг. Зарим хүмүүс хурдан итгэдэг хэдий ч; олон жил зарцуулдаг хүн ч бий. Харин **хэн ч хэтэрхий хол биш!** Нэг нэгээр дэлхийн өнцөг булан бүрд хүмүүс эдгээр сүмүүдийн гадагш хүсэл тэмүүллээр Есүсийн дотор аврал, найдварыг олж байна.

> Хүн бүхэнд нигүүлслийн аянаа
> эхлүүлж, Бурханы Үгийг сонсож
> ухаардаг, Есүсийн дотор эдгэрэл,
> найдварыг хайгаад олдог боломжыг
> олгодог, бүгдэд нээлттэй сүмийг та
> төсөөлж чадах уу?

- Хүн бүхэн жинхэнэ харилцааг барьж байгуулахад өөрсдийгөө зориулсан, хүн бүрийн сүнслэг аялал нь хүндлэгдсэн, Есүсрүү өөрийн таавaар алхах эрх чөлөөг нь өгсөн сүмийг та төсөөлж чадах уу?
- Гадны хүмүүс юмуу өөрийн хүмүүс гэж байхгүй, харин хүн бүхэн хүндэтгэлийн цуглаанд уригдсан, нэгэн хэсэг нь болохоор үнэлэгдсэн сүмийг төсөөлж чадах уу?

- Бүгдийг энгийн байлгаж, гол зүйлээ урдаа, төвд байлгахын тулд бүгд хичээнгүйлэн ажилладаг сүмийг та төсөөлж чадах уу?
- Хана байхгүй, маскгүй, хориотой зүйлгүй, хүн бүр Есүсийн хайрладаг шиг бие биенээ хайрладаг, өөрсдийг нь зовоож, хохироосон хүмүүсийн төлөө ч өөрийн амиа золиослоход бэлэн байдаг сүмийг төсөөлж чадах уу? (Матай 5:43-44)
- Бэлгийн хэт их дуршилтайгаа, порнографтай, үр хөндөлт хийлгүүлсэнтэйгээ тэмцэж байгаа, хүүхэд байхдаа хүчирхийлэлд өртөөд эр хүнтэй хэрхэн харьцахаа мэдэхгүй болсон байсан сүмийг төсөөлж байна уу? архичин эцэг эхтэйгээсээ болоод ажлын хэнхэгтэй болсон хүн, мансууруулах бодисын донтолтоо санхүүжүүлэхээр аав ээжийнхээ үл хөдлөх хөрөнгийн хулгайлсан хүн гээд - **хүн бүхэнд** нигүүлслийн аяныг эхлүүлэхэд **нээлттэй**, Бурханы Үгний үнэнийг сонсоод ойлгодог, Есүсийн дотор эдгэрэл найдварыг хайгаад хариулаад олдог сүмийг төсөөлж чадах уу?
- Хариу харалгүй тусламжын гараа сунгах нь хэвийн үзэгдэл болсон, өөрөөс нь санхүүгийн тусламж асуухыг хүлээж байдаг - орон нутгийнхаа сүм болон дэлхийн дахинд байгаа хүмүүст бодит ба сүнслэг байдлаар туслахад долоо хоногийн өргөлийг зарцуулагдаг сүмийг төсөөлж чадах уу?

Ариун Сүнс бидний зүрхний гүнд биднийг энэ хөдөлгөөнөө урагшлуулахад тууштай байхыг өрдсөөр, бид үүнтэй адил илүү олон Монгол сүмүүдийг эхлүүлэх ЁСТОЙГ сануулж байна. Бид одоо байгаа монгол сүмүүдийг ингэж ажиллахаар шинэчлэх ёстой.

Бид БҮХ сүмүүдийг дагалдагч бэлтгэхээ нигүүлслийн аян болгож гадны хүмүүсд анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй байна! 9

## Эргэцүүлэх Асуултууд - 3р Бүлэг

1. 1. Зохиогчид" Христэд итгэгч эцэг эхийн үйл ажиллагаа адилаар зориудаар дагалдагч бэлтгэх үйл явц итгэж эхлэхээс эхэлдэггүй энэ нь анхны мэдэгдэхүүнээс эхэлдэг. Хүн Христэд итгэхийн өмнө тэднийг тааламжтай нигүүлсэл татаж эхэлдэг" гэжээ. Бурхан хүнийг авралын нигүүлслийг амьдралдаа мэдрэхээс нь өмнө Бурхан ажиллаж эхэлдэг гэдэгтэй та санал нийлж байна уу? Яагаад эсвэл яагаад үгүй гэж?
2. "Бурханы таалал" гэсэн үг таны бодлоор юу вэ? Таны бодлоор

"хүний таалал" тэгвэл юу вэ? Яагаад эсвэл яагаад үгүй гэж? Энэ нь хүний амьдралд тохиолдоход "яаж харагддаг" вэ?

3. Таны хувьд "Бурханы таалал"ыг сүм цуглаанд мэдэрч таашаах боломжтой юу? Яагаад эсвэл яагаад үгүй гэж?
4. Тэмми Селвейгийн гэрчлэл танд ямар санагдсан бэ? Та ямар сургамж авсан бэ? Танай сүмд Тэммитэй ижил төстэй сүнслэг аян хийсэн хэн нэгэн байгаа юу? Тэр хэн бэ?
5. Танай сүм хүний амьдрал дахь сүнслэг өөрчлөлтийг хэрхэн тэмдэглэдэг вэ? Танай сүм хүмүүст гэрчлэлээ бусадтай хуваалцах боломжийг өгдөг үү? Үүнийг яаж хийдэг вэ?
6. Тэмми шиг хүмүүсийг сүмдээ яаж илүү сайн угтан авч болох вэ?
7. Зарим сүмийн болон Христэд итгэгчдийн буруу хандлага, буруу итгэл үнэмшил, буруу зан авирыг судлаад үз. Тэдгээрийн аль нь таны анхаарлыг татаж байна? Аль нь танай сүмд сорилт болох вэ? Харин таны хувийн амьдралд? Сүмийнхээ тухай биш зөвхөн өөрийнхөө тухай бүлэг, бүлгийн эсвэл ангийнхаа гишүүдтэй зоригтой хуваалцаарай.
8. Эрүүл, өсөн нэмэгдэж байгаа сүмүүдийн онцлог шинж чанарыг эргэцүүл. Эдгээр сүмийн талаар уншихад та юу сурсан бэ? Эдгээрийн аль нь танд шинэлэг байсан бэ? Танд сүмээ урагшлуулахад, эдгээр таваас алийг нь танай сүм илүү хөгжүүлж эхлэх ёстой гэж бодож байна?
9. Гишүүнчлэлийн "давуу эрхийн" тухай ярих сорилтыг даван туулахын тулд сүмүүд юу хийж болох вэ? Өөрийгөө үгүйсгэх, золиослохыг өвлүүлэх соёлыг бид хэрхэн илүү сайн хөгжүүлэх вэ? Библи бидэнд энийг заах ёстой гэж заадаг гэж бодож байна уу?
10. Библид сүнслэг дайн тулаан болдог сүнслэг зүй тогтол байдаг гэж тодорхой заасан байдаг. Энэ бүлгээс та юу сурсан бэ? Эдгээрийг сүм дээрээ хэрэгжүүлэхийн тулд ямар практик алхам хийх вэ? Харин таны хувийн амьдралд?
11. Гадагш төвтэй сүмүүдэд хүмүүс итгэж, өөрсдийгөө Христэд итгэгчид шиг биеэ авч явахаасаа өмнө уригдаж нэг хэсэг нь болсон байдаг. Сүнслэг аяллаа дөнгөж эхэлж байгаа Христэд итгэж амжаагүй хүмүүсийг танай сүм хэрхэн угтан авдаг вэ? Та хэрхэн сайжруулах вэ?
12. Итгэж эхлээд биеэ авч явахад сураад нэгэн хэсэг нь болох дарааллын гүн ухааныг, эхлээд нэгэн хэсэг нь болоод, тэгээд итгээд дараа нь биеэ авч явахад сурах ухааны хоорондын ялгааг ярилц. Танай

сүм теологи, итгэл үнэмшлээ өөрчлөхгүйгээр сэтгэлгээгээ хэрхэн өөрчлөх вэ?

13. Танай чуулган хэр хольмог вэ? Угсаатан? Өнгө? Боловсролын суурь? Улс төрийн харьяалал? Карьер? Нас? Нийгмийн статус? Хувцасны хэв маяг? Спортын багуудын хувьд? Танай сүмийн хүмүүс тэс өөр хүмүүсээс сонсож, суралцахдаа хэр нээлттэй вэ?
14. Танай сүм дагалдагч бэлтгэх дараагийн алхмуудаа зочид болон оролцогчиддоо хэр ойр ойрхон тайлбарладаг вэ? Эдгээр алхамуудыг хийхэд хэр энгийн, ойлгомжтой вэ?
15. “Гадагш хүсэл тэмүүлэл” хэсгийг уншиж дууссаны дараа 1-ээс 10 хүртэлх хэмжээгээр, 1 нь маш доогуур, 10 нь гайхалтай хүсэл тэмүүлэлтэй гэвэл та өөрийгөө юу гэж үнэлэх вэ? Танай сүмийн хувьд? Та өөрийн бүлэг, хамт олон эсвэл ангиасаа таны хүсэл эрмэлзлийн түвшин дор хаяж 1 эсвэл 2 оноогоор ирэх өдрүүдэд дээшлэхийг залбируулаарай.

# Чуулганы Тухай Бидний Итгэл 4

"Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла. Тэр чуулганыг үгээр дамжуулан усанд угааж цэвэрлэн, ариусгаад түүнийг ямар ч толбо, үрчлээсгүй эсвэл алив ийм юмгүй, харин ариун, гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө алдарт чуулган болгох гэсэн билээ. (5 Ефес: 25-27)

Бид хэрхэн том өөрчлөлт хийх тухай бодьё. Энэ бодол нь дэлхийд бүхий л том өөрчлөлт бий болгох ба өөрчлөлтийг авчрах болно. Бидний хэлсэн нь бидний хэрхэн бодож байснаас илүү бодитоор бидний хэн бэ гэдгийг харуулдаг. Эцсийн эцэст бидний хэн болох нь бидний бодож байгаагаар тодорхойлогддог. Галат 6: 7 дээр суурилагдан хэлсэнээр бид юу тарьсанаа л хураадж авдаг.

> Эцсийн эцэст юу болох нь бидний хэрхэн бодож байгаагаар тогтоогддог. Энэ бол орон нутгийн Монгол чуулгануудын болон Монголын Христчин чуулганы хөдөлгөөний хувьд үнэн зүйл юм.

Бодол тарьж үйлдлийг хураа Үйлдлийг тарьж зуршилыг хураа Зуршилыг тарьж зан чанарыг хураа Зан чанарыг тарьж хувь тавьланг хураа

Бид хэрхэн бодсоноороо үйлдэлээ удирддаг. Бид хэрхэн үйлдэлээ тогтоож бий болгосноор бид зуршилаа хэлбэржүүлдэг. Бидний тогтоосон зуршил нь бидэнд байдаг зан чанарыг тодорхойлдог. Бидний зан чанар бидний хувь тавиланг тодорхойлдог. Энэ бол зөвхөн бие даасан цуглаануудын үнэн бус энэ нь орон нутгийн цуглаан болон бүлэг цуглаануудын үнэн байна.

Бидний **MULTIPLYNAZ** сургалт нь бидний сүнслэг зуршил сүмийн үндэс суурь хөрсийг хөгжүүлэх шалгалт болж байна. (Марк 4:28). Бусдад нөлөөлдөг сүмүүд өөрсдийн хүмүүст дагалдагч бэлддэг зуршлыг зааж сургадаг нь амархан өсөх шалтгааны үр нь болдог. Тэдний үйлдэл болон зуршил нь тэднийг бусдад нөлөөлдөг чуулганууд болгодог. Сүмийн сэтгэлгээнээс сүмийн зан чанар соёлын хэлбэржилт урсан гарч ирдэг. Тиймээс бидний бодол сэтгэлгээ их чухал юм. Орон нутгийн сүм чуулганууд болон Монголын христчин чуулганы

хөдөлгөөн болон бид нар бол бид хэрхэн бодож байсны маань үр дүн бүтээгдэхүүн юм.

Хэрэв Монголын Христчин чуулганы хөдөлгөөн нь Бурхан үүнийг мөрөөдөж хүсэж байсан бүх зүйл байх ёстой бол энэ нь бидний бодол санаагаар байгаагаар эхэлж байгаа юм.

Хэрэв бид бидний үеийнхэнд сүмд туслахад Есүс тэдний төлөө өөрийгөө өгсөн гэдгийг мэдрүүлэхийн тулд бид заавал Есүсийн бодож байсан арга замыг эрэн хайх ёстой. Бид заавал төөрсөн (гадны хүмүүс) хүмүүсийг Есүс тэдгээр хүмүүсийг яаж харж байсан шиг харах ёстой. (Лук 15:1-32). Хэрвээ бид сүмийг удирдаж байгаа бол бид Есүсийн гаргаж байсан үйлсийг гаргах ёстой. Түүний учраас. Бид түүний бие түүний бие нь энэ дэлхий билээ. (1Коринт 12:27). Түүний сүмийн хувьд бидэнд Христийн оюун ухаан байх боломжтой гэсэн гайхалтай амлалтыг өгсөн" (1Коринт 2:16). Есүс үргэлж Сүйт Бүсгүй болсон бидний тухай боддог!

> Бид Есүс яаж үйлдэх байсан шиг үйлдэх ёстой, хэрэв тэр бидний өмнөөс удирдаж байгаа бол учир нь Тэр удирдаж байгаа юм.

Бид бүгдээрээ хуриманд оролцож байсан. Есүс анхны гайхамшигаа хуриман дээр хийсэн. (Иохан 2:1-11). Хуучин Гэрээнд Бурхан Израилийн ард түмнийг сүйт бүсгүй гэж хэлсэн байдаг. (Хосеа 2:19-20). Шинэ Гэрээн дээр Паул элч сүмийн мөн чанарыг эхнэр нөхөр хоёрын гэрлэлттэй адилтган "хоёулаа нэг бие болох болно гэж зүйрлэж хэлсэн. Энэ нууц нь агуу юм гэвч би Христ ба чуулганы тухайд ярьж байна" (Ефес 5:32). Библийн хамгийн сүүлийн номон дээр элч Иохан хурганы гэрлэх ёслол дээр болох хамгийн агуу хуримын зоогийг дүрсэлжээ (Илчлэлт 19:6-9). Христийн бэр болох сүм нь Есүс Христэд үүрд мөнхөд хамааргадна.

## Бидний Чуулганы Онол

Энэ номын зохиогч хүмүүс бид Эзэн Есүс Христэд гэмшин Ариун Сүнсээр хамтдаа Бурханы бүтээсэн Христ дотор гэрээ байгуулан шинэчлэгдсэн мөн үгийн дагуу Христийн биеэр дуудагдсан сүмд итгэдэг гэсэн. Сүмийн эрхэм зорилго нь дэлхийд Христийн цагаатгал болон эвлэрүүллийн үйлчлэлийг Ариун сүнсний хүчээр хуваалцах нь

юм. Сүмийн талаар бидний итгэдэг зүйл бол теологийн хувьд маш чухал бөгөөд энэ нь сүм орон нутаг, дэлхийн хэмжээнд өөр өөр, нөхцөл байдалд хэрхэн харагдах талаархи ойлголтыг хэлбэржүүлж өгдөг. Бид "чуулган бол түүхийн хувьд бодит зүйл бөгөөд энэ нь **соёлын нөхцөлт хэлбэрийг** бий болгодог гэдэгт итгэдэг…"

Бид Америкийн Нэгдсэн Улс болон Монгол болон бусад улсуудад олон соёлын нөхцөлт сүмийн хэлбэрт орших байна. АНУ-д амьдардаг монголчуудын олонхи нь сүмийн тодорхой соёлын хэлбэртэй болсон байна. Энэ бол сайн маш сайн байна. Сүм гэдэг үгийг яг одоо хэрэглэхэд бидний бодож байгаа хэдэн арван төрлийн сүм хэрэгтэй байна.

> "Чуулган бол түүхийн хувьд бодит зүйл бөгөөд энэ нь соёлын нөхцөлт хэлбэрийг бий болгодог…"

Хүн бүр пастор болгон удирдагч бүр өөрсдийн сүмийн соёлын нөхцөлт хэлбэрийг илүүд үздэг. Та үүнийгээ алдахгүй гэж итгэж байна. Та үүнийгээ хадгалаад бидэнд өсөхөд маань тусална уу. Монголын Христчин чуулганы хөдөлгөөнд чуулган бүрийг эрүүл өсөлттэй сүм болгоход туслах удирдагч нар хэрэгтэй байна.

Манай сүмийн удирдагч нар ухаалгаар танигдсан удирдагч нар сүмд үг болон илгээлттэй хамт зэрэгцүүлэн тогтмол сүнслэг халамж магтаал зааварчилгаагаар... хангахыг хичээдэг..." Эндээс бид 4 түлхүүр зарчмыг олж харж болно: 1) магтаал, 2) хамтын ажиллагаа, 3) хариуцлага 4) илгээлт.

Мэдэгдэх нь, сүм заавал өөрийн байр үл хөдлөх хөрөнгөтэй байх албагүй. Бас заавал пастортай ч байх албагүй. Харин теологийн боловсролоор хангагдсан Эзэнд өөрийгөө зориулах сэтгэлтэй удирдагч байхад хангалттай. Сүм нь заавал тодорхой хэмжээтэй байх албагүй. Бас заавал Бүтэн сайнд цугладаг байх албагүй. Магадгүй ажлын өдрүүдээр цуглардаг байж болно.

Элч Паул Ром14:5 дээр хэлэхдээ, "Зарим нь нэг өдрийг нөгөөгөөс нь онцгойлон үздэг байхад, зарим нь өдөр бүрийг адилхан гэж үздэг. Хүн бүр өөрийн бодолдоо бат итгэлтэй байг. ." Тэгэхээр элч Паул бидэнд зөвхөн Ням гариг бус долоо хоногийн бүх өдөр хүмүүсийг Христ руу удирдан Эзэнийг магтах зөвшөөрөл өгсөн байх нь ээ.!

Сүм хэзээ ч тодорхой хэмжээтэй байснаар үр нөлөөтэй байсан

удаа байхгүй. Иймээс бичил-Монгол чуулган байж болох юм." Хэрвээ бид тархсан Монголчуудын нийгмийн бүлэг болон соёлын бүлэг болсон цөөнхөд хүрье гэвэл маш их өөрөөр бодож сэтгэх ёстой. Бид илгээлтийн эздийн бодол илгээлтийн стратеги байж бид Монголчуудын шашинлаг соёлд нэвтэрэх ёстой. Дэлхий дээрх бүх цуглаанууд ихэвчлэн жижгээр эхэлсэн байдаг. Бид дэлхий даяар хүрч амжаагүй хөршүүддээ хүрч зуу зуун бичил сүмүүдийг тарьж болно. Дэлхийн аварга том хотууд дахь үл хөдлөх хөрөнгийн үнэ дийлэхийн аргагүй байгаа энэ үед, бичил монгол чуулган (гэр чуулган) нь чуулганы огцом тэлэлтийг үргэлжлүүлэх арга зам болох нь дамжиггүй.

> "Чуулган бол тогтмол сүнслэг халамжын төлөө цугладаг, магтаал зааварчилгаа... тогтоосон удирдагч нар чуулганы баримлах үг болон зорилгод дүйцүүлдэг."

> Чуулган заавал өөрийн байр, үл хөдлөх хөрөнгөтэй байх албагүй. Бас заавал пастортай ч байх албагүй. Харин теологийн боловсролоор хангагдсан Эзэнд өөрийгөө зориулах сэтгэлтэй удирдагчтай байхад хангалттай.

Энэ өсөлтийг аргыг чуулганы онолд оруулна. Сүм үргэлж соёлын хэлбэрт таарч тохирсоноороо оршин тогтнодог. Бидэнд өөр өөр соёлын хэлбэртэй олон арван шинэ сүмүүд хэрэгтэй байна. Энэ нь бүх төрлийн газарт бүх төрлийн хүмүүст бүх төрлийн сүмүүдийг бий болгоно гэсэн үг юм. Сүмүүдийн ирээдүй нь зөвхөн Монгол чуулганы ирээдүй биш бүх л чуулганы ирээдүй юм. Тэд бас очиж сайн мэдээ тарааж буй хүмүүсийнхээ соёл нөхцөл байдалд нь тааруулж харилцах хэрэгтэй.

> Бид илгээлтийн эздийн бодол илгээлтийн стратегитай болж Монголчуудын шашинлаг соёлд нэвтэрэх ёстой.

Ингэснээр эрүүл Монгол чуулганд өөр соёлын гаралтай хүмүүс ирж оролцдог болж болох юм. Ирээдүйд олон Монгол чуулганууд таригдсан газраасаа хамаараад

олон соёлын гаралтай болж болох юм. Монгол чуулганы дэлхийн илгээлтийг хэрэгжүүлэхийн тулд Христ итгэлт Монгол чуулганы хөдөлгөөн нь маш олон тооны шинэ төрлийн чуулгануудыг дэлхий даяар эхлүүлнэ. Бид эдгээр **шинэ чуулгануудыг болон удирдагч** нарыг нь **тэврэн авах** олон арван итгэлээр өссөн Монгол чуулганы удирдагч нар байгаад баяртай байна.

Дэлхий үргэлжлэн өөрчлөгдөж байгаа шиг чуулган заавал өөрчлөгдөх шаардлагтай. Бидний сургаал хэзээ ч өөрчлөгдөхгүй харин арга барил хэв маяг стратеги төлөвлөгөө цаг ямагт шинэчлэгдэх ёстой. Хэрэв бид Есүс Христийн сайн мэдээний хамт бүх дэд соёл, бичил хам сэдэвт нэвтрэн орохын тулд бид үргэлж шинийг санаачилж нөхцөл байдалд тохируулж харьцаж байх ёстой.

## Манай Чуулганы Доод Хэмжээ

Грекээр чуулганыг “ecclesia” гэдэг үгээр илэрхийлдэг. Чуулган судлалыг (ecclesiology) гэдэг. Бид чуулганы доод хэмжүүрийн тухай ярих утга нь “Сүмд тооцогдохоор цугларах ёстой хүмүүсийн хамгийн бага хэмжээ ямар байх вэ? Гэсэн утга гарч байна. Бид хийж буй бүхий л зүйлээ библийн дагуу энгийн анхны чуулган ямар байсан шиг хийх ёстой. Бид бичил чуулгануудыг Христ итгэлт Монгол чуулганы хөдөлгөөний гол үндсэн илэрхийлэл гэж баталдаг. Учир нь хоёр буюу гурвуулаа Миний нэрээр хаана цуглана, тэнд Би тэдний дунд байна гэж айлдав. (Матай 18:20). Хэрвээ эдгээр итгэгч нар хамтдаа үнэн сэтгэлээсээ магтаал өргөн хүмүүстэйгээ хариуцлагтай хандаж Есүсийн эрхэм зорилготойгоор сайн мэдээ бусдад тарааж ecclesia г өргөтгөж байх юм бол тэд нар чуулган юм!

> Чуулганы илгээлтийг дэлхийд хэрэгжүүлэхийн тулд маш олон тооны шинэ төрлийн чуулгануудыг өөрсдийн бүс болон дэлхий даяар эхлүүлэх хэрэгтэй.

Тиймээс бидний хувьд 1) магтаал, 2) хамтын ажиллагаа, 3) хариуцлага 4) илгээлт нь чуулганы доод хэмжүүр юм.

**Учир бид хянахаас илүү эрүүл Монгол чуулгануудыг өсгөж тэдэнд эрх мэдлийг өгөхийг хүсдэг.** Шинээр үндэстнүүдэд цуглаан тарьж эхлэхэд хамгийн их үр нөлөөтэй сайн мэдээний аргын гол охь

нь Христтэй адил дагалдагч бэлтгэх арга гэдэгт бид итгэдэг. Монгол чуулган бүрийг эцэг чуулган байж шинээр үүсгэн байгуулагдсан чуулгануудыг бас эцэг чуулган болгохын тулд бид урамшуулдаг. Хэрэв энэ нь боломжгүй бол сүм таригч нь хариуцлага хүлээх боломжтой пастортой холбоход нь тусалдаг **MULTIPLYNAZ** оффист хандах хэрэгтэй. Бид хаана ч сайн мэдээ хэрэгтэй байгаа Монгол хүмүүст Бурханы босгосон удирдагч нарыг ашиглан шинэ Христич Монгол Чуулганыг эхлүүлж чадна.

> Хэрэв бид Есүс Христийн сайн мэдээг бүх дэд соёл, бичил хам сэдэвт нэвтрэн орохыг хүсвэл бид үргэлж шинийг санаачилж нөхцөл байдалд заавал тохируулан харьцаж байх ёстой.

**Есүс Чуулганы Тухай Юунд Итгэдэг Болох**

Сүмийн эрхэм зорилго нь үндэстэнд Христтэй адил дагалдагч нарыг бий болгох нь юм.” Христтэй адил гэдэг стандарт хэмжээ нь Христийг бүх бодол санаа бүх зүйлээрээ дуулгавартай дагахыг хэлж байгаа юм. (2Коринт 10:5). “Есүс бид нарыг мөрөөрөө дагуулахын тулд бид нарт үлгэр жишээ үзүүлсэн. (1Петр 2:21).

Бидний дуудлага чуулганы удирдагч нарт энэ үеийнхэнд Есүс гологдсон тэдгээр хүмүүсийн төлөө сүмийн төлөө өөрийгөө өгсөн гэдгийг зааж өгөх нь Бурханы хүсэл гэдгийг мэдүүлэх явдал юм. Хэдийгээр Эзэн Есүс болон Бурхан Эцэг төгс боловч өнөө үед Есүсийн биеийн илэрхийлэл болсон чуулган төгс биш байна. Энэ бол Бурханд урам хугархаар гэнэтийн зүйл биш.

> Бидэнд, 1) магтаал, 2) хамтын ажиллагаа, 3) хариуцлага 4) илгээлт бол бидний чуулганы доод хэмжүүр.

Есүс Иерусалимд анхны чуулганыг байгуулахдаа чуулган төгс биш байх болно гэдгийг мэдэж байсан. Хэрэв таны чуулган чинь асуудалтай санагдвал Есүс түүний чуулганд ямар асуудал тулгарч байсныг олж хараарай.

1. Түүний санхүү баригч нь мөнгөнөөс нь хулгайлж байсан. (Иохан 12:6)

2. Түүний чуулганы томилсон гол удирдагч нараас нэг нь түүнээс урваж байсан. (Лук 22: 7-48).
3. Түүнд удирдлагын багийнхан нь хэрэг болох үед тэд нар нь унтаж байсан. (Матай 26:40).
4. Аюул дарамт ирэхэд удирдлагын багийнхан нь орхин зугтаасан. (Матай 26:55-56)
5. Түүний хамгийн дотно нэгэн нь түүнийг үгүйсгэсэн. (Матай 26:75)

Бид сүм дэхь асуудлыг үнэлэхэд Есүсийн ажиллаж байсан хэд хэдэн урам өгөх үнэн ялгарч гарч ирдэг. Таны санхүүг баригч чинь мөнгийг тань танаас хулгайлахгүй, таны сонгосон гол удирдагч нар танаас урвахгүй, танай удирдлагын багаас хурлын үеэр ердөө л тал нь унтдаг, удирдлагын багт байгаа нөхөд чинь таныг ямар ч үед орхихгүй, таны шилдэг дэмжигч нар ерөөс дэмжлэг харилцаагаа таслахгүй байх юм бол та Есүсээс илүү зүйлийг хийжээ гэсэн үг.

Хэрэв чи Есүс Христийн үхэл амьдралын тухай киног үзсэн бол үйл явдлыг нь оюун ухаандаа дахин хараарай. Мөнгөний уут баригч нь мөнгийг нь хулгайлаад итгэмжит гол удирдагч нар нь урваад чухал үед удирдлагын багийнхан унтчихсан ерөөс сэрэхгүй сэрүүн үедээ түүнийг хаян зугтсан мөн хамгийн ойрын дэмжигч нь түүнийг бүүр хараан байж үгүйсгэхийг харна. Эндээс асуулт гарч ирж байна. Та ийм хүмүүсийн төлөө загалмай уруу явах уу? Ийм хангалтгүй чуулганы төлөө өөрийгөө золиос болгон өгөх үү? Есүс үүнийг хийсэн.

Тиймээс бидний удирдагч Есүс байхад ийм зүйл тохиолдож байгаа юм чинь бүх чуулганы удирдагч нарт олон төрлийн асуудал тулгарч байгаа. Бидэнтэй адилхан хангалтгүй төгс бус бүлэг хүмүүстэй Есүс ажиллаж байсан. Тэр чуулганыг хайрлаад чуулганы төлөө өөрийгөө өгсөн. (Ефес 5:25). Бид дэлхийд аврал авчруулахаар сонгосон Бурханы хайрын нэгдэл түүний жишээгээр чуулганыг хайрлах бид нар түүнийг бидэнтэй уулзахад бэлтгэж байгаа хөдөлгүүр билээ. Есүс чуулганыг хайрлан итгэсэн, энэ бол дэлхийн найдлага билээ! Тэрбээр орон нутгийн чуулганууд эрүүл болох цорын ганц арга замыг мэддэг байсан бөгөөд дэлхий даяар Түүний үлгэр жишээ нь хүмүүсийг чуулганыг өсгөн илгээлтэнд явуулахад зориулагдсан юм.

## Есүстэй Зөвшилцсөн Төлөвлөгөө

Есүс өөрийн бодол санаа онгод орж авсан санаагаа хуваалцсанаар дэлхийг өөрчилсөн. Ариун сүнсний хүчээр Христийн хөдөлгөөний тэсрэлтээр Христ итгэлт Монгол чуулганы хөдөлгөөн 21 дүгээр зуунд эхэлсэн. Есүст өөрийн чуулганы төлөө алсын хараа бий. Тэр сүмийн төлөө болон түүний байж болох бүх зүйлд өөрийгөө зориулав. Тэрээр Бурханаас хүлээж авсан санаа бодол сургаалаар дэлхийг өөрчилсөн. Тэрээр хэлэхдээ, Учир нь Би Өөрөөсөө яриагүй, харин юу хэлж, юу ярих тушаалыг Намайг илгээсэн Эцэг Өөрөө өгсөн юм (Иохан 12:49).

> Бид дэлхийд аврал авчруулахаар сонгосон Бурханы хайрын нэгдэл түүний жишээгээр чуулганыг хайрлах бид нар түүнийг бидэнтэй уулзахад бэлтгэж байгаа хөдөлгүүр билээ.

Бид хэзээ ч Бурханы хүчээр сэргээгдэн гарч ирсэн бодол болон санаануудыг
дутуу үнэлдэггүй. Ийм учраас бид долоо хоног бүр Христ итгэлт Монгол чуулганд маш их эрч хүчтэйгээр зааж номлож байна!

Бурхан хүмүүсийн амьдралын өөрчлөлтийг авч үзэхгүйгээр тэр чигээр нь хэрэглэдэг. Есүс бүгдийн болон бүх чуулганы төлөө үхсэн. Тэр танай цуглааныг өөрийн зүрх сэтгэл оюун ухаандаа тээж явдаг. “Би чиний үйлс, хайр, итгэл, үйлчлэл, тэвчээр болон эцсийн үйл чинь эхнийхээсээ илүү гэдгийг мэднэ” (Илчлэлт 2:19).

Есүс биднийг өөрийн барьж буй сүмээ хамт барилцуулахаар дуудсан. (Матай 16:18). Бид усан үзмийн модтой байнга холбоотой байснаар бид үр бүтээлтэй байн, (Иохан 15:1-2), өөрсдийнхөө санаанаас цааш ярихыг сурч байна”. Бид Эцэг Бурхан болон Ариун Сүнсний юу шивэгнэж байгааг мэдэрч байх ёстой. (1Хаад 19:12, Исаиа 30:21, Иохан 10:27). Есүсийг сонсож байж бид сүмдээ хайр болон үйлчлэлээр юу хэлэх, үүнийг хэрхэн хэлэхийг заавал сурах ёстой

> Бид хэзээ ч Бурханы хүчээр сэргээгдэн гарч ирсэн бодол болон санаануудыг дутуу үнэлж болохгүй.

Бидэнд үг болон Сүнсний зааварчилгаа хэрэгтэй. (Иохан

14:26) мөн биднийг цэвэр болгоно. (Иохан 15:3). Агуу зөвшилцсөн төлөвлөгөө бол бид илүү алсын стратеги төлөвлөгөөгөөр цэнэглэгдсэн мөн бидний үнэхээр итгэж байгаа Христийн бие **Үгээр дамжуулан** болон Ариун Сүнсээр хамтдаа дуудагдсан зүйл юм. Саад бэрхшээлтэй нүүр тулах нь (Иохан 15:5), бидний бодол санааг өөрчлөх бичээсийн хүчтэй хамааралтай болгодог шалтгаан гэдгийг бид гэрчилж чадна (Иеремиа 20:9, 23:29). Бид Христийн оюун ухаантай байхыг хүсдэг. (1Коринт 2:16). Тэр биднийг хэлбэржүүлж Христтэй адил болох хүсэл тэмүүлэлийн сүнсээр дүүргэдэг. Энэ нь үргэлжлүүлэн түүнтэй хамт зөвшилцсөн төлөвлөгөөг хайх шалтгааныг бидэнд өгч байна.

Бид сүмийн илгээлтэнд илүү анхаарахдаа үндэстэнд Христтэй адил дагалдагчийг бэлтгэхийн тулд Есүсийн төлөвлөгөөг дагаж суралцах хэрэгтэй байна. Үүнийг цэнэглэх асуулт нь ийм байж болох юм Есүс энэ тухай юу гэж бодох вэ? Тэр үүгээр ямар мэдрэмж авах вэ? Есүс юу хийсэн бэ? Бид бүхэн өөрсдөө залбирч байхдаа залбирагч нарынхаа төлөө ийм байдлаар Эзэн таныг уйлуулж буй зүйлийн төлөө намайг уйлуулаач таныг инээлгэж байгаа зүйлийн төлөө намайг инээлгээч зүрхийг тань хөдөлгөж буй зүйлд та миний зүрхийг хөдөлгөөч хэмээх залбирлын арга замыг олно.

> Бид Есүсийн бодож байгаачлан бодож, түүний мэдэрч байгаачлан мэдэрч, түүний уйлж буй зүйлийн төлөө уйлахыг хүсдэг. Мөн түүний хүслээр бидний хүсэл газарчлуулж бидний үнэ цэнэ түүний үнэ цэнээр илэрхийлэгддэг байхыг хүсдэг.

Бид илүү их өсөж Есүсийн бодож байгаа зүйлийг бодож, түүний мэдэрч байгаа зүйлийг мэдэрч, түүний уйлсан зүйлийн төлөө уйлж байхыг хүсдэг. Мөн түүний хүслээр бидний хүсэл газарчлуулж бидний үнэ цэнэ түүний үнэ цэнээр илэрхийлэгддэг байхыг хүсэж байна. Бас бидний сүнс Түүний Сүнсээр дүүргэгдэж бидний зүрх сэтгэл түүний зүрх сэтгэлтэй зэрэгцэн байгаасай гэж хүсэж байна. Есүс хэрхэн яаж бодож сэтгэж байсан шиг бид бас бодож сэтгэж сурмаар байна. Түүний төлөвлөгөө манай сүмийн төлөвлөгөө байгаасай гэж хүсэж байна. Есүсийн ариусгагдсан дагалдагч нар энэ нь биднийг сүнсний гэмшлийн хамт удирдан амьдарна.

Грекээр гэмшил гэсэн үгийн тодорхойлолт энэ төрлийн ариусгагдсан зүрхийг өсгөх “Metanoia,” буюу “санаа бодлыг өөрчлөх

амьдралын өөрчлөлт гэсэн утгатай юм.” Бидний сүнсийг дүүргэж, сүмийг хамтдаа дууддаг Ариун Сүнс биднийг Үг уруу дагуулдаг. Дээр цохож хэлсэн зорилгыг даган мөрдөж, Есүсийн төлөвлөгөөтэй нийцүүлэн сонгосон шийдвэрээ бид танд хэлж өгөхийг хүсч байна.” Тийм биш ч, бид “цэвэр ариун хандлагтай” байж чадна.

Цаг өнгөрөх тусам бидний оюун бодол аажмаар шинэчлэгдэж байгааг бид мэдэрдэг. Бид өөрсдийн бодлоор удирдагдах нь илүү ихээр багасаад Есүсийн бодол илүү ихээр биднийг тогтвортойгоор залж байна. Есүстэй Зөвшилцсөн төлөвлөгөө нь үйл явц юм. Энэ тухай элч Паул дүрслэн хэлэхдээ Энэ үеийн явдалд нийцэлгүй, харин оюун санааныхаа шинэтгэлээр өөрчлөгдөж байгтун! Тэгвэл Бурханы сайн, тааламжит, төгс төгөлдөр таалал юу болохыг таних болно (Ром 12:2).

Хэрэв бид чуулган Есүсийн илгээлтэнд хүрч үйлчилье гэвэл Иймээс та нар яв, **бүх үндэстнийг дагалдуулагтун,** Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээ, та нарт тушаасан бүгдийг минь сахин биелүүлэхийг тэдэнд заа гэсэн (Матай 28:19), энэ бидний зориулалт бидний амлалттай даруугаар өөрчлөгдөн биелж эхлэх болно. Энэ нь Бурхан бидний оюун ухааныг өөрийн үгээр шинэчилэхийг шаардаж бид Түүний төлөвлөгөөг хүлээн авч өөр чуулганы удирдагч нартай зохицон үйлчлэх болно. Үүний үр дүнд Есүстэй хамт мөр зэрэгцэн чуулганы төлөө алсын харааг бий болгож ижил бодолтой, ижил хайр, нэг сүнс, нэг зорилготой" байх болно (Филиппой 2:2). Таньд Бурханы энэ хөдөлгөөний нэг хэсэг болох сонирхол байна уу? Хэрвээ зүрх чинь хариу өгч байвал энэ хөдөлгөөн таны амьдралд аль хэдийн орж эхэлсэн байна гэсэн үг!

**Эргэцүүлэх Асуулт – 4 Бүлэг**

1. Та бидний бодол болон үйлдэлийн мэдэгдэлийг зөвшөөрч байна уу? Бидний үйлдэл бидний зуршлыг хурцалж байна уу? Бидний зуршил бидний зан чанарыг хурцалж байна уу? Үүнийг бүлэгтэйгээ зөвлөлдөөрэй. Та өөрийн амьдрал дахь ийм жишээг хэлж өгнө үү?
2. Мэдэгдэлийг эргэцүүлэх: “Бид Есүсийн хийж байсан үйлсийг гаргах ёстой Хэрэв Есүс бидний дотор сүмийг удирдаж байсан бол бид яг л түүний үйлдсэн шиг үйлдэл хийх ёстой. Учир нь Тэр. Хэрэв Есүс танай чуулганы удирдагч байсан бол юуг өөрөөр хийх байсан бол? Тийм бол яг юуг?
3. “Чуулган бол өөрийгөө **соёлт хэлбэрт төлөвшүүлэн** зохион

Бид гэмшлийн сүнстэй хамт амьдардаг. … Бидний сүнсийг дүүргэж, сүмийг хамтдаа дууддаг Ариун Сүнс биднийг Үг уруу дагуулдаг. Хэрвээ зүрх чинь хөдөлж байвал энэ хөдөлгөөн таны амьдралд аль хэдийн орж эхэлсэн байна гэсэн үг.

байгуулдаг түүхэн бодит зүйл.” Дэлхийн янз бүрийн хэсэгт сүмүүд өөр өөр байдгийн жишээг та мэдэх үү? Тэд өөр өөр соёлд хэрхэн ялгаатай байх вэ? Нэг хотод маш их өөр сүмүүд байж болох уу? Тийм бол яагаад?

4. Христ итгэлт Монгол чуулганууд бүгд адилхан байх ёстой юу? Эсвэл нэг нэгнээсээ өөр байх ёстой юу? Яагаад эсвэл яагаад үгүй гэж? Хэрэв бид өөр өөр Христ итгэлт Монгол чуулгануудтай бол бид эрүүл, өсөлттэй байхын тулд бидний хувьд ямар нийтлэг зүйл байх ёстой вэ? Тиймээс бидэнд шинэ удирдагчдыг босгон гаргаж ирэх үр дүнтэй тогтолцоо бий юу?
5. Чуулган заавал өөрийн байртай байх ёстой юу? Мөн томилогдсон пастортай байх ёстой юу? Энэ нь тодорхой хэмжээтэй байх ёстой юу? Чуулган заавал Ням гаригт мөргөл хийх ёстой юу? Тийм бол Яагаад?
6. Чуулганы итгэгч нар цаг үргэлж илгээлтийн эзэд шиг бодож эхэлбэл чуулганы үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдөх вэ?
7. Чуулганы арга барил хэв маяг болон стратеги өөрчлөгдөхөд чуулган маань чуулган хэвээрээ байх уу? Үргэлжлүүлэн өөрчлөгдөж буй байдал нь “бүх дэд соёл, бичил хам сэдэвт” нэвтрэхэд Христийн Монгол чуулганд хэрхэн тусалдаг вэ? Энэ байдал ямар харагдах бол?
8. Дэлхий даяарх чуулганы хэрэглэдэг доод хэмжүүрийн талаар дөрвөн зүйлийн талаар зөвлөлдөөрэй. Та эдгээр зүйлстэй санал нэг байна уу? Танд үүн дээр үнэхээр нэмж хэлмээр зүйл байгаа юу? Яагаад эсвэл яагаад үгүй гэж?
9. Есүс чуулганыг эхлүүлэхдээ төгс бус чуулгантай хамт эхлүүлсэн талаар зөвлөлдөөрэй. Тэгэхээр таньд өөрийн тань төгс бус чуулганы талаар ямар мэдрэмж байна вэ?
10. Есүс яагаад ийм төгс бус хүмүүсийн төлөө өөрийгөө золиос болгон өргөхийг хүссэн бэ? Та өөрийн чуулганы төлөө ийм зүйл хийхийг хүсэж байна уу? Есүс энэ талаар бидэнтэй хэрхэн холбогдож

байгаа талаар зөвлөлдөөрэй. Түр завсарлаад сүмийнхээ төлөө зориулалт гаргах төвшин дээшлэхийн төлөө залбир.

11. Та бүхэн зохиогчийн дүрслэн бичсэн сүнсний гэмшилтэй амьдарч байна уу? Та Есүстэй хэрхэн илүү сайн зохицож чадах вэ? Таны бодлоор Есүс хэрхэн яаж үргэлжлүүлэн өөрчлөгдөх замыг хүсдэг вэ? Үүнийг өөрийн бүлэгтэйгээ хуваалцаарай. Тэднээс Есүсээр өөрчлөгдөхөд нээлттэй байхын тулд өөрийнхөө төлөө залбирахыг тэднээс хүсээрэй.

## 5 Назарын Харилцан Хамаарлыг Баримталдаг Шалтгаан

Одоо бид ойлголоо—Бурхан бол нүүр тал хардаггүй бөгөөд Түүнээс эмээгч, зөвийг үйлдэгч **алив үндэстний** хүн Түүнд таалагддаг гэдгийг би үнэнээр ойлгов. (Үйлс 10:34-35)

Ямар гайхалтай Бурханы бүтээл вэ! Ер бусын сайхан загвар! Ямар тэнгэрлэг стратеги төлөвлөгөө вэ! Бурхан бүх дэлхий даяарх төгс бус Есүст итгэсэн хүмүүсийг тэнгэрлэг бүлэгтээ цуглуулна. Эдгээр бүлгүүд магтаал, хамт олон, урам зориг, бусдад үйлчлэх зорилгоор тогтмол цуглардаг. Тэд Есүс ба Эцэгтэй хамт байдаг гэдгээ дэлхий нийтэд гэрчлэхийн тулд бие биентэйгээ мөр зэрэгцэн явдаг. (Иохан 17:21-23).

Библид сүм гэдэг үгийг хоёр аргаар хэрэглэдэг. Эхлээд энэ нь өөр өөрийн цаг хугацаанд амьдарч байсан Христэд итгэгч бүрийг дурдахад хэрэглэгддэг. Энэ сүм бол “бүх дэлхийн” сүм бөгөөд Библи дээр энэ үгийг дөрвөн удаа хэрэглэсэн. Өөр 110 удаа Библи дээр чуулган гэдэг үгийг сүнсээр холбогдсон итгэгчдийн биеийг төлөөлүүлэн хэрэглэсэн байдаг. Коринт дахь чуулган, Филиппой чуулган, Тесалоник дахь чуулган болон бусад бүх олон мянган —чуулганууд — Христэд итгэгч хүн бүр бие биетэйгээ холбогдсон байсан.

Анхны чуулганы зааж байснаар хэн нэгэн Христэд итгэгч, нутгийн Христийн бие Бурханы дэлхийн хөдөлгөөний хэсэгтэй холбогдоно гэдэг төсөөлөхөд бэрх зүйл байв. Шинэ Гэрээнд Христэд итгэгч нарт өгсөн хэдэн арван тушаалыг бид нар чуулгантай идэвхтэй холбогдож чуулганы идэвхтэй хэсэг болохгүйгээр дагах боломжгүй юм. Шинэ Гэрээнд олон арван удаа бие биенээ хайрла (Иохан 13:34), “бие биедээ зориулалт гарга бие биенээ хүндэл (Ром 12:10), бие биетэйгээ таарамжтай бай (Ром 12:16), бие биенээ хүлээн ав (Ром 15:7), бие биедээ үйлчил (Галат 5:13), нэг нэгэндээ зааварла (Ром 15:14), “нэг

нэгнийхээ ачаанаас үүрэлц" (Галат 6:2), "бие биедээ аядуу зөөлөн," "нэг нэгнээ уучлан" (Ефес 4:32), "нэг нь нөгөөдөө захирагдан" (Ефес 5:21), "бие биенээ урамшуулан," "бие биенээ босгон" (1Тесалоник 5:11), "бие биенийхээ эсрэг бүү гомдолло" (Иаков 5:9), "бие биенийхээ өмнө улайн гэмш," "бие биенийхээ төлөө залбир" (Иаков 5:16), "бие биедээ **зочломтгой** бай" (1Петр 4:9), бие биетэйгээ эвтэй" (1Петр 3:8), цөөн хэдийг нэрлэлээ!

> Үйлс номын туршид Ариун Сүнс сүмийг орон нутгийн сүмүүдтэй холбоотой байдлыг нь хэвээр хадгалахын тулд удирдан чиглүүлдэг. Теологийн үг нь "харилцан хамаарал."

Үйлс номын туршид Ариун Сүнс сүмийг орон нутгийн сүмүүдтэй холбоотой байдлыг нь хэвээр хадгалахын тулд удирдан чиглүүлдэг. Теологийн үг **"харилцан хамаарал."** Бурханы хөдөлгөөн нь Бурханы хүмүүсээр дамжуулан онцгойлон сүм орон нутгийн түвшнөөс илүү өргөжиж байсан газар харилцаа холбоог тогтоож ажиллахыг шаарддаг байсан. Ариун сүнс Анхны чуулганыг еврей ба харь хүмүүсийн соёлтой нөхцөл хэлбэрийн зохион байгуулалттайгаар байлгаж байсан ч тэд харилцан хамааралтай хэвээр байв. Филипийг Самари уруу явуулсанаар энэ хөдөлгөөн ихээр дэлгэрч эхэлсэн. (Үйлс 8:5). Иерусалим дахь элч нар Петр Иохан нарыг Самари уруу тэндхийн хөдөлгөөнийг цэнэглэж Ариун Сүнсийг ойлгон хүлээн авахад туслуулахаар явуулсан. (Үйлс 8:14-15). Ариун Сүнс Филипийг газарчлан Етиоф улсын тайган амбантай уулзуулж хөдөлгөөний сэргэн мандалтыг Самараас Африк уруу тараасан (Үйлс 8:26-39).

Петр Иудейн заншлыг эвдэж харь үндэстэн болох Ромын зуутын даргын гэрт айлчилсанаар хөдөлгөөн бүх төрлийн үндэстэн ястны соёлын саадыг даван тархсан. (Үйлс 10:2728). Петрийн үзсэн үзэгдэл Бурхан түүнээс эмээгч зөвийг үйлдэгч **бүх үндэстний** хүмүүсийг хүлээн авна гэдгийг нээн илрүүлж өгсөн". (Үйлс 10:35). Бурханы дэлхийн хөдөлгөөний үрнүүд Бурханы хүмүүсээр шинэ боломжуудын хамт тэсэрч байна!

Хөдөлгөөн Ариун Сүнсээр цэнэглэгдэж Паул Барнаб нарыг Кипр тэгээд (орчин цагийн) Турк улсын дагуу илгээсэн. (Үйлс 13:1-14:28). Бурханы энэхүү хөдөлгөөн нь сүмийн үйл ажиллагаанд хэзээ ч "сүнсний бие даасан байдал" гэсэн зүйлийг хөгжүүлээгүй.

Бид анхны чуулганы сүнсний дотоод- холбогдол болон **"харилцан хамааралтай"** байдал нь үргэлж хэвээрээ байсныг олж хардаг." Ийм учраас Назарын Чуулган бид бидний харилцан хамаарал Шинэ Гэрээний үндэс суурьтай гэдэгт хүчтэй итгэдэг.

Сүмийн үйл ажиллагаа, онолын тухай үндсэн асуултууд гарч ирсэн учраас Паул Барнаб нар зарим итгэгч нарын хамт сонгогдон Иерусалим уруу явж элч нар болон ахлагчидтай уулзаж (Үйлс 15:2) асуудлын талаар зөвлөлдсөн. Яагаад? Учир нь тэд хэзээ ч бие даасан бус харин харилцан хамааралтай байсных юм. Энэ нь сүнсний хамт сүмийн үйл ажиллагаа нь Ариун Сүнс болон бидэнд сайн санагдаж байна. (Үйлс 15:28).

Үйлчлэлийн зөрөөнөөс болж Паул Барнаб хоёрын хооронд салах нөхцөл үүссэн (Үйлс 15:39), гэхдээ энэ нь Паулын чуулгантай харилцан хамааралтай байх зориулалтанд нь саад болоогүй. Паул Силас хотуудаар дайрч өнгөрөхдөө элч нар болон ахлагчдын Иерусалимд гаргасан айлдварыг сахин баримтлахыг тэдэнд дамжуулав. (Үйлс 16:4).

> Бурханы хөдөлгөөн нь Бурханы хүмүүсээр дамжуулан онцгойлон сүм орон нутгийн төвшнөөс илүү өргөжиж байсан газар харилцаа холбоог тогтоож ажиллахыг шаарддаг байсан.

Энэ шалтгааны улмаас "чуулганууд итгэл дотор хүчирхэгжиж өдөр бүр тоогоор өсөж байв" (Үйлс 16:5). Анхны чуулган болон чуулгануудын хооронд "харилцан хамаарал" үүссэн баталгаа нь маргаангүй юм. Чуулган соёлын нөхцөлт хэлбэрүүдэд (Еврей болон Харь үндэстний чуулганууд хамтдаа) үйл ажиллагаа явуулдаг байсан тул тэдгээр чуулганууд өөрсдөө бие даан үйл ажиллагаа явуулахыг хэзээ ч эрэлхийлж байгаагүй. Бүгд чуулганы харилцан хамааралд гүн итгэл үнэмшилтэй ажилладаг байв. Бурханы хүмүүсээр дамжуулсан Бурханы хөдөлгөөн нь хэт их үнэ цэнэтэй байсан тул хөдөлгөөн доторх чухал бус зүйлсээ тэд хувааж заагласан.

> Анхны чуулган болон чуулгануудын хооронд "харилцан хамаарал" үүссэн баталгаа нь маргаангүй юм.

Шинэ Гэрээнд гардаг эдгээр тодорхой жишээнүүдийг дагаж

доор хэлсэн библийн долоон шалтгаанаар Христ Итгэлт Монгол Чуулганы хөдөлгөөн дэх бусад сүмүүдтэй харилцан хамааралтай ажиллахыг маш ХҮЧТЭЙгээр урамшуулж байна. Нэгт, **бид үүгээр Христтэй адил байдалд төлөвшиж байна**. Нөхөрлөлгүйгээр төлөвшиж чадахгүй. Чуулган бол Бурханы сонгосон биднийг түүнтэй уулзуулж түүнтэй хамт цагийг өнгөрүүлж Бурхантай хамт үүрд мөнхөд хамтдаа байхад сургадаг сургалтын газар юм. Тэр чуулганыг үгээр дамжуулан усанд угааж цэвэрлэн, ариусгаад (Ефес 5:26-27). Өөр өөр нийгэмлэг, соёл, улс орны ах, эгч дүүс нараа хүлээн авсанаараа бид Христтэй адил болох шинэ төвшинд шилжиж байна.

Хоёрт, **чуулган бол бидний сүнслэг гэр бүл маань юм.** Паул элч бичихдээ, “Тиймээс бид боломжтой үедээ бүх хүнд, юуны түрүүнд итгэлийн гэр бүлийн гишүүдэд сайныг үйлдэцгээе” (Галат 6:10). Манай сүнслэг гэр бүл, сүм бол бидний махан биеийн гэр бүлийнхнээс ч удаан байх болно. Бид Мөнхийн улсад сүмийн гэр бүлтэйгээ үүрд мөнхөд амьдарна. Манай Назарын сүлжээ бидний сүнслэг гэр бүл энэ нь зөвхөн орон нутгийнх биш бүс нутгийн бүүр дэлхийн хэмжээнийх юм. Бид дэлхийгээр аялж дэлхийн итгэгч гэр бүлийн гишүүдтэйгээ шууд уулзах боломжтой.

Гуравт, **Бид чуулганд сүнслэг билэг авьяасаа нээн илрүүлж ашиглах боломжтой.** Элч Паул бичихдээ, “Ах дүү нар аа, сүнслэг бэлгүүдийн талаар та нар мэдлэггүй байхыг би хүсэхгүй байна” (1Коринт12:1). “Хүн бүр хүлээн авсан бэлгээрээ бие биендээ Бурханы олон төрлийн нигүүлслийн сайн нярвууд шиг үйлчил” (1Петр 4:10). Хэрвээ бид Бурханы өгсөн сүнслэг бэлгээ ашиглан Христийн чуулганыг босгон байгуулахад туслахгүй бол, чуулган Есүсийн дэлхий дээрх ажил нь тийм сайн байж чадахгүй. бүхэл бие нь Христээр хайр дор өөрийгөө босгон барихын тулд биеийн өсөлтийг бий болгодог.” (Ефес 4:16). Хэсэг нэгбүрийн зохистой үйл ажиллагааны дагуу холбоос болгоноос хангаж байдаг зүйлээр хамтдаа холбогдон нийлж буй бүхэл бие нь Христээр хайр дор өөрийгөө босгон барихын тулд биеийн

> Бидний сүнслэг гэр бүл энэ нь зөвхөн орон нутгийнх биш бүс нутгийн буюу дэлхийн хэмжээнийх юм. Бид дэлхийгээр аялж дэлхийн итгэгч гэр бүлийн гишүүдтэйгээ шууд уулзах боломжтой.

өсөлтийг бий болгодог. Орон нутгийн сүмд хэрэгтэй бүх сүнслэг бэлгийг Бурхан тэр сүм дотор өсгөж чаддаг. Дэлхийн өнцөг булан бүрт байдаг сүмийн янз бүрийн соёлын хэлбэрээр илэрхийлэгддэг янз бүрийн сүнслэг бэлэг нь биднийг илүү сайн болгодог.

Дөрөвт, **Чуулганд байгаа бид сүнслэг хамгаалалтыг хүлээн авдаг**. Бичээс Пасторуудад зааварчлахдаа, Бурхан Өөрийн цусаар Өөртөө өмчилж авсан Бурханы чуулганыг хариулуулахаар Ариун Сүнс та нарыг харгалзагч болгосон бөгөөд та нар өөртөө болон бүх сүрэгт анхаарал тавь. Намайг явсны дараагаар, сүргийг үл өршөөх хэрцгий чононууд та нарын дунд орно гэдгийг ч би мэдэж байна" (Үйлс 20:28-29). Чуулганы хариуцлагын нэг хэсэг нь хүмүүсийг алдаа зөрчлөөс туслгаарлын үнэн уруу явахад туслах сүнслэг хамгаалалтанд хэвээр үлдээх юм.

> Пасторууд зөвхөн өөрсдийн чуулган болон удирдагчдад хариуцлагатай байдаг төдийгүй удирдагч нар пасторууд болон бие биедээ хариуцлагатай байдаг… Хариуцлагатай байх нь бидний хамгийн агуу хүч чадлын нэг хэсэг юм.

Тавт, **Чуулган биднийг харилцанхамаарлындагуу сүнслэг хариуцлагаар хангаж өгдөг.** Библи дээр хэлэхдээ, “Ах дүү нар аа, хэрэв хэн нэг нь гэмд автсан бол сүнслэг та нар түүнийг дөлгөөн сүнсээр шинэчлэн засагтун. Ингэхдээ өөрийгөө ч хянаж бай. Эс тэгвэл чи ч мөн уруу татагдах вий. Нэг нэгнийхээ ачаанаас үүрэлц. Тийнхүү Христийн хуулийг хэрэгжүүлэгтүн“ (Галат 6:1, 2). Хүмүүс чуулгантай холбогдох ёстой чухал шалтгаан нь хүн бүхэн өөрсдийн сүнслэг өсөлтөндөө хариуцлагатай байх хэрэгтэй байдагтай холбоотой юм. Энэ бол Есүсийн заасан сургаалд дуулгавартай байх өсөлтийн асуудал (Матай 28:19, Иохан 14:23-24). Чуулганы гишүүн бүр өөрсдийн чуулгандаа сүнслэг хариуцлагтай байх хэрэгтэй. Чуулган дахь үйлчлэгч бүр бусад үйлчлэгч нартай хариуцлагатай хандах ёстой. Америкийн Нэгдсэн Улсад болон Монгол Улсад байгаа Христич Монгол Чуулганууд хамтран болж бие биедээ их үр нөлөөтэй мөн хариуцлагатай байдаг байх ёстой.

Назарын хөдөлгөөнөөс сонгогдсон **пастор бүр** бусад пастор болгонтой чуулганыг хариуцлагтай харилцан хамааралтай байгааг хянаж тусална. Энэ нь чуулганы хөдөлгөөний эрүүл болон өсөлттэй

үйл ажиллагаа явуулах зам юм. Христ итгэлт Монгол Чуулган бие биедээ хариуцлагтай харилцан хамааралтай өсөлттэй байх нь Христич Монгол Чуулганы Хөдөлгөөний эрүүл байдал, хүч чадал өсөлтийг ирж буй жилүүдэд тодорхойлох болно!

Зургаад, **эрүүл Христ Итгэлт Монгол Чуулганы Хөдөлгөөн нь орон нутгийн Монгол чуулгануудад тусдаа хийх боломжгүй зүйлийг хамтдаа хийх боломжийг олгодог.** Нутгийн чуулганууд хамтдаа мөр зэрэгцэн явбал тэд зогсошгүй болно. Тэд олон нийттэй холбоотой байдаг. Эдгээр нь АНУ болон бусад улс орнуудын сүмүүдтэй холбоо, харилцан хамааралтай байдаг. Тэд өөрсдийн нутаг орны болон бусад улс орны бусад сүмүүдтэй мөн сүлжээнд холбогдсон бусад сүмүүдээс суралцах боломжтой. Чуулган харилцан хамааралтай, эрүүл, өсөлттэй байдаг нь **чуулганы хөдөлгөөнөөс** бид өөрсдөө хэзээ ч хийж чадахгүй зүйлийг хамтдаа хийхээр зөвшилцсөн төлөвлөгөөний үр дүн юм.

Хамгийн сүүлд, **чуулган нь Ариун Сүнсээр бүтээгдэж бидэнд Христийн тушаасан Агуу Захирамжийг гүйцэлдүүлэхэд тусалдаг**. Христэд итгэгч хүн нэг бүр “бүх үндэстнүүдэд дагалдагч бэлтгэхээр” дуудагдсан (Матай 28:19). Салангид мөн тусгаарлагдмал орон нутгийн сэтгэлгээтэй, тул дэлхийн сэтгэлгээтэй Христэд итгэгчид байгаасай гэж бүх итгэгч нарыг Бурхан хүсдэг. Энэ бол орон нутгийн нийгэмд хийж буй арга барилыг чуулганы хөдөлгөөнтэй холбосноор орон нутагт асар их нөлөө үзүүлэх, сүлжээг бий болгох сургах нөөц бүрдүүлэхэд мөн Бурханы шинэ удирдагчдыг босгон Монголд, цаашилбал гадаад улс орнуудад хүргэхэд зориулагдах юм!

Назарын хөдөлгөөн бол үндэстэн дамнасан хөдөлгөөн бөгөөд дэлхий даяар зургаан бүсийн оффистой. Ихэнх хүмүүс Айпл компани компьютэр гар утас зардаг гэдгийг сонссон байдаг. Тэд бол дэлхий даяар чинээлэг олонд танигдсан дэлхийн анхны 1 тэрбумаас илүү доллар цуглуулж чадсан анхны компани. Айпл компанийн зах зээлийн түвшин ДНБ ээс их байна (Дотоодын нийт бүтээгдэхүүн) Дэлхийн банкны ДНБ ийн мэдээлэлээр 199 орны 183-ийн 5-т багтдаг. Айпл компани чуулгануудаас илүү их мөнгөтэй байна. Гэвч Айпл компани ердөө дэлхийн 24 оронд л (мөнгө олдог газар нь) үйлдвэрлэлээ явуулдаг. Назарын хөдөлгөөн дэлхийн 160+ Айпл компаниас 7 дахин олон оронд үйл ажиллагаа явуулж байна. Бид улс орнуудын эдийн засгийн хүчин зүйлийг харж нэвтэрч ордоггүй. **Бид дэлхийн ядуу буурай орнуудад ажилладаг.** Бидний төлөвлөгөө бол Есүс Эзэний

төлөвлөгөө!

Учир нь бид Бурханы дэлхийн хөдөлгөөн учраас одоо олон арван улсаас илгээлтийн эздийг хамгийн их хэрэгцээтэй, тохирсон байршил руу илгээдэг. Бид цөөн хэдэн улс орнуудаар болон улс төр геополитикийн сөрөг нөлөөллөөр ч хязгаарлагдахгүйгээр ажилладаг. Назарын дэлхийн хөдөлгөөн бүх улс орныг энэ тэнцүү хэмжээнд авч үздэг. **Аль нэг улсыг бусдаас илүү гэж авч үздэггүй.** Назарын чуулганы 21 дүгээр зууны илэрхийлэл нь Бурханы элч Петрээр өгөгдсөн тэр үзэгдэл билээ. “Петр ам нээж,—Бурхан бол нүүр тал хардаггүй бөгөөд Түүнээс эмээгч, зөвийг үйлдэгч алив үндэстний хүн Түүнд таалагддаг гэдгийг би үнэнээр ойлгов” (Үйлс 10:34-35). Бурханы ард түмнээр дамжуулж явагддаг ийм олон улсын, харилцан хамааралтай Бурханы хөдөлгөөнд оролцох нь ямар их аз завшаан бэ!

> Айпл компани ердөө дэлхийн 24 оронд л үйлдвэрлэлээ явуулдаг. Назарын хөдөлгөөн дэлхийн 160+ Айпл компаниас 7 дахин олон оронд үйл ажиллагаа явуулж байна.
> Назарын дэлхийн хөдөлгөөн бүх улс орныг энэ тэнцүү хэмжээнд авч үздэг. Аль нэг улсыг бусдаас илүү гэж авч үздэггүй.

**Асуулт Эргэцүүлэл – 5 Бүлэг**

1. Бие биетэйгээ дээрх Шинэ Гэрээн дэх жагсаалтын талаар зөвлөлдөөрэй. Эдгээр нь таны чуулганд одоо хэрхэн хэрэгжиж байна вэ? Цаг гарган танай чуулган анхны чуулгантай илүү адилхан болох арга замын талаар Бурханд талархаарай. Сайжруулахын тулд ямар практик алхам хийх хэрэгтэй вэ?
2. Бид орон нутгийн чуулган болон гадны чуулгануудтай холбоо хэвээр хадгалах харилцан хамааралтай байхаар дуудагдсан. Анхны чуулган чуулгануудын дунд харилцан хамааралтай байсан жишээг гарган зөвлөлдөөрэй.
3. Анхны чуулган Иудей болон Харь үндэстний чуулганыг соёлын нөхцөлт хэлбэрээр зохион байгуулж байхдаа тэд хоорондоо харилцан хамааралтай байсан. Таны чуулган хэрхэн бусад чуулгантай холбогдох холбоогоо илүү сайнаар хэвээр хадгалах вэ?
4. Харилцан хамааралаа хэвээр хадгалах библийн долоон шалтгааны

талаар зөвлөлдөөрэй. Та аль хэсэгт илүү ялгарч гарч байна вэ? Аль хэсэг нь таньд шинэ зүйл байна вэ?

5. Дээр бичсэн Шинэ Гэрээн дэхь жагсаалтанд зохиогч яагаад сүнсээр эрүүл пастор зөвхөн өөрийн чуулганаас гадна бусад пасторуудад хариуцлагтай байдлыг шаарддаг талаар зөвлөлдөөрэй. Пасторууд бие биедээ хариуцлагтай байх ёстой гэдэгт та санал нийлж байна уу? Та энэ харицлагтай байдал сүнслэг эрүүл байдал гэдэгт санал нэг байна уу? Яагаад эсвэл яагаад үгүй гэж?
6. Чуулганы удирдагч нар хариуцлагтай байдлыг чуулганы гэр бүлдээ хадгалахгүй бол ямар аюултай нүүр тулах вэ?
7. Дэлхийн Назарын хөдөлгөөн Айпл компаниас хэрхэн өөр байгааг зөвлөлдөн ярилцаарай. Энэ зүйл таны чуулганы талаарх бодлыг өөрчилсөн үү? Хэрхэн?

# 6 Үржин Өсөх Тушаалыг Дэлгэрүүлэх

“Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Буудайн үр газар эс унан, эс үхвээс тэр ганцаараа үлдэнэ. Харин тэр үхвээс олон үр гаргана.” (Иохан 12:24)

Есүс Эзэн шилдэг харилцааг тогтоогч. Товч хэллэгээр хүчтэй санааг агуулан ярихын хүчийг Тэр маш сайн мэддэг. Өдөр тутмын амьдралаас сэдэвлэсэн багц ойлголтыг бий болгож, өнөө 2000 жилийн дараа ч хүмүүсийн ярьж буй асуудлын шийдлийг нь гаргаж ирсэн. Түүний өгүүлсэн нэгэн түүхэнд үхэл ба үржихүйн дунд оршдог хачирхалтай гэмээр харилцаа анхаарал татдаг. “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Буудайн үр газар эс унан, эс үхвээс тэр ганцаараа үлдэнэ. Харин тэр үхвээс олон үр гаргана.” (Иохан 12:24).

**Үхэл Үржлийг Бий Болгодог**

Чуулганы ариусал нь чуулганы өсөлтийн Библийн түлхүүр хэмээн Есүс Эзэн заасан. Паул Бурханы амласан “бүрэн ариусгал” нь бидний сүнс, сэтгэл, биеийг бүхэлд нь Ариун Сүнсээр дүүргэн Эзэн Есүсийг ирэх хүртэл гэм зэмгүй байхад туслах талаар заасан (1Тесалоник 5:23-24). Энэ нь зөвхөн хувь хүнд бус чуулганд ч адил нөлөөтэй хэмээн бид итгэдэг. Үржиж олшрох тушаалыг бид дэлгэрүүлэхдээ чухамдаа бид эхлээд үхэхийг хүсэх хэрэгтэй (Иохан 12:24). Үхэл л үржлийг бий болгох нөхцөл болдог. Өнөө 21 зуунд гарч ирсэн тийм ч шинэ санаа биш бөгөөд аль тэртээ 2000 жилийн өмнөөс Есүс Эзэний заасан үндсэн зарчим юм!

> Чуулганы өсөлтийн Библийн түлхүүр нь чуулганы ариусгал хэмээн Есүс Эзэн заасан.

Чуулганы цовдлогдох нь үргэлж чуулганы үржлийг дүүргэн бялхаах үндэс болдог. Элч Паулын үнэний тухай хэлсэн үгийг тунгаан бодож дүүрцгээе. “Би Христтэй хамт цовдлогдсон. Амьд байгаа нь би биш, харин миний дотор амьдардаг Христ юм” (Галат 2:20). “Бидний итгэлийг илтгэсэн дэлхийн дахиныг хамарсан тунхагийг бид Христитгэлийн эхний 5 зууны үеэс хүлээн авч хэрэглэсээр байна. Бид хэзээ ч мартаж болохгүй бөгөөд эхэн үеийн чуулганы таран

Эхэн үеийн чуулганы түгэн дэлгэрсэн учир нь тарчлан тамлуулсан тэдний цус байлаа. …хөдөлгөөний төлөө амь биеэ зориулахад бэлэн хүмүүс.

түгсэн дүүргэлтийн тухай тунхаг бус тэдний тарчлан тамлуулсан цус юм. Есүс Эзэнийг **өөрийн хүслээрээ** даган үхэх хүртлээ амиа зориулан дэлхийд хувьслыг авчирсан тэд юм. Сайн ч бай муу ч бай шалтгаанаар, хөдөлгөөний төлөө үхэхэд ч бэлэн хүмүүс..

Чуулганы ямар ч хөдөлгөөн ба бүлгийн нэг чухал өөрчлөлт бол дүүргэлтийг алдах ба цовдлогдох тухай бага ярьдагт байдаг. Өөрсдийнхөө гаргасан төлөвлөгөө бүтцийг үхүүлэх гэдэгт бидэнд таалагддаггүй. Чуулганы хувьд ч дотооддоо гаргасан төлөвлөгөөгөө өөрчлөх амаргүй, гэвч үүнийг хийж чадвал тухайн чуулганд амлагдсан үржилт өсөлтийн гайхамшиг болох болно! Чуулганд тохиолдсон энэ л туршлагыг бид "ариусалтай хамтрах" гэдэг.

Нутгийн чуулган ариусах үед Бурханы үржиж өсгөх хөдөлгөөний төлөө хэсэгчлэн болон бүхэлдээ золиос гаргах болно. Ариусалтай хамтрах нь эцэг чуулганаас шинэ чуулган тарих бүрд тохиолддог. Жижиг чуулганууд чадамжтайгаар гадагшаа гарах үедээ том чуулганы хүрээлэлтэй адил болох үед энэ нь бий болдог. Гадагшаа гарахдаа үнэ цэнэтэйгээр Есүс Эзэний төлөвлөгөөтэй явахдаа зовиур шаналал дундуур яваа нутгийн чуулганд ч тохиолддог. Нутгийн чуулган чуулганаасаа гарна хэмээн шийдсэн тохиолдол бүрт, шинэ чуулганд хөрөнгө оруулан дэмжихэд үүнтэй тулгарах болно.

Сүнслэг төлөвлөгөөний учир шалтгаан нь чуулганы хүн бүр "өөрсдийнхөө төлөвлөгөөг" хүлээн зөвшөөрөх **бус** харин Есүс Эзэний хүслийг эрэн хайхад л байдаг.

Нутгийн чуулган өөрсдөдөө мөнгөө зарцуулахын оронд Бурханы хөдөлгөөнийг даяарт дүүргэхийн тулд мөнгө санхүүг илгээхэд бий болдог. Чуулганы "ариусгал" д туршиж буй эдгээр олон жишээнүүд нь Есүс Эзэний Иохан12:24 т заасантай холбоотой.

Бид өөрсдийнхөө төлөвлөгөө зорилгыг үхүүлэх хүсэлтэй болоход Есүс Эзэний төлөвлөгөөгөөр өсөлт бий болно. Сүнслэг төлөвлөгөөний учир шалтгаан нь чуулганы хүн бүр

"өөрсдийнхөө төлөвлөгөөг" хүлээн зөвшөөрөх **бус** харин Есүс Эзэний хүслийг эрэн хайхад л байдаг. Түүний нигүүлслийг хайн өөрсдийгөө даруу болгоход Тэр өөрийгөө бидэнд илчилнэ хэмээн амласан (Иаков 4:6).

Гэмшил, эмтэрсэн сэтгэл, сэргэн мандах, яаралтай хөгжих талаар олонтаа ярьдаг нь Бурхантай хувьчлан уулзаж өөрчлөгдөхийн л тулд бус үнэндээ энэ нь чуулган даяараа баяртай оролцохын төлөө юм. Бурханы хөдөлгөөн Бурханы хүмүүсээр дамжин Есүс Эзэний заасан ариусалтай хамтрах тухайд туршин сурдаг чуулганы тавьдаг өндөр хэмжүүрийг нураан эвдэлдэг.

Энэ хандлагын үр дүнд пастор ахлагчид чуулганы шийдвэрийг гаргахдаа тооны нэмэлтийн талаар гэхээсээ илүүтэй үйлчлэл ба илгээлтийн өсөлтийг анхаарах юм. Еүдей/Христитгэлтний түүхийн сүүлийн 4000 жилд Бурханы дагалдагчид итгэл ба дуулгавартай байдлын оронд учир шалтгаанаар амьдрах гэж соригдсон. "Үхэгсдийг амилуулагч, байхгүйг байгаагаар дуудагч" (Ром 4:17) Бурханы хөдөлгөөнд итгэж нэгдсэн хүмүүст талархах нь зүйтэй. "Эзэнд итгэсэн тэд" (Эхлэл 15:6) Абрахамтай адил, Бурханы амласан хүчээр Бурханы төлөө зүтгэгсэд (Ром 4:21).

## Ариусал ба Өсөлтийн Зарчмууд

Ариун Сүнс Есүс Эзэний хэлсэн үгийг (Иохан 14:26) нэгэнтээ бидэнд сануулснаар, хаа сайгүй байх ариусал ба өсөлтийн тухай Библийн зарчмуудыг нүд маань харахаар нээгддэг! Монгол чуулганы хувьд дараах арван хичээл (Монголын Христитгэлт чуулганы хөдөлгөөн) эрүүлээр өсөж хөгжихөд тустай. Нэгд, **өсөлтийн төлөө бидний өгч чадах зүйлс.** Сайн мэдээнд, бяцхан хүүгийн өдрийн хоолны дэргэд зогсож буй Андрейг харъя. Тэдний эргэн тойронд эмэгтэйчүүд хүүхдүүдийг оролцуулалгүй 5000 гаруй хүмүүс. Есүс Эзэн болон дагалдагчид хүүгийн хоолыг авах нь учир шалтгааны талаас боломжгүй. "Энд таван арвайн талх, хоёр загастай хүүхэд байна. Гэвч энэ нь тэр олон хүнд юу болох вэ?" (Иохан 6:9)

> Өгч чадахаа өгсөн үед л өсөлт бий болно.

Есүс Эзэний гарт өгч чадахаа тавихад Тэр өсгөн цаашаа

дамжуулах болно гэдгийг харуулсан хүчтэй санааг энэ түүх агуулдаг. Есүс Эзэн “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Буудайн үр газар эс унан, эс үхвээс тэр ганцаараа үлдэнэ. Харин тэр үхвээс олон үр гаргана.” (Иохан 12:24) гэсэн. Бурханы хаанчлалд, бид байгаагаа өгөөд Түүний юу хийхийг харах хүсэлтэй байвал Есүс Эзэн өсгөн үржүүлэх болно!

Чуулганы нэмэлтийг анхааралдаа авах үед тулгарах аймшигтай сорилт бол – өөрсдийнхөө хийх үйлчлэлийг л **нэмэгдүүлэх** байдаг. Цаг болон газрыг л тодруулах болдог. “Өөрсдийнхөө Иерусалим, Иуда, Самари”-ийг (Үйлс 1:8) хайж, Есүс Эзэнийхээр харж чадвал Есүс Эзэний нөлөөлөхийг хүсч буй бай маань маш том бөгөөд нэг чуулганы нэг үйлчлэл хангалтгүй гэдгийг ойлгох болно. Бурханы биднийг байрлуулсан тэр газарт Хаанчлалыг өргөжүүлэхэд Есүс Эзэн бидэнд ямар үлгэр загварыг өгснийг болон бас өгснөөрөө бид үржих болно гэдгийг хэзээ ч мартаж болохгүй.

> Хүн бүрийн сүнсний цатгалт нь өсөлтийн түлхүүр юм.

Хоёр дахь зарчим, **өсөлт нь бүгдийг цатган хооллох болно**. Иохан 6:12т, “тэд бүгд цадтал хооллосон”; Библийн дагуух Христитгэлтнүүд, дэлхийг сүнсээр цатгах чин эрмэлзлэлтэй байдаг. Амийн талх болсон Есүс Эзэн (Иохан 6:35). Бидэнд тулгарч буй нөхцөл бол “Талх хэрэгтэй хүмүүст хэрхэн аваачиж өгөх вэ?” юм. Чуулганы эрүүл өсөлтийн талбарт үүнээс илүү чухал зарчим гэж байхгүй. Бурханаар дуудагдсан удирдагчдыг Эзэн босгоход, эцэг чуулгануудыг гэр бүлүүдээр хүчирхэгжүүлэхэд Монголын сайн мэдээ хүрээгүй сонсоогүй бүлэг багт Хаанчлалын үрийг тарьж бүр гайхалтай ажлаа хийх болно.

Хүмүүсийг өгөх нь ихэнхдээ биднийг сунгаж чангалдаг – сайн гэр бүлүүдийг өөр газар, үйлчлэл ба нөхцөл рүү явуулах амаргүй. Есүс Эзэнийг дуулгавартай дагасан удирдагчид өөрсдийнхөө хүсэл төлөвлөгөөг Түүнийхээр сольж, Бурханы хүмүүсийг өгч, бидний “тарьсан” тэдгээр хүмүүсийг Бурхан аваад арав, хорь, гуч, тавь бүр заримдаа зуу дахин өсгөх болно (Матай 13:23).

Сайн мэдээний тооцоололд, бяцхан хүү Есүс Эзэнд байгаа бүхнээ хүслээрээ өгөхөд “хүн бүр цадтал хооллосон”. Хүмүүс болон нөөц бололцоогоороо үүнийг хийснээр Бурхан бидэнд хүн бүрийг хооллох түлхүүрийг өгсөн.

Гурав дахь зарчим, **Есүс Эзэн үр жимсийг хүлээдэг.** Хүмүүс улс төрийн хувьд хаанчлалын найдвар тавьж байхад (Лук 19:11) Есүс Эзэн арван маанэ өгсөн ноёны тухай сургаалт үлгэрийг ярьсан. Энэ хэсэгт Есүс Эзэн буцахаасаа өмнө юу хийхээ болон дагалдагчдаасаа авсан талант болон нөөц боломжоороо үр жимстэй бас итгэмжтэй байхыг хүсч байгаагаа тодорхой хэлсэн (Лук 19:15-19). Зарим Христитгэлтнүүд Есүс Эзэний үр жимс гаргах тухай хүлээлтэнд их хичээх хэрэгтэй хэмээн үздэг. Хаан (Есүс) бэлэг авсан зарц нартаа нөөц боломжоо ашиглаагүйн төлөө хатуу хандаж байдаг (Лук 19:20-24).

> Түүний дагалдагчид авсан бэлгээ чанар болон боломжиндоо итгэмжтэй байж үр жимстэй байхыг Есүс Эзэн хүсдэг.

Энэ ядмаг зарц нартаа Есүс Эзэн яагаад ийнхүү хатуу хандана вэ? Үүнд дөрвөн шалтгаан бий. 1) Тэр Эзэнийхээ өгсөн боломжийг Хаанчлалын төлөө хуваалцаагүй. 2) Тэр Эзэнийхээ төлөвлөгөөнд итгээгүй учир өөрийнхөөрөө хийсэн. 3) Түүний анхаарал зөвхөн өөр лүү нь хандсан байдаг. 4) Тэр авсан бэлэг болон боломжоо ашиглан юу ч хийгээгүй. Түүний зарцын тухайд Есүс Эзэн биднийг Түүний төлөвлөгөөнд нэгдэхийг хүсдэг. Түүний өгснөөр үр жимс гаргах нь Түүний төлөвлөгөөнд багтдаг.

Дөрөв дэх зарчим, **бидэнд өгөгдсөнөөр үржин өсөхийг Есүс Эзэн хүсдэг.** Түүний хүсэлтийг тайлбарлахад, Есүс Эзэн талантын тухай сургаалт зүйрлэл ярьсан (Матай 25:14-30). Энэ удаа эзэн нь зарц нарынхаа чадамжид тулгуурлан ялгаатайгаар хуваарилсан байдаг. “Хэнд илүү өгнө, түүнээс илүү ихийг шаардана” (Лук 12:48). Хэн ч өөрийнхөө хэмжээнээс илүү ч үгүй дутуу ч үгүй авна (Матай 25:15). Бурханы бидэнд өгсөн цаг хугацаа, талант буюу бэлгэ чанар, эрдэнэс гэх мэт ямар ч нөөц боломжийг энд бүгдийг багтаан Есүс Эзэн ярьсан. Түүнийг буцаж ирэх хүртэл эдгээрийг ухаалгаар зарцуулахыг Тэр хүсдэг ба тэр цагт Түүнд мөн буцаан өгөхийг хүсдэг. Үлгэрт хэлсэнчлэн хэн авсандаа итгэмжтэй үнэнч байна түүнд “Итгэмжтэй зарц минь сайн байна” (Матай 25:21,23) гэх болно.

Өөрийгөө л бодож аюулгүй хэмээн санаж, өөрийнхөө сонирхол хүслийг л хамгаалан авч үлдэхийг хүссэн тэр зарцыг Есүс Эзэн “сул дорой залхуу” (Матай 25:26) хэмээн дууддаг. Түүнд өгснийг үржин өсгөхийг тэр бодож хичээгээгүй. Түүнд хамаарагдах цаг хугацаа

болон бэлгэ чанар, эрдэнэс нь ЭЗЭНд нь хамаатайг ч бодолгүй **түүнийх биш** гэдгийг тэр мартсан. Тэр эзэмшигч нь биш, тэр зарц, Бурханы эзэмшдэгийг зохицуулан зарцуулагч. Бидэнд өгснийг хүлээн авч түүнийг өсгөх нь Есүс Эзэний төлөвлөгөө.

Тав дахь зарчим, **Бурхан өөрийнхөө хүмүүсийг хамтдаа нэгдмэлээр ажиллахыг хүсдэгийг мэдэх болно.** Бид Шинэ Гэрээнээс жишээ татан авч үзсэн, энэ талаар Хуучин Гэрээнд ч гардаг. Израилийн түүхэнд, хүмүүс айдас ба итгэлийн аль алинаар нь дүүрдэг (Тооллого 13:25-32). Амлагдсан газар тэднийг аваачих баталгааг Бурхан өгсөн. Мосе тэдэнд “ЭЗЭН Бурхан чинь энэ газрыг та нарт өмчлүүлэхээр өглөө. Эр зоригт эрчүүд та бүхэн зэвсэглээд, Израилийн хөвгүүд болох ах дүү нараа манлайлан гаталцгаа. ... ЭЗЭН та нарт өгсөн шигээ ах дүүст чинь ч амралтыг өгөх хүртэл тийн байх болно. Тэд Иорданы нөгөө талд, та нарын Бурхан ЭЗЭНий өгөх газрыг эзэмшсэний дараа та нар бүгдээрээ миний өгсөн эзэмшил газартаа буцаж ирж болно” гэж хэлсэн (Дэд хууль 3:18,20).

Бидэнд өгөгдсөнөөр үржин өсөхийг Есүс Эзэн хүсдэг.

Бурхан Израилийн түүхээс биднийг суралцахыг хүсдэг. “Энэ бүхэн жишээ болон тэдэнд тохиолдсон бөгөөд үүнийг бидэнд сануулга болгон бичжээ” (1Коринт 10:11). Энэ бол ахан дүүс бидэнд санал болгож буй биш харин Бурханы тушаал юм. Иорданы зүүн талд амьдардаг овгийнхон өөрсдийнхөө өвийг аль хэдийн хүлээн авсан. Гэвч Бурхан тэднийг үүндээ санаа амарч амьдрахыг хүсээгүй. Тэдний эзлэн авах газар цаана нь үлдсэн байсан. Бурхан удирдагчдыг “шинэ газар нутгийг эзлэн авах” ад оролцохыг хүссэн.

Христитгэлтнүүдийг хамтдаа нэгдмэлээр ажиллахыг Бурхан хүсдэг.

Түүний амлалт ил тодорхой. “ЭЗЭН Бурхан чинь энэ газрыг та нарт өмчлүүлэхээр өглөө” (Дэд хууль 3:18). Бурхан газар нутгийн тэлэн өсгөхөө амласан! Үүнийг хийх ганцхан л арга байсан. “Эр зоригт эрчүүд та бүхэн зэвсэглээд” өөрөөр хэлбэл, сүнслэг армийнхан орохдоо, Бурханы тэлэн өргөжүүлэх агуу үйлсэд бусдыгаа манлайлан хөндлөн гулд явах хүсэлтэй байх ёстой.

"Өөрсдийнхөө газар нутагт" бусдаас хамааралгүйгээр аюулгүйгээр тухлаг орчиндоо чуулганаа байгаад байхыг Бурхан хүсдэггүй. Монголын Христитгэлт хөдөлгөөний болон эцэг чуулганы удирдагчид нь өсөн үржиж, Бурханы чуулганыг барьж байгуулахын тулд хамтран ажиллах нь сайн. "Ахан дүүст минь Эзэн амралтыг өгөх хүртэл" түүхийн дагуу хамтдаа ажиллана (Дэд хууль 3:20). Бурхан биднийг дэлхий даяар Хаанчлалыг өргөжин тэлүүлэхийн тулд гар хөлөө хумиад суухын оронд хамтдаа сүнсээрээ нэгдэн зүтгэхийг хүсч үүнийг хүлээн байна.

Зургаа дахь зарчим, **"дараагийн хот руу" хараатайгаар Есүс Эзэн амьдарсан**. Түүний ажил үйлчлэл эхэлсний дараа, Тэр байгаа газраасаа цаашаа явах ёстойгоо мэддэг ба тэгэхийн тулд тэнгэрлэг Эцэгээсээ зааврыг хүлээн авч сүнсний хувьд туршлагаж шинэчлэгдэж байсан. Олон хүнийг эдгээж, ард түмэнтэй өдөржингөө байсан урт өдрийн дараа (Марк 1:33) ч Түүнд заавар хэрэгтэй байсан. Тэгээд "Үүр шөнөөр Тэр босоод гадагш гарч зэлүүд газар очин, тэндээ залбирч байв" (Марк 1:35).

Дагалдагчид Есүс Эзэнийг хайн ирэхдээ Түүнийг харсан. Өглөө эртлэн боссон Есүс Эзэн тодорхой зааврыг тэр цагт авч, Эцэг нь түүнийг "дараагийн хот руу" явахыг хүссэн гэдгийг мэдсэн. (Лук 4:43) Тэр байгаа газартаа Хаанчлалыг байгуулаад зогсохгүй, **зэргэлдээ хотуудад** ч мөн барьж, мөн ойр хавийн бүлэг хүмүүст ч хүрэхийг хүссэн. Тэр Хаанчлалыг зөвхөн нэг газарт байгаа газартаа л тарихыг хэзээ ч хүсээгүй. Түүний үйлчлэлийг эхлүүлэхдээ бид анхааралтай байж, Есүс Эзэнд байсан зэргэлдээх хүмүүсийг бас Түүний жишээгээр санаандаа багтаах ёстой. Түүний бие, чуулган шинээр таригдаж буй чуулганыг дэмжигч байж Есүс Эзэний жишээгээр сайн мэдээг Монголын сайн мэдээ сонсоогүй хүмүүст хүргэх юм. "Одоо эндээс явж ... үүний төлөө л би ирсэн" (Марк 1:38) Есүс Эзэн "дараагийн хот руу" гэсэн санаатай байсан.

> Есүс Эзэн хаант улсаа нэг л газарт байгуулахаар хэзээ ч хараалаагүй.

Долоо дахь зарчим, **Есүс Эзэн удирдагчдыг босгон хөгжүүлж, тэдэнд эрх мэдэл хариуцлагыг өгсөн.** Дагалдагчидтайгаа хамт амьдарч байхдаа зогсолтгүйгээр зааж сургасан. Дагалдагчдаа ангиа төгсөж дүүргэсний дараа л явуулахыг хүлээгээгүй. Эхнээсээ л

тэдэндээ цагаа зарцуулан 3 Түүний юуг яаж хийж байгааг харуулан хамтдаа үйлчлэхэд тэднийг зоригжуулж байсан.

Хэдэн сарын дараа, арван хоёроо дуудаад, тэдэнд хүчийг бас эрх мэдлийг өгөөд тэднийг сайн мэдээ тараалгахаар явуулсан (Лук 9:1-2). Хэсэгхэн хугацааны дараа, Есүс Эзэн далан хоёр хүнийг хоёр хоёроор нь баг болгоод тосгод руу явуулсан (Лук 10:1). Тэд буцаж ирээд юу хийсэн харснаа гэрчлэн ярихад Есүс Эзэн тэднийг сүнслэг заавраар урамшуулсан (Лук 10:17-24), Бурханы хөгжүүлэн өсгөж байгаа залбирлын эдгээр удирдагчидтайгаа баярлан хөөрсөн! Есүс Эзэний дагалдагчдаа хөгжүүлэн сургаж байгаа энэ жишээг Паул мөн дуурайж, Тимотыг сургасан. Есүс Эзэний дагалдагчдаа сургах энэ үлгэр загвар нь энгийн бөгөөд тэр үргэлж үржиж өсөхийг санаж явсантай холбоотой. Түүгээр эхэлсэн энэ төлөвлөгөө бусдаар дамжин хурдан биелэлээ олж өсөх болно. Түүний энэ загвар дараах аргачлалд хэрэглэгдсэн:

Түүгээр эхэлсэн энэ төлөвлөгөө бусдаар дамжин хурдан биелэлээ олж өсөх болно.

**Алхам 1**: Би хийе. Чи хар. Хамтдаа ярилцъя.
**Алхам 2:** Би хийе. Чи тусал. Хамтдаа ярилцъя.
**Алхам 3:** Чи хий. Би тусалъя. Хамтдаа ярилцъя.
**Алхам 4:** Чи хий. Би харъя. Хамтдаа ярилцъя.
**Алхам 5:** Чи хий. Өөр нэгэн хараг. Тэд ярилцаг.

Хаана эрүүл, өсөж буй чуулган байна тэнд удирдагчид Тимотыг босгож эрх мэдэл ба хариуцлагыг хамтад нь тэдэндээ хүлээлгэн өгдөг (2 Тимотод 2:2).

Найм дахь зарчим, Есүс Эзэн хэзээд гол дагалдуулагч байсан бид биш. Бурхан Тимоттой адил удирдагчдыг Монголын Чуулганд өсгөвөл дэндүү хамааралтай удирдагчид бий болох ба сул дорой шалчиганасан хүмүүс л болно. Ганц л энэ л шалтгааны улмаас Есүс Эзэн дэлхийд 3 жил амьдарсан. Тэрээр дагалдагчдыгаа бие махбодит Түүнээс л хамааралтай байгаасай гэж хүсээгүй. Харин Бурхан Эцэгийн амласан хожим ирэх Сүнснээс хамааралтай байхыг хүсдэг. Гурвалаар хүмүүсээ дүүргэн удирдан чиглүүлэх болно. Тэд өнчрөгсөд хэзээ ч болохгүй бөгөөд Бурхан ч тэднийг үйлчлэлд нь ганцааранг нь

орхихгүй! (Иохан 14:18-26) Тэр тэдэнд “Би төгсгөл хүртэл та нартай хамт байх болно” (Матай 28:20) гэж амласан.

Бид хэзээ ч ганцаардахгүй тул Эзэн шинэ удирдагчдыг бидний дундаас үргэлж босгож байх болно. Есүс Эзэн тэднийг удирдан чиглүүлж, хэрэв тэд дуулгавартай байж чихээ Түүнд хандуулан амьдрал ба үйлчлэлдээ дуу хоолойг нь сонсвол Тэр дагалдуулах болно (Иохан 10:27). Иохан 14:1-17:26д дагалдагчиддаа Есүс Эзэн Ариун Сүнсний хийх ажлын талаар тодорхой тайлбарласан. Нэгэн цагт чуулганы тэргүүн болох Есүстэй холбоотой байх талаар тэдэнд заасан учраас Тимотууд бидэнд хэрэггүй болно. Ийм л шалтгаанаар Есүс Эзэн үргэлж анхны биднийг дагалдуулсан анхдагч гэдгийг санаж байх хэрэгтэй.

> Тэрээр дагалдагчдыгаа бие махбодит Түүнээс л бус харин Бурхан Эцэгийн амласан хожим ирэх Сүнснээс хамааралтай байхыг хүсдэг.

Ес дэх зарчим, **тэд анхлан эхэлсэнтэй адилаар Монгол чуулган өөрсдийнхөө өсөн үржих зориулалтаа гаргах хэрэгтэй.** Олон чуулган таригч хүмүүс буй сургалтанд суухдаа бид эцэг чуулгануудын олонх нь тэдэнд өгсөөр байгааг харах болно. Есүс Эзэн “Өгөх нь авахаасаа илүү ерөөлтэй” хэмээн хэлсэн (Үйлс 20:35). Ийм л учраас эхнээсээ Монголд чуулган таригчдыг өөрсдийнхөө өсөх хувилбарыг бий болгоорой хэмээн уриалж байна. Монголын Христитгэлт чуулганы хөдөлгөөнөөр чуулган тарих үйлчлэлд шинэ чуулганууд эцэг болон дэмжигч чуулгануудаа тэдний сэтгэлгээгээр удирдах чадамжтай. Бурхан ямар ч төрлийн хамтын ажиллагааг таалан хүлээн авч, шударга ба хамтдаа нэгдмэл байдаг эцэг чуулганы пастороор өнөө цагт Монголд хөдөлгөөнөө өрнүүлэх болно.

> Эхлэхдээ шинэ чуулганууд өөрсдийнхөө зориулалтаараа өсөж үржихэд анхаарах ёстой.

Байшин, хөрөнгө мөнгө, гишүүд, мөн эхлэхэд хэрэгтэй бусад олон боломжууд байхгүй таригчид олон байна. Тэдний дагаж мөрдөж буй аргачлалд өсөж үржихэд хэрэгтэй энэ л аргыг тэдэнд санал болгох уу? Тиймээ гэсэн хариултыг өгье. **Бид эрүүл чуулганы өсөлтийн тухай л ярьж байгаа бөгөөд чуулганы гишүүд болон мөнгө санхүүгийн тухай яриагүй.**

Энэ бол зүрхний шалгуур. Бурханы хаанчлалд хамтдаа нэгддэг бас хараатай таригчид хэрэгтэй бөгөөд Бурханы хөдөлгөөнийг дүүргэх болно. Хэд дахин олон эрүүл, өөрсдийнхөө зориулалтаар өсгөхийн тулд биднийг аврахаар ирсэн Есүс Эзэнийг гэрчлэн хүмүүст хүрэхээр холбоо харилцааг бий болгодог удирдагчид Монголын Христитгэлт чуулганы хөдөлгөөнд хэрэгтэй (Лук 19:10).

Арав дахь зарчим, тэдгээр удирдагчид **Монголын эцэг чуулгануудыг сүнслэг халамжаар асарч тэтгэх нь зөв**. Антиохын чуулган өсөлтийн тал дээр маш тодорхой үйлчлэлтэй байсан. Христ хэрэгтэй хүн бүр чуулганд хамрагдахгүйг Антиохын чуулганы удирдагчид ойлгож байв. Томоохон чуулганы чадамж нь чуудал бөглөхөд бус тэднийг илгээхэд байдгийг тэд ухаарсан. Паулын сүүлд бичсэн захианд "Тэгвэл Түүнд итгээгүй тэд яаж Түүнийг дуудах вэ? Түүнийг сонсоогүй тэд яаж Түүнд итгэх вэ? Тэд тунхаглагчидгүйгээр яаж сонсох вэ? Илгээгдэхээс нааш тэд яаж тунхаглах вэ?" (Ром 10:14-15) гэжээ. Эзэнийг магтан хүндлэх нөхцлийг бүрдүүлсэн бас Ариун Сүнсийг иртэл мацаг барин залбирч байгаа Христитгэлтнүүд хоёр удирдагчдийг илгээснээрээ анхны албан ёсны Христитгэлийг түгээж чуулган тарих ажлыг эхлүүлсэн (Үйлс 13:2).

> Гайхамшигтай чуулганы хэмжүүр нь суудлын тоо буй чадамжид бус хэр илгээх чадамжид байдаг.

Антиох чуулганы сүнслэг уур амьсгал нь эцэг чуулганыг төрүүлсэн. Итгэгчид нь Ариун Сүнсний хийх ёстой зүйлийг нь хэлэхэд дуулгавартай байж бэлтгэн мэдрэмжтэй байсан. Дэлхийн дахинд эцэг чуулганы төрх байдлыг тэд Шинэ Гэрээний үед тодорхойлж үлгэр жишээ болсон. Тэдэнд үр дүнт бүтэц бий болж сүнслэг уур амьсгал нь зөв төлөвшсөн. Чуулган дуулгавартай байсан бөгөөд эцэг чуулганы хувьд тэднийгээ үйлчлэлд илгээсэн үр дүнтэй. "Тэгээд тэд мацаг барин залбирч, Саул Барнаб дээр гар тавиад, явуулжээ" (Үйлс 13:3).

Чуулганыг тарьж үйлчлэлд илгээхдээ Антиохчууд эцэг чуулган ямар байхыг бидэнд харуулсан. Тэд мацаг барин, залбирч, гар тавин ерөөн залбирсан. Антиохын гишүүд Паул Барнабыг тойрон гараа тавьж, хайраар харилцан, тэднийг дэмжин халамжилсан. Эцэг чуулганы хувьд, хэзээ ч үнэ цэнэ болон хувь хүнд хүрэх үгийг доогуур үнэлж болохгүй. Чуулган таригчид сэтгэл хөдлөлтэй хайр, мөн адил

мэдрэмжээр энэрэхийг, Антиохын үзүүлсэн жишээтэй адил мэдэрч байх ёстой.

Бурхан Монгол чуулганы ихэнх нь шинэ чуулган тарихдаа эцгийн ёсоор дэмжихийг хүсдэг. Монгол чуулганы Хөдөлгөөний удирдагчид эцэг чуулгануудыг бий болгохын тулд уур амьсгал болон үр жимсийг анхаарвал Бурханы нээхээр амласан үүд хаалгыг онгойлгох болно! (Үйлс 14:27).

> Бид эцэг чуулгануудыг бий болгохын тулд уур амьсгал болон үр жимсийг анхаарна.

**Өсөлтийг Дүүргэх Илгээлтийн Аянтай адил Сэтгэхүй**

Бид илгээлтийн эзэдтэй адил сэтгэснээр бидний эргэн тойронд буй соёлын бүтэн байдал ба энгийн шинжийг харахгүй байж чадахгүй. Нийгэм бүлгүүд олон соёлт болон хөгжиж, дэлхий даяар бие биедээ уусан, ёс заншлууд хэдэн зуугаараа холилдож байна. Соёл уламжлал хэзээ ч тоо баримтаар яригддаггүй, үргэлжид өөрчлөгддөг. Ойр дөт газрын ёс заншлаас бид суралцан өөрсдийнхтэйгээ нэгдүүлэн олон соёлыг нэгтгэдэг.

Эрүүл ба өсөлттэй чуулганы удирдагчид соёлын хил хязгаарыг хөндлөн туулах илгээлтийн эздийг бэлтгэхэд суралцана. Тэдний хүрэхийг хүссэн хүмүүсийн дэлхийг үзэх үзэлт соёл ба хэл яриа танил болдог. Тэдний хуваалцах бичээсийг тайлбарлахтай адил ёс заншлыг бас “тайлбарлах” болно. Афиний бурхдын талаар тэдний өмнө зогсоод “үл мэдэгдэх бурханд” гэсэн бичээсийг Паул тэдэнд тайлбарласан жишээ бий (Үйлс 17:23).

> Илгээлтийн эзэд гадна талд харагдахаас илүүг Бурхан аль хэдийн хийгээд эхэлсэн гэдгийг мэддэг! Бурхан өөрөө л хүмүүсийг төрхжүүлэн зурдаг.

Өнөөгийн Монгол чуулган бүр Христитгэлт бус соёл заншилтай газарт байршдаг учир үр нөлөөт Монгол пасторууд чуулганыхаа удирдагчдыг Христитгэлт болохоос өмнө ямар үзэх хандлагатай байдгийг ойлгоход нь туслах болно. Чуулганы гишүүд илгээлтийн эзэдтэй адил сэтгэж эхлэхэд Монголын Христийг үл мэддэг

хүмүүсийн “сэтгэхүй”г танихад суралцана. Христитгэлтэн арайхандаа болоогүй байгаа хүмүүст хүрэх үр нөлөөт чуулганы уламжлалыг бий болгохыг тэд хүсдэг. Хүмүүсийн асуултанд үнэнчээр хариулж итгэл доторх сүнсний аялалаа эхлүүлэхэд нь аюулгүй байх орчныг тэд бий болгохыг хүсдэг.

Илгээлтийн эзэд бол тэвчээртэй. Бурханы энэрэл өршөөлд тэд итгэсэн тул тэдний гадна талд харагдахаас илүүг Бурхан аль хэдийн хийгээд эхэлсэн гэдгийг мэддэг! Бурхан өөрөө л хүмүүсийг төрхжүүлэн зурдаг. Илгээлтийн эзэд “зовлон бэрхшээл” гаднаас ирдэгийг мэддэг. Христитгэлтэн болоогүй л бол Христтэй адил үйлдэх ба авирлахад нь хүмүүсийг хүлээн авдаггүй.

Шинэ Гэрээний тоймыг уншихад анхны чуулганууд замбараагүй хөдөлж байсан. 1Коринт номын хараарай. Коринтын өөрийнх нь ёс заншлын агуулгад тулгуурлан Паул чуулганыг төлөвшин “хамгийн шилдэг арга зам” руу эргэхийг тэдэнд заасан (1Коринт 12:31).

Бидний хүн бүр илгээлтийн талбарт амьдардаг. Монгол чуулганы хөдөлгөөний чуулган бүр илгээлтийн талбарт байршдаг. Үүний учир, Монгол чуулганы пастор бүр илгээлтийн эзэн хэмээн гишүүн бүрээ харж урамшуулж бодох хэрэгтэй. Бидний мэдэж байгаа дэлхий ертөнц өөрчлөгдөж байна. Бүгдээрээ үүнийг харж, мэдэрч, чуулганы удирдагчид нэгдэхийн төлөө ярьж залбирч байна.

Бидний мэдэж байгаа дэлхий ертөнц өөрчлөгдөж байна. Бүгдээрээ үүнийг харж, мэдэрч, чуулганы удирдагчид нэгдэхийн төлөө ярьж залбирч байна.

Хүүхдүүдийг маань хүрээлэн буй ёс заншил өөрчлөгдөж байна. Чуулган үргэлжлүүлэн өөрчлөгдөж, бүлэг хүмүүст болон ёс заншил буй дэлхий даяар тархсан Монгол хүмүүст хүрч нөлөөлөхийн төлөө явах хэрэгтэй.

Чуулганы үржиж өсөх нэгэн зорилго нь илгээлтийн эзэд хэмээн чуулганы удирдагчдаа харахад байдаг. Дэлхийн Назарчуудын олонх нь тэд юунд итгэж байгаагаараа үйлдэхэд туршлагажиж дадлагажсан байдаг. Зүрхний гүнд тэд сүнсний талбартаа цовдлогдсоноор чуулганы өсөлт бий болно гэдэгт итгэдэг.

## Назарын Сүлжээний Хүчээр Тоноглохуй

Назарчуудын бас нэгэн учир нь Назарын Сүлжээний чуулгануудын өсөлтийн зарчмаас суралцан хамтдаа хүчээр тоноглогдоход оршдог. Назарын дагаж буй зарчимд хөдөлгөөнийг дүүргэхэд тусалдаг онцгой нэгэн шигтгээ байдаг. Чуулганаа бид чин зүрхнээсээ баттайяа хайрладаг. Зарц удирдагчид байхаар бид Эзэн Есүст дуудагдсан**. Тослогдсон ахлагчдаас илүү өндөр ажлын байр гэж чуулганд үгүй.** Дэлхийн чуулганыг удирдах удирдлагын зөвлөлд гишүүдийг бид илүү хүндэлдэг хүмүүсээ сонгодог. Бидний дунд харин пап лам болон бишоп байхгүй. Бид бүхэнд энгийн л үүрэг хариуцлага өөр өөрөөр оногдсон. **Багт байгаа хүн** бүр онцлог шинжээрээ бие биенээ хүчирхэгжүүлэх болно.

Протестантын хэв маягаас Назарчууд арай өөр чуулганы загварчлалыг хөгжүүлж байна. 1980 онд олон улсын журам болох чуулганууд ба дэлхий нийтийн бүсчилсэн итгэгчдийн нөхөрлөлийг үрчлэн авч тэднийг өөрсдийнхөө ёс уламжлалд нийцүүлэн хүлээн авсан. Оюун санаагаараа ангилан үздэг “хүчтэй ба сул дорой”, “санхүүжүүлэгч ба хүлээн авагч” гэсэн ойлголтыг бид эсэргүүцэн хүн бүрийн тусгайлан холбоосыг хүлээн авдаг. Энэ л арга замаар манай чуулган дэлхийн хязгаарт хүртэл хурдан тархсан. Шинэ мянганыхан улс үндэстэн бүрийн эдийн засгаас үл хамааран удирдагчид ба чуулганы хүчний тэнцвэртэй гэж бидний хардаг дэлхийг харахдаа баяртай байдаг.

Шинэ мянганыхан улс үндэстэн бүрийн эдийн засгаас үл хамааран удирдагчид ба чуулганы хүчний тэнцвэртэй гэж бидний хардаг дэлхийг харахдаа баяртай байдаг.

Дэлхийн чуулганы итгэгч оролцогч бүрт бид Христитгэлийн үнэ цэнэ, Ариун байдал ба Илгээлтийн, хамаарал холбоог үнэлэн хуваалцдаг. Чуулганы өсөлт хэн нэгэн хүн ба бүлэг хяналт тавих гэж оролдохгүй цагт хурдан явагддаг болохыг бид сурсаар байна. Дэлхийн даяар өөрчлөлт явагдахын хэрээр харилцаа холбоо сайжирч, пасторууд болон удирдлагын зөвлөлийн гишүүд хаа сайгүй харилцдаг болсон. Агуу захирамж хөдөлгөөний дагуу Есүс Эзэний төлөвлөгөөгөөр Ариун байдлыг дүүргэхээр удирдагч бүр итгэгчдээ уриалан нээлттэй байх харилцааг бид үүсгэж

байна.

Нээлттэй болсон энэ цаг үед дэлхийн мэдээллийг болон оюуны чадамжид төвлөрөлгүй харин эдгээрийг Назарын чуулганы Сүлжээгээрээ дамжуулан тараадаг. Мэдээлэл ба мэдлэг нь Христтэй адил үйлддэг Христитгэлтнүүдтэй нутгийн чуулганаас эхтэйгээр бидний хөдөлгөөнийг дүүргэхэд чухал нөхцлүүдийг суралцахад тустай тул шалгуур шүүлт нь энгийн байдлаар шууд л явагддаг.

------ . ------

Чуулганы хувьд, чуулган тарих гдаж байгаа, чуулган хөгжиж байгаа газар нутгийн жишээг бид онцлон авч бусаддаа түгээн тараахад анхаардаг. Дэлхийн нийтээр өсөж буй чуулганыг анхааралтай ажиглавал Бурхан чуулган тарилтын хөдөлгөөнийг өрнүүлж буй газарт тэднийг босгон байгуулж байгааг олж хардаг. Монголын Христитгэлт Чуулганы хөдөлгөөний томоохон хэрэгцээ бол хувиа хичээлгүй Бурханы төлөө босох, нутгийн Монгол чуулгандаа хөдөлгөөнийг өрнүүлэхийн төлөө Христтэй адил үйлчлэх хүсэлтэй байх юм. Есүс Эзэн биднийг үхэх хүсэлтэй байхад шинэ удирдагчдыг төрүүлэн гаргах үр жимстэй болно гэсэн! (Иохан 12:24)

Христитгэлт Монгол Чуулганы хөдөлгөөн нь хөгжиж буй дэлхийн өнцөг булан бүр лүү, өөр ертөнц рүү нүүж байна. Энд гайхалтай мэдээ байна! Назарын Сүлжээгээр хамтдаа ажилласнаар 21-р зуунд бид өмнө хийж байгаагүй тэр л Есүс Эзэний үйлчлэлийг хийхэд бэлтгэгдэж байна. Ариун Сүнсний бэлэг бол манай сүлжээ билээ! Энэ бидний зуун. Одоо цаг нь болжээ. Бурханы хүмүүсээр дамжин Бурханы хөдөлгөөнд **өнөөдөр** та хэрэгтэй бөгөөд гараа барилцан таны үйлчилж байгаа тэр л газарт өсөлтийн бүлгийг бий болоход туслаарай.

> Ариун Сүнсний бэлэг бол манай сүлжээ билээ! Энэ бидний зуун. Одоо цаг нь болжээ.

**Эргэцүүлэх Асуултууд 6 Бүлэг**

1. Есүс Эзэний хэлсэн "үхэл үргэлж үржлийг төрүүлдэг" гэсэн үгийн тухай ярилцаарай. Энэ сүнслэг зарчмын хэрэгжүүлэлтийг чуулганы түүхэнд хэрхэн биелүүлсэн бэ?
2. Христитгэлийн анхны 3 зууны тухай та нар юу мэдэх вэ? "Хавчигдан

зовогсдын цус" ны талаар сонсож байсан уу? Энэ дэлхийн хаа сайгүй хавчигдан гадуурхагдаж байгаа Христитгэлтнүүдийнхээ төлөө хэдэн хором гаргаад залбирна уу?

3. Христитгэлтэн бүр Библийн заасан "ариусал" нь хувь хүнд хувьчлан хийгддэгт итгэдэг. Тэгсэн хэдий ч ихэнх чуулганууд Библийн зарчмыг ариусалтай хослуулах зарчмыг авч хэрэглэхгүй л байна. Зохиогчийн дэвшүүлсэн ариусалтай хамтрах талаар авсан ямар жишээнүүд байна вэ? Танай чуулганд энэ туршлага бий юу? Үүнийг эхлүүлье гэвэл юу хийх вэ?
4. Ариусал ба өсөлтийн талаар зохиогч маань 10 санааг дэвшүүлсэн. Аль танд хамгийн ойр туссан бэ? Та юу сурав? Таны сонсож байгаагүй болон мэдээгүй ямар зарчим байсан бэ?
5. Энэ бүлгийг уншаад эргэн харахад өсөхийн тулд чуулгандаа үйлчлэл нэмэлгүйгээр хийж болох зүйл юу вэ?
6. Жижиг өөрчлөлтөөс эхлэн арваас мянга руу хэрхэн өсөж болох сүнслэг хөдөлгөөний тухай энэ бүлэгт танд тустай юу хэлэгдсэн бэ? Назарын хөдөлгөөн энэ л зарчмаар өссөөр 160 гаруй улс орны 30,000 гаруй чуулганыг тариад байна. Монгол чуулганы ирээдүйг та хэрхэн харж мэдэрч байна вэ? Та эдгээр зарчмыг хэнд хуваалцаж, Христитгэлт Монгол Чуулганы хөдөлгөөнийг өрнүүлж болох вэ?
7. Дараах зарчмын талаар ярилцаарай. **"Тослогдсон ахлагчдаас илүү өндөр ажлын байр гэж чуулганд үгүй**. Бидний дунд харин пап лам болон бишоп байхгүй. Бид бүхэнд энгийн л үүрэг хариуцлага өөр өөрөөр оногдсон." Багийн чухал үнэтэй гишүүн гэдгээ мэдрэхэд хүн бүрт туслахын тулд, чуулганы сайны төлөө хамтдаа хийж болох, Америк ба Монголд нэмж хийж болох ямар ажил байна?
8. Өсөлтийн тухай эдгээр зарчмуудыг ойлгох ба дэлхийн чуулганы сүлжээ, Назарын хөдөлгөөний болон зохиогчийн 21-р зуунд нөлөөлөхөөр дэвшүүлсэн санааг та дэмжиж байна уу? Яагаад?

# 7 Чуулганы Нөлөөт Уламжлалыг Бий Болгохуй

"Тэгтэл ЭЗЭН надад хариу айлдруун "Үзэгдлийг бичээд, хавтангууд дээр сийл. Уншсан нэг нь ухасхийг. Үзэгдэл нь тогтоогдсон цагийн төлөө юм. Төгсгөл уруугаа энэ нь яарах агаад эс хөсөрдөнө. Хоцорч байгаа боловч үүнийг хүлээгтүн. Хойшлолгүй заавал биелэгдэх болно. ... Харин зөвт хүн итгэлээрээ амьдарна. (Хабаккук 2:2-4)

Монгол чуулганы үр нөлөөт удирдагчид нь зорилгоо зөв тодорхойлж, хараагаа хөгжүүлэн, бүтцийг бий болгоод Христитгэлт Монгол Чуулганы **уламжлалыг хөгжүүлэн шинэчилж,** хамгийн чухал бидэнд тулгарч буй агуу ирээдүйн төлөө өнөөдрөөс тулан хэлбэршүүлдэг. Удирдагчдыг шинэ санаагаар хөгжин дэвшихэд хамаарах уламжлал юм. Бүтээлч сэтгэлгээгээр хүчирхэгжин, урам зоригийг бадраан, хамтдаа ажиллан хамтрахын төлөө ээзд нь байх мэдрэхүйг хөгжүүлэх уламжлал. Чуулганы хувь онцлог ёс суртахуун, багийн ажиллагаа, үр нөлөө, урт хугацааны эрүүл энх тогтнох, өсөх чадамжийг төрхжүүлдэг чуулганы уламжлалыг бид яриад байгаа.

> Хүмүүсийн өдөөгдөж байдаг арга зам, чуулганд хамтрагчаа өдөөн уриалж байгаа арга, удирдагчдынхаа үгийг хүлээн авч байгаа нөхцөл, эдгээр бүгд хүмүүсийн амьсгалж буй чуулганы "агаар" юм.

Чуулганы "уламжлал" гэж юу вэ? Үүнийг тайлбарлахад тийм амархан биш. Хүмүүсийн өмссөн зүүсэн, аяглаж авирлаж байгааг хардаг зүйлс багтдаг ч цуглах үедээ бидний хуваалцаж буй "мэдээ" ямар болохыг ажиглах орно. Бидний үнэлдэг тогтвортой болон тогтворгүй зүйлс, итгэдэг ба авч үздэг нөхцөл байдал, зөвхөн онолын бус мөн үйл ажиллагааны ч итгэл үнэмшил бүгд юм. Чуулганд эрүүл ахуйг хэрхэн баярлан хөөрч хүлээн авах вэ? Асуудлыг хэрхэн дугаарлаж байна? Бие биенээ хүндлэн итгэлээр хүлээн авахдаа хэр байна?

Уламжлал гэдэг нь хараа болгон бодлогоос илүү гүн утгатай бөгөөд төрхжүүлэхэд хүндрэлтэй, учир нь хүмүүс ба харилцааны тухай ярьж байна. Хүмүүсийн өдөөгдөж байдаг арга зам, чуулганд хамтрагчаа өдөөн уриалж байгаа арга, Христитгэлт Монгол Чуулганы

хөдөлгөөний удирдагчдынхаа үгийг хүлээн авч байгаа нөхцөл, эдгээр бүгд хүмүүсийн амьсгалж буй чуулганы "агаар" юм. Энэ агаарыг эрүүл бас тэнхээ оруулсан хэмээн баттай итгэж байвал Монгол чуулганы хөдөлгөөн өрнөх болно. Хэрэв энэ "агаар" урам зориггүй, зогсонги бол төлөвлөгөө бүтэлгүйтэж, бүтээлч сэтгэлгээ дутаж, үр нь хорхойд идүүлэн, чуулганы уламжлал сүнслэг дурсамжгүй болох болно. 6 Өөрөөр хэлбэл, бидний бүгдийн амьсгалдаг "агаар" ын үнэ цэнэ хамгийн чухал!

## Хүсэл тэмүүлэл, Нөөц боломж, Уур амьсгал

Хэд хэдэн пасторуудтай ярилцсаны дараа, чуулганы нөлөөлөхүйц уламжлалыг бий болгоход гурван зүйл шаардлагатайг мэдсэн. Тэднийг "гурван тойргоор" илэрхийлье. Хүсэл тэмүүлэл, нөөц боломж, уур амьсгал эдгээр нь эрүүл, Монгол чуулганы өсөлтийн чухал нөхцлүүд болно.

> Хүсэл тэмүүлэл "Хүсч буй", нөөц боломж **"хэрхэн",** уур амьсгал "хүрэх" болно.

Чуулганы нөлөөт уламжлалыг бий болгохдоо эдгээр гурваас нэг юмуу хоёрыг нь авч хэрэглэх бус бүгдийг нь адил тэнцвэртэйгээр авч үзэх нь чухал. Хүсэл тэмүүлэл **"Хүсэлт",** нөөц боломж **"Хэрхэн",** уур амьсгал "**Хүрэх"** болно. Энэ гурван зарчим чуулганд нөлөөт уламжлал бий болгоход ихэд тустай. Доор дүрсэлсэн үр жимсгүй, айдас, өнгөц авч үзэх нь гурваас нэг юмуу хоёрыг нь сонгож авахад гарч ирэх үр дүн юм.

Хүсэл тэмүүлэлтэй нөөц боломжийг авч үзэхэд л уур амьсгалыг хөгжүүлээгүй үед **үр жимсгүй байдал** үр дүн бий болно. Нөөц боломжийг уур амьсгалтэй авч үзэхэд хүсэл тэмүүлэл Бурханы цаашид явахыг хүсч буй хөдөлгөөнийг харахыг хүсдэг хүмүүс болон удирдагчдын зүрхэнд үгүй болж аливааг **үр дүнгүй төгсгөлийн** үр дүн гарна. Уур амьсгал хүсэл тэмүүлэл хоёрыг л авч үзээд нөөц боломжгүйгээр багт **цухалдал** төрдөг. Чуулганы нөлөөт уламжлалын зүрх нь төвд байрлаж гурвууланг нь эн тэнцүүхэн авч үздэгт л байдаг. Дараах бүтцийг хараарай.




Эрүүл Монгол чуулганы аль ч сайн зүйлс эхлэхдээ **хүсэл тэмүүллээс** үүсэлтэй. Хүсэл тэмүүллээ хөгжүүлэхдээ удирдагчид шаардлагатай мэдээлэл ба мэдлэгийг эрж хайдаг. Тэд хараагаа хөгжүүлэн, өөрсдийгөө өдөөж, өөрчлөлтөнд бэлтгэдэг. Багтаа сэтгэл хөдөлгөм бас нээлттэй байх хүсэлтэй байж, байгаа нөхцөл байдлаа тодорхойлж, **итгэл найдвараар** босгон байгуулах шаардлагатай цаг хугацаагаар хөрөнгө оруулдаг. Хүсэл тэмүүллийн тойрог мэдлэг, хараа, итгэл найдварыг багтаадаг.

Энд баяртай мэдээ байна. Удирдагч бүр нөлөөлөгч, Бурханы таныг байлгахаар товлосон газартаа байгаа та **суралцах чадвартай**!

Хүсэл тэмүүлэл **мэдлэгээс** үүдэлтэй. Бурхан “мэдлэггүйгээс миний ард түмэн мөхөх аюултай” хэмээн хэлсэн (Хосеа 4:6). Чуулганы олонхи удирдагчид эрүүл өсөлттэй чуулганы үр ашигт баярлан хөөрөхийг хүсдэг ч одоо нүүрэлдэж байгаа энэ нөхцөл байдлаас тэр хүртэл хэрхэн явахаа ухаараагүй байдаг. Тэдний ирээдүй нь “устгагдсан” байх бөгөөд энэ нь тэд юу ч мэдэхгүйд л байгаа юу. Зөвшилцсөн төлөвлөгөө, чуулганы бүтэц, чуулганаа босгоход авах алхмууд, итгэлцлээ хөгжүүлэх харилцаа, эсвэл удирдлагын хөгжил ба

сайн мэдээний төлөө авах арга хэмжээнүүдийг хэрхэн авч үзэх уур амьсгалыг мэдлэгээр өөрчилж болох юм.

Энд баяртай мэдээ байна. Удирдагч бүр нөлөөлөгч, Бурханы таныг байлгахаар товлосон газартаа байгаа та **суралцах чадвартай**! Биднээс өөр удирдагчдаас суралцах нь бидэнд үнэтэй бөгөөд хүн чанар биднийг үүн рүү түлхдэг. Амьдралынхаа турш суралцах хүсэл тэмүүлэл нь бидэнд хэрэгтэй мэдлэгийг хуримтлуулахад тустай. Эрүүл бас өсөлттэй чуулганы удирдагчид сүнсний ажлыг бас заах чадамжтай байдаг. Хүмүүс заалгаж, залруулж, сургагдахад бэлэн. “Бичээс бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахуй, зэмлэхүй, **залруулахуй, зөвд чиглүүлэхүйд тустай**” (2Тимотод 3:16).

Монголын удирдагчид өөрийгөө л гэх эго үзлээ орхиж, төлөвшсөн хүмүүсээр үр нөлөөт чуулганы уламжлалыг бий болгохыг хүсдэг буй за. Тэднийг хайж буй мэдлэг нь хаанаас ч бай хэнээс ч бай тэдний сурсан зүйлс билээ. Тэд заалгахуй, залруулахуй, сургахуйд сэтгэлийн **гүнээсээ хүсэлтэй** байдаг. Хүүхэд байхдаа томчуудаар засагдаж байснаа санаж байна уу? Танд таалагдаж байсан уу? Мэдээж таалагдаагүй байх. Паул “Би хүүхэд байхдаа хүүхэд шиг ярьж, хүүхэд шиг боддог, сэтгэдэг байлаа. Би эрийн цээнд хүрээд хүүхэд зангаа орхисон юм” (1Коринт 13:11).

> Үр нөлөөт чуулганы уламжлалыг бий болгохыг хүсдэг удирдагч бүр заалгахуй, залруулахуй, сургагдахуйд сэтгэлийн гүнээсээ суралцахад дуртай байдаг.

“Хүүхэд зан” гаа орхихыг төлөвшсөн удирдагчдаас шаарддаг. Удирдагчийн хувьд, сургахуй, залруулахуй, сурахуйд насан туршдаа суралцахын тулд зориулдаг. Бичээс гэсгээлийг эсэргүүцвэл бусдыг сүйрэл рүү хөтөлнө (Сургаалт үгс 10:17), залрууллыг үзэн ядагч нь харанхуй бүдүүлэг (Сургаалт үгс 12:1), гэсгээлтийг сахигчид алдар хүнд (Сургаалт үгс 13:18) гэсэн байдаг.

Басамжлагч нь зэмлэгчийг хайрладаггүй. Тэрээр мэргэн хүн уруу зүглэхгүй. (Сургаалт үгс 15:12). Сургамжийг үл ойшоогч өөрийгөө үл хэрэгсэх. (Сургаалт үгс 15:32).

Эдгээр **Үгс** зүгээр нэг бодол санааг дэмжих бус бидний суралцаж өсөх хүслийг өдөөдөг. Чуулганд үйлчилж буй Монгол удирдагчид өөрчлөлтийн төлөө урагшилж, өнөө байгаа зуршлаа шинэ бодол санаагаар шинэчилж, өөр байхад чиглүүлж буй шинэ зуршлыг

хүсэх нь сайн. “Гэсгээлтэд минь эргэн ханд. Тэгвэл, би сүнсээ та нар дээр бялхуулна, үгээ би та нарт мэдүүлнэ.” (Сургаалт үгс 1:23). “Мунхгийн зам нүдэнд нь зөв. Мэргэн нэгэн зөвлөгөөг сонсох” (Сургаалт үгс 12:15).

“Басамжлагчийг бүү зэмлэ, тэр чамайг үзэн ядна. Мэргэнийг зэмлэ, тэр чамайг хайрлана” (Сургаалт үгс 9:8). “Мэргэнд соёрх тэрээр улам мэргэн болно. Зөвтийг сурга, тэрээр мэдлэгээ арвижуулна” (Сургаалт үгс 9:9). “Ухаалаг нэгний зүрх тушаалыг хүлээн авах” (Сургаалт үгс 10:8).

Энэ санаагаар, Бурханы өмнө бүрэн үнэнч байхыг хэлнэ (Еврей 4:13). Удирдагч нь, эрүүл өсөлттэй Монгол чуулганд хэрэгтэй оролцоог бас мэдлэгийг эрэн хайхаар хэрхэн хүсэх вэ? Есүс Эзэнээр залруулагдан өөрчлөгдөхийг зүрхнийхээ хэр гүнээс хүсч байна вэ? Танд одоо байхгүй байгаа мэдлэгийг хүлээн авч өсөх хэр их хүсэл тэмүүлэл байна вэ?

Есүс Эзэнээр залруулагдан өөрчлөгдөхийг зүрхнийхээ хэр гүнээс хүсч байна вэ? Танд одоо байхгүй байгаа мэдлэгийг хүлээн авч өсөх хэр их хүсэл тэмүүлэл байна вэ?

Эрүүл өсөлттэй Монгол чуулганы болон заалгахуйд хүсэлтэй удирдагчийн чин сэтгэлийн хооронд шууд харилцаа бий. Үр нөлөөт хөгжлийн төлөө хувийн зуршилтай удирдагчид өөрчлөгдөх бас суралцаж өсөх хэрэгтэй. **Тэд мэдлэгийг эрэн** хайж – тэднийг илүү ухаалаг бас үр нөлөөт болоход туслах **ямарч арга замуудыг** суралцаж, залруулагдах чин хүсэлтэй байх. “Энэ нь миний сэтгэл зүрхэн дотор шатаж буй гал мэт болно. Би үүнийг дотроо хадгалвал ядарч ...,” (Иеремиа 20:9) өмнөхтэйгээ адилгүй болно. Тэдэнд байгаа Үг, байгаа байдал нь хүлээн зөвшөөрөгдөөгүй.

Таны зүрх одоо хүчтэй цохилж байгаа бол үнэн болох сүнсийг тань таны дотор буй Сүнс таныг шалгаж байна (1Иохан 5:6-9) та ямар нэгэн зөвшилцөлд хүрч байгаа бол таны өнгөрснөөс илүүтэй ирээдүйг тань Есүс Эзэн хүчтэй болгоно гэдэгт итгээрэй! Та шинэчлэгдэн сэргэж, Бурханы хөдөлгөөний дүүргэлтээр таны үйлчилж буй Бурханы хүмүүст хүрэх болно.

Есүс Эзэний таныг сураасай хэмээн хүсч заасан бүгдийг Ариун Сүнс танд зааж өгнө (Иохан 14:26). Танд хэрэгтэй мэдлэгийн эх сурвалж болон таныг гайхшруулах Сүнс байгаа учир номхон дөлгөөнд таныг

> Таны өнгөрснөөс илүүтэй ирээдүйг тань Есүс Эзэн хүчтэй болгоно гэдэгт итгээрэй!

төлөвшүүлнэ! Ариун Сүнс бидний хүсэл тэмүүлэлд төрөхөд бидний өмнө явсан бусад хүмүүсийг ойлгох болно. Бидэнд сурахад туслах бусад удирдагчидтай харилцаа холбоогоо хэзээ ч тасалж болохгүй. "Суралцагчид бэлэн болоход багш гарч ирдэг." Хүсэл тэмүүллийн тойрог хэзээд мэдлэгээр цангахаас эхтэй. Мэдлэгийн хөгжил бол биднийг Бурханы хараа зорилгыг эрэн хайх залбиралд хөтөлдөг.

Хүсэл тэмүүлэл **харааг** бий болгодог. Чуулганы харааг хөгжүүлэх нь мэдлэгийн нөлөөнд биднийг автуулдаг. Гайхалтай эрүүл чуулганы тухайд Бурханд бүрэн арга зам байгаа бол тэр нь ямаршуу харагдах болоо? Юугаараа өөр байх болоо? Хүмүүс хэрхэн бодож үйлдэх бол? Хэрэв "бидний гуйж бодохоос илүүтэй хэмжээлшгүй бялхлаар" Бурхан агуу арга замаар хөдөлбөл (Ефес 3:20), энэ бүхэн болж байгааг бид хэрхэн мэдэх вэ? Манай чуулгануудад Бурхан гайхамшигтайгаар ажиллавал уламжлал шинэчлэгдвэл юугаараа өөр байх болоо?

Өөр ирээдүйн алсын хараа нь дандаа удирдагчийн зүрх сэтгэлд эх үүсвэрээ тавьсан байдаг. Тэгээд тэдэнд хадгалагдаад зогсдоггүй. "Хуваалцсан хараа" болж зөвшилцсөн төлөвлөгөөг бий болгодог. Санаанд буулгасан зураглал, ирээдүйг дүрсэлсэн хараа нь таныг дагаж буй хүмүүстээ өгч болох удирдагчийн гарт буй агуу бэлэгт билээ.

> Ариун Сүнс бидний хүсэл тэмүүлэлд төрөхөд бидний өмнө явсан бусад хүмүүсийг ойлгох болно. Бидэнд сурахад туслах бусад удирдагчидтай харилцаа холбоогоо хэзээ ч тасалж болохгүй.

Ийм хараа нь нэг дор шууд бий болдоггүй. Цаг хугацааг туулан ирдэг. Дурангаар хагас километрийн зайг харахтай адил. Үүнийг харж байна хэмээн бодож тэнд хүрэхээр алхаж эхлэх болно. Эхэндээ ҮРГЭЛЖ эмх замбараагүй мэт байдаг ч цаг хугацаа өнгөрөх тусам тодорсоор тодорсоор л байдаг. Хамтран үйлчилж байгаа багийнхнаар хараа улам бүр нэмэгдэн төгөлдөржиж байдаг. Бурхан бидэнд "Үзэгдлийг бичээд, ... үүнийг хүлээгтүн. Хойшлолгүй

заавал биелэгдэх болно” (Хабакук 2:2-3) хэмээн сануулсан.

Одоохондоо **мэдлэг** болон **хараа** нь улам бүр тодорхой болох цагт багийн хүн бүрт **итгэл** найдвар төрнө. “Үүдний сахиулаар” сонгогдсон хүмүүс нь бүгд ... Давид тэднийг **итгэмжит ажилд** томилов (1Шастир 9:22). Багийн 5 үйл ажиллагааны саатал, Патрик Ленсионий номонд эерэг уламжлалыг бий болгоход хамгийн чухал бас үнэнч байдлыг бий болгодог нь итгэл хэмээн ажигласнаа тэмдэглэсэн байдаг. Тэрээр, “Итгэл үгүй газарт удирдагчийн хүсээгүй зүйлс багт санаа зовнилыг авчирч саад болдог. Бусаддаа алдаа оноогоо, сул талаа нээлттэй илэрхийлээгүйгээс итгэлийг суурийг тавих боломжгүй.”

Бусдад үнэнч байж бид итгэлийг барьж байгуулна. Эерэг түүхийг хуваалцана. Христитгэлт Монгол Чуулганы болон дэлхий даяар итгэмжтэй үйлчилж буй баатруудтай хамт баярлана. Тэднийг сонсож, тэднээс цаг үргэлжид суралцана. Багийг маань ирээдүйд илүү төрхжүүлэн байгуулах оролтуудыг бид залбиран хайна. Бүтээлч сэтгэлгээг дэмжин сэтгэл хөдөлгөхийн төлөө залбирна.
Удирдагчдын шударга байдал тэдний тэмцэл, багийнхаа гишүүн бүрийг анхааран халамжлах – гэх мэт бүгд нь итгэлцлийг байгуулдаг.

> Бие биедээ үнэнч байж итгэлийг бид бий болгоно. Эерэг түүхийг ярина. Баатруудтайгаа баярлана. Бид сонсож, цаг үргэлж суралцана.

**Хүсэл тэмүүллийн** эхний тойрог бидний “хүсч буй” зүйл! Мэдлэг, хараа, итгэлийг өөртөө агуулдаг.

Хоёр дахь тойрог бол **нөөц боломж**. Энэ тойрогт **хүмүүс, систем ба сургалт, нярвын үйлчлэлийг** өөртөө багтаадаг. Зарим удирдагчид энэ талаарярихдаа хамгийн чухал нөөц бол мөнгө санхүү гэж боддог ч үнэндээ энэ нь буруу ташаа ойлголт. Бидний хамгийн чухал нөөц боломж бол хэзээд хүмүүс юм! Өргөжүүлэх ба орлуулах бараа бүтээгдэхүүн бол тэд биш. Хүмүүс өөрсдийг нь үнэлэн хүндэтгэж байгааг эсвэл хэрэглэж байгааг мэдэж байдаг. Бид үргэлж хүмүүсийг халамжлан “өөрсдийгөө тэдний сайн хоньчин” болгох хэрэгтэй (Иохан 10:11). Тэднийг хэр их асарч дэмжиж байгааг тэднийг мэдэх хүртэл тэд бидний халамжийг анхаарахгүй. Эрүүл чуулганууд Бурханы дуудсан, Тэр биднийг удирдаж байгаад итгэдэг хүмүүсийн багийг зөвшилцсөн төлөвлөгөөгөөрөө бий болгож байгаагаа ойлгодог. Нөөц боломж дандаа **хүмүүсээс** эхэлдэг.

Багтаа бид зөв хэмээн үзсэн хүмүүсээ оруулсан ч **системийг** бий болгож багаа **сургалтаар** хангах хэрэгтэй. Назарын хөдөлгөөний зарим нэгэн ашигтай нөхцөл бол пасторын сургалт боловсролыг хөгжүүлж, баталгаат гэрчилгээ олгон, зан төрх, өрсөлдөх чадамжийг хөгжүүлж, чуулганы хөгжил ба сургалт болон чуулган тарилтыг төлөвлөх, чуулганы тайлангаа хариуцлагатайгаар хийж маш их нөлөөг бий болгож, чуулганы тогтвортой хөгжлийг илүү дэвжүүлэх туслалцааг бий болгосон.

Христитгэлт Монгол Чуулганы болон дэлхийн бусад улс орны, мөн Америкийн пастор удирдагчидтай харилцаж хамтран ажиллах сүлжээг бий болгохыг бид хүсдэг. Цаг үргэлжид бид албан ба албан бусаар сургаж байна. Пасторуудыг чуулганы хөгжлийн төлөвлөгөө зохиоход тусалж байна. Удирдагчдыг дэмжин зөвлөж, тэдгээр төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхдээ хариуцлагатай системийг бий болгож байна. Үргэлжилсэн халамжлагчийн үйлчлэлээр чуулганыг цаашаа олон янзын зөвлөгчтэйгээр урагш явахад дэмжин урамшуулдаг. Пасторууд ба гол удирдагчдын залбирлаар, Христийн санааг хайж, сүнслэгээр төлөвлөн, зөвшилцсөн төлөвлөгөөг хамтдаа бий болгох эх үүсвэрээ тавина.

Хүмүүстэй хамт, системүүд болон газар байршлын сургалт, нөөц боломжийн тойрог нь нярвын сэтгэлгээг шаарддаг. 3 бүлэгт ярилцаж байсан үр нөлөөт чуулган илүү хүлээлттэй чуулган ба өгөөмөр чуулганыг бий болгодог гэсэн. Нярвын үйлчлэл нь цаг хугацааг эзлэн, бэлгэ чадвар баялгийг (санхүү) агуулдаг. Христитгэлт Монгол Чуулган бүрийн зорилго маш чухал, учир нь Есүс Эзэн ихэнхдээ санхүүгийн нярвын тухай ярьж байсан бөгөөд эрүүл чуулганы удирдагчид үйлчлэлдээ санхүү босгож байсан Эзэний жишээг дагана. Цэвэр зүрх, хүсэлтэй гартай хамт Бурхан МАШ ИХИЙГ үйлдсэн ч Есүс Эзэнийг аялахад хамт явж буй хүмүүст “дагалдагчдад нь тэдний хэрэгцээнд туслах дэмжлэг” хэрэгтэй байсан. (Лук 8:3). Есүс Эзэний төлөвлөгөө ба Түүний зорилгод санхүүгийн нөөцийг бий болгох өсгөх шаардлагатай байдаг. Бурханы тэдэнд хариуцуулсан мөнгө санхүүд хэрхэн итгэмжтэй байх ёстойг Есүс Эзэн онцлон олонтаа заасан. Бидэнд өгөгдсөн бүх зүйлд бид эзэд нь биш харин нярвууд гэдгийг Тэр сануулдаг.

Хүсэл тэмүүлэл, хараатай нутгийн чуулган ба Бичээст заасан өгөөмөр нярвын авдаг шагнал болон Бурханд дуулгавартай байснаар бий болдог гайхалтай туршлагуудад итгэдэг. Зөвшилцсөн төлөвлөгөө

хаана байна тэнд өнөө цагт байгаа хүч ба нөөц боломжид тулгуурласан ирээдүйд найдсан найдвар болон хараагаа хуваалцдаг. Хоёр дахь тойрогын нөөц боломж “хэрхэн” гэдэгтэй холбогддог. Хүмүүсийг оролцуулаад, систем, сургалт бас нярвууд багтана.

Гурав дахь тойрог бол чуулганы **уур амьсгал**. “Уур амьсгал” гэдэг үгийг зарим хүмүүс “соёл уламжлал” гэдэг ч бид тэгж хэлдэггүй. Уламжлалыг өөрчлөлт рүү хөтөлдөг нэг үндсэн шалтгаан нь уур амьсгал гэж бид итгэдэг. Уур амьсгалын өөрчлөлтийг хэрэв бид дүүргэж чадвал цаг хугацаа өнгөрөхөд чуулганы уламжлал шинэчлэгдсэн байна. Уур амьсгалыг өөрчлөх гурван зүйл болох залбирал, сүнслэг төлөвлөгөө, зөвшилцсөн төлөвлөгөө багтдаг.

## Залбиралд Итгэснээр Бүх Зүйл Эхэлдэг

Чуулганы эхэн үеийн бүх зүйл залбиралд итгэснээр үүдэлтэй. Олон Христитгэлтэн залбирдаг ч “залбиралдаа итгэж” хэрэгжүүлэх итгэлийн түвшинд хүртэл залбирлын амьдрал нь тэднийг хөдөлгөхгүй байна. Есүс Эзэн рүү ирсэн хүүгийн аавын жишээг дагаснаар гайхалтай үр ашгийг тэд олж авна. Түүний хүү муу сүнсэнд эзлүүлээд амьдралынхаа турш зовж байсан.

> Есүс Эзэнтэй цаг өнгөрөөснөөр анхны дагалдагчид хэрэгцээгээ маш амархан таньж мэдсэн. Тэд “Бидний итгэлийг өсгөж өгөөч!” хэмээн гуйсан.

“Та юуг ч хийж чаддаг бол биднийг өрөвдөж туслаач” гэлээ. Есүс түүнд “Та чаддаг бол” гэв үү? **Итгэдэгт нь бүх юм боломжтой”** гэхэд хүүгийн эцэг “Би итгэж байна. Итгэлгүй байгаад минь туслаач” хэмээн чарлав. (Марк 9:22-24). Залбиралдаа итгэх туршилтаар бидний итгэл өсдөг. “Итгэл нь сонссоноор, сонсох нь Бурханы Үгнээс” (Ром 10:17, NKJV). Есүс Эзэний дагалдагчдынхаа зүрх сэтгэлд юу тарьсан бас удирдагчдын эрүүл өсөлттэй чуулгандаа юу тарьж байгаагаас итгэлийн төвшингөө барьж босгоно.

Есүс Эзэнтэй цаг өнгөрөөснөөр анхны дагалдагчид хэрэгцээгээ маш амархан таньж мэдсэн. Дагалдагч бэлтгэх “Итгэлийн талбартаа” тэд Есүс Эзэнээс тусламж гуйсан. Тэд “Бидний итгэлийг өсгөж өгөөч!” хэмээн гуйсан (Лук 17:5). Есүс Эзэний дагалдагчид бидэнд ч энэ хэрэгцээ байна. Христитгэлт Монгол чуулганы удирдагчид

Есүс Эзэнээр цангаж, “Өнөөдөр бидний итгэлийг өсгөж өгөөч!” гэж асууцгаая. Тэр бол чуулганы тэргүүн хэмээн бид итгэдэг. Тэр амьд Сүйт бүсгүйгээ Түүнээс бүрэн хамааралтай байж залбиралдаа итгэж бүх дэлхийд хүрэхэд чиглүүлэн удирддаг.

Манай чуулганууд ихэнхдээ “Шинэ Гэрээний чуулгануудад сүнслэг хүч нотолгоо болдог” хэмээн ярьдаг. Анхны чуулган юу хийсэн бэ? Тэд залбиралдаа итгэсэн! Есүс Эзэнтэй цаг өнгөрөөх нь түлхүүр гэдгийг ухаарч ойлгосон. Есүс Эзэнтэй залбирлаар хамт байхад Түүний хүсэл, Түүний Сүнс, Түүний үнэ цэнэ, Түүний зүрх сэтгэл бидний зүрх сэтгэлд бууж шингэнэ. Түүний хэлсэн сүнслэг бодит байдлын талаар хэлсэн “Бурханы хувьд бүх зүйл боломжтой” (Матай 19:26) гэсэн үгийг таньж мэдэх болно. Бид хэзээ ч ганцаараа биш! (Матай 28:20) Тэр бидэнтэй хамт! (Матай 18:20)

Анхны чуулганыг дүүргэсэн “Сүнс” ямар байсан бэ? Тэд сүнслэг хүч чадлыг хаанаас авсан бэ? Лукийн тайлбарт “Эрдэм номгүй, юм сураагүй Петр, Иохан хоёрын зоригтой байгааг тэд хараад гайхацгаан, Есүстэй хамт байсныг нь мэдэв.” (Үйлс 4:13). Есүс Эзэнтэй цаг өнгөрөөх тусам тэдэнд итгэл илүү хэрэгтэй болжбайсан! (Лук 17:5) Тэнгэрлэг Эцэгтэй илүү ярьж Түүнийг сонсож сурах хэрэгтэй (Лук 11:1). Есүс Эзэний хамтран ажилладаг аргачлалыг тэд хараад Түүний амьдралд буй хүч Бурханаас гэдгийг төвөггүй мэдсэн тул тэд залбиралдаа итгэх хэрэгтэй болсон.

> Есүс Эзэнтэй залбирлаар хамт байхад Түүний хүсэл, Түүний Сүнс, Түүний үнэ цэнэ, Түүний зүрх сэтгэл бидний зүрх сэтгэлд бууж шингэнэ.

Есүс Эзэн бидний үлгэр жишээ. Бидний зорилго бол Түүнийг дагаснаар Христтэй адил дагалдагчдыг бэлтгэх юм. Түүний зүрхийг эрж хайж, Түүний Сүнсээр дүүрч, Түүний Үгийг уншиж, Түүний хүслийг эрэн хайж, адил хүсэлтэй итгэгчидтэйгээ нэгдэн байхыг бид эрэлхийлж байна. Биднийг залбирах үед зөвшилцсөн төлөвлөгөө нь бидний дунд бий болох нь Түүний хүсэл юм. Түүнийхээс өөр ямар ч төлөвлөгөөг бид хүсэхгүй! Есүс Эзэний Сүнстэй адил нэгэн гэж үгүй бөгөөд Тэр чуулганд дүүрэхэд залбиралдаа итгэх нь хэрэгжинэ!

Ийм төрлийн залбирал бидний одоо мэдэхгүй байгааг Бурхан залбирлаар маань дамжуулан хариулж харуулах баталгааг хүлээн автлаа залбирахад суралцана гэсэн үг (Иеремиа 33:3). Тодорхой

залбирна (Матай 6:11, Марк 10:51). Бид гуйгаагүй учраас хариугаа аваагүй (Матай 7:7). Бид заримдаа зөв хандлагаар залбираагүй байдаг (Иаков 4:2-3). Залбиралдаа бид тууштай байхыг бас хэлнэ. Есүс Эзэн итгэл ба тууштай байдалд шууд харилцаа байдгийг заасан. Түүний дахин ирэх үед, итгэл маань амьд бидний дунд бат бөх байхыг харахыг хүснэ! (Лук 18:1-8)

Өөрсдийнхөө биш харин Бурханы хүслийг, Есүс Эзэний л төлөвлөгөөг хүссэн гуйвшгүй сэтгэлтэй байхад "Түүний хүслийн дагуу юу ч гуйсан Тэр биднийг сонсоно. **Бид юу ч гуйсан, бид Түүнээс гуйснаа авсан болохоо мэднэ**. Энэ нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм" (1Иохан 5:14,15).

Чуулганы уур амьсгалыг залбиралдаа итгэснээр өөрчилнө. Залбиралдаа итгэх нь хүмүүсийнхээ дунд байгаа Бурханы оршихуйг авчрах юм. "Тэнгэрлэг хүч нь тэнгэрлэг оршихуйг үргэлж дагуулдаг. Библид, Эхлэлээс Илчлэлт хүртэл, залбирал нь Бурханы хүчийг хэрхэн авчирч байгааг харуулсан түүх олон. Есүс Эзэн дагалдагчиддаа хүлээж байхад нь ирэх анхны үр жимс ба Ариун Сүнс залбирлаар ирэх болно хэмээн амласан." 14 (Үйлс 1:4,8). Өөр өөр чуулганыг харж ажигласнаар залбиралдаа итгэх туршлага болно.

Чуулганы хэрэглэдэг ямар ч үйл явц нь Есүстэй хамт үр дүнтэй төлөвлөгөөний хүчийг сулруулж, бүх л эрүүл чуулганы зүрхэнд залбиралдаа итгэхийг хуурдаг. Энэ нь бидний чуулган бус Есүс Эзэнд л хамаардаг. Тэр Тэргүүн. Түүний төлөвлөгөө хүсэл л биелэлээ олох болно. Түүний хүслийг эрэн хайж, залбирлаар дамжуулан юу хүсдэгийг нь мэдэх болно. Залбиралдаа итгэхээс бүх зүйл эхтэйг ухаарах сүнслэг ойлголт чуулганыг барина.

> Энэ хүсэл тэмүүлэл, нөөц боломж, уур амьсгал гэсэн 3 тойрог нутгийн чуулганд зэрэгцэн орших нөлөөт уламжлалыг бий болгох болно!

**MULTIPLYNAZ** сургалт, хэрхэн эрүүл өсөлттэй чуулганыг бий болгох сүнслэг төлөвлөлтийг бид ярьж, тэд мэдэх ёстой бүхнээ мэдээгүй гэдгээ өсөж буй чуулганууд мэдэх болно. Тэдэнд байхгүй боловч бусад удирдагч ба чуулганд буй мэдлэгийг эрэн хайхад тэднийг хөтөлнө. Чуулганы хөгжлийн үйл явцад, хамаарлаас хамаарлын бус руу бас харилцан хамаарал руу шилжих болно. Залбиралдаа итгэхэд,

сүнслэг төлөвлөгөө ба чуулганы хөгжил хоёр нэгдэж, зөвшилцсөн төлөвлөгөөгөөр гайхалтай үр дүнд хүрнэ.

Ариун Сүнсний удирдлага дор, чуулганыхаа гишүүдийн дагалдагч бэлтгэх зуршлын "хөрс" ийг чуулган бэлдэхэд хүмүүс Бурханы гайхалтай тэнгэрлэг мөчүүдийг туршин мэдэрч, тэр чуулган зогсолтгүй урагшлах болно! (Үйлс 2:42-47) Тэд баяр хөөр ба өөдрөг үзлээр тэргүүлүүлсэн учир нь чуулганы хүн бүр мэдрэмжтэй байж хамтдаа агуу ирээдүйг бий болгох юм. Есүс Эзэн амьд, үүнийг тэд мэддэг! (Үйлс 4:20) Энэ **хүсэл тэмүүлэл, нөөц боломж, уур амьсгал** гэсэн гурван тойрог нутгийн чуулганд зэрэгцэн оршиж нөлөөт уламжлалыг бий болгох болно!

## Төлөвлөхдөө Халуун Сэтгэлээр Холбогдох

Нөлөөт уламжлал байгаа хаа ч хүмүүс багаараа халуун сэтгэлээр шатаж байдаг. Энэ нь хувь хүний онцлог ба сэтгэл хөдлөл, халуунаас үл хамаарна. Тэдгээр нь тайзны ард чимээгүй явах болно. Паултай адил "Миний дотор хүчтэй нөлөөлөх **Түүний хүч чадлаар** би зүдэн зүтгэж, үүний төлөө тэмцдэг", Эзэн Есүс тэднийг хаашаа чиглүүлж буйг тэд чин сэтгэлээсээ мэдэхийг хүсдэг (Колоссай 1:29). Өөрсөддөө тогтмол "тэдэнд буй Бурханы бэлгийг сэргээхийг" сануулдаг (2Тимотод 1:6). Тэд "Тахилын ширээн дээрх **гал байнга асаж** байх ёстой. Энэ нь унтрах ёсгүй" г (Левит 6:13) мэддэг.

> Бурханы хүсэлд төвлөрснөөр, Түүний танд дүүргэсэн хүсэл тэмүүлэл Христитгэлт Монгол эрүүл чуулган бодитоор бий болоход зүтгэх болно!

Эрүүл, өсөлттэй чуулган **халуун сэтгэлээ төлөвлөгөөтэйгээ уялдуулдаг.** Бурханы зүрхэнд нь суулгасан сүнслэг хүсэл тэмүүлэлдээ хүрч чадах ба Бурханы хүчээр хийнэ гэдэгтээ ямар ч асуулт болон эргэлзээг байлгахгүй байдаг. Христэд төвлөрсөн эрүүл, өсөлттэй чуулганыг хүсэхдээ тэдгээрт хүрэх чадамжтай гэдгээ мэдээгүй үед Бурхан эдгээрийг та нарт хэзээ ч тодорхойлж өгөхгүй.

Христитгэлт удирдагч бүр Ариун Сүнсний удирдамжид хувьчлан удирдуулсан чадамжтй байдаг. Ариун Сүнс "Түүний тодорхойлсон" сүнслэг бэлэг ба чадамжуудыг түгээдэг (1Коринт

12:11). Сүнсний удирдамж болон бидний чадамж нь хүслийг маань төрхжүүлдэг хэмээн Паул заасан. "Учир нь Өөрийн сайн тааллын төлөө та нарын хүсэх, ажиллахын аль алинд нь **та нарын дотор үйлдэгч** нь Бурхан Өөрөө юм" (Филипой 2:13). Бурханы хүсэлд төвлөрснөөр, Түүний танд дүүргэсэн хүсэл тэмүүлэл Христитгэлт Монгол эрүүл чуулган бодитоор бий болоход зүтгэх болно! Бурханы танд өгсөн халуун сэтгэлийн хөгжил нь 15 Бурханы харааг бодит болгоход хэрэгтэй алхмуудыг авчирна.

Хэн нэгэн хаа нэгтээ Бурханы өгсөн харааг биелүүлэхэд залбирлын тань хариу болж туслах болно.

Үүнийг залбирлаар эхлээд Бурханыг хүлээ. Бурханд үүнийхээ тухай зүгээр яриад байх бус Бурханы дуу хоолойг сонс. Итгэлийг тань барьж байгуулахыг Түүнээс гуй. Түүний мэргэн ухааныг гуйж байхдаа Түний танд өгсөн санаа бүрийг тэмдэглэж ав. Та болон таны баг юу хийгээсэй хэмээн Бурхан хүсч байгааг тодруул. Та хуваалцаж байгаа зүйлээ хэзээ хуваалцах вэ гэдэгтээ ухаантай байгаарай. Иосефт зөв зүүд байсан ч тэр үүнийгээ цагаа ололгүй хуваалцсан! (Эхлэл 37:5-11)

Өөрөсөө дараах асуултыг асуу, "Хэрэв Бурхан бидэнд өгч буй энэ харааны дагуу явбал яг юуг хийж юунд хүрээсэй гэж хүсч байгаа вэ?" Бурхан өөрөө юу хийх бол? Энэ нь таны залбирлын жагсаалт болно! Бурханаас ирэх тэнгэрлэг мөчийг бид хэзээд хайж олох болно. Энэ үйл явцад **бидний хийх хэсэг** гэж бий. Хэзээ ч мартаж болохгүй, хэн нэгэн хаа нэгтээ Бурханы өгсөн харааг биелүүлэхэд залбирлын тань хариу болж туслах болно. Нэг л өдөр бүх зүйл өөрчлөгдөнө. Зөв цагтаа, зөв газраа, зөв хүмүүстэй уулзаж, хамтдаа Бурханы төлөвлөгөөг гүйцэлдүүлэхийн төлөө залбираарай.

Энэ үйл явцын түлхүүр хэсэг нь Бурханы танд өгсөн харааг гүйцэлдүүлэхэд тустай нарийвчилсан төлөвлөгөөг гаргахдаа өөрийгөө зориулах юм. Таны чадах тэр л нарийвчлалыг гаргахын тулд бүгдийг дэлгэрэнгүй бич. Доктор Ж. Б. Чапман хэдэн жилийн өмнө "Уруулаараа гаргаж, гараараа үйлдэх үед бодол нь санаанаасаа салдаг" гэжээ. Төлөвлөгөөгөө нарийвчлан бичихэд энэ нь бодлого төлөвлөлт биш гэдгийг анхаарах хэрэгтэй. Энэ нь үргэлж өөрчлөлт ба нэмэлтээр үргэлжлэх болно. Төлөвлөгөөгөө төгс болохыг хүлээх хэрэггүй. Төгс төлөвлөгөө ч гэж байхгүй. Бурхан өөрийнхөө хэсгийг

хийж эхлэхийг хүлээн алгуурлах хэрэггүй. Бурхан таныг өөрийнхөө хэсэгтээ хэр нухацтай хандаж байхыг харах болно!
Бүх зүйл нэг л өдөр өөрчлөгдөнө. Зөв цагтаа, зөв газраа, зөв

Эхэлснийхээ дараа Бурханы өгсөн төлөвлөгөөгөө тогтмол давтах хэрэгтэй. Төгс рүү чиглэ. Эзэн хүслээрээ удирдахын төлөө эрэл хайгуул хий. Түүний Сүнсээр төлөвлөгөөгөө баталгаажуулж, нүдэндээ санаа бодолдоо харж, зүрхэндээ мэдэрч, Бурхан үүнийгээ хийх хангалттай агуу том гэдэгт болон Түүний ерөөн дүүргэсэн хүслийнхээ дагуу эхлүүлсэн гэсэн хүсэлдээ итгээрэй! Таныг дуудсан Тэр Нэгэн итгэмжтэй бас хүслээ биелүүлэх болно (1Тесалоник 5:24).

> хүмүүстэй уулзаж, хамтдаа Бурханы төлөвлөгөөг гүйцэлдүүлэхийн төлөө залбираарай.

Бурханы өгсөн хараанд хүрэх хүчээр, хүсэн тэмүүлдэг хүмүүстээ Бурханы ерөөдөг сүнсний хүсэл, үгээр илэрхийлж боломжгүй тийм л мэдрэмж, бодит байдалд азгүйтэл болохгүй тийм сүнсний доотоод хүч зэрэг үүнийг эрэн хайсан хүмүүстээ Бурхан бялхааж чадна!

> “Уруулаараа гаргаж, гараараа үйлдэх үед бодол нь санаанаасаа салдаг.”

**Урт хугацаатай төлөвлөх**

Өнөөдөр удирдагчдын гаргаж байгаа шийдвэр маргаашийн чуулганд хүрэх нөлөө ихтэй. Бичээст, Хезекиа хааны амьдралаас энэ талаар харж болдог. Хезекиа ганцаараа байгаа тэр л өнөөгийн удирдагчийг төлөөлнө. Тэр хувиа хичээгч, бардам бас өнгөцхөн харж дүгнэдэг. Өвчнөөсөө эдгэрсний дараа, Вавилоны элч төлөөлөгчдийн тэдний газар нутгийг тандах даалгавартай ирээд Бурханы хийсэн тэмдгийн талаар асуусан. Үнэндээ Бурхан түүний сэтгэлийн гүнд юу байгааг мэдэхээр туршсан. Харин тэрээр энэ удаа унасан (2Шастир 32:31).

Исаиа эш үзүүлэгч түүн рүү ирээд түүний уналтаас болж ирээдүйд буюу урт хугацааны дараа болох үйл явдлыг хэлэхэд Хезекиа өөрийнх нь амьд байх хугацаанд “аюулгүй амар амгалан” байхыг

мэдээд баяртай байсан (2Хаад 20:19). Өнөөгийн чуулганд бид энэ үр дагаврыг харж байна. Гол удирдагчид болон пасторууд бүгд шийдвэр гаргадаг, тэдний гаргасан шийдвэрийн ургацыг чуулган хорь гучин жилийн дараа тэднийг явснаас хойш хураадаг.

Гадны хүмүүст хүрэх өөрчлөлтийг эсэргүүцэж, тэмцэлд ялалттайгаар дуусдаг, бусдад нөлөөлөх өндөр чадамжтай гол удирдагчид байж болно. Шийдвэрээс болж чуулган хүлээн авахаас татгалздаг. Амар амгалан ба аюулгүй орчин эрсдлийг, боломжийг ялан дийлдэг. Удирдагчид болон шинэ үйлчлэл, чуулганыг өсгөх сонирхолгүй удирдагчид ийм шийдвэр гаргадаг. Ингэснээр үйлчлэлүүдийг шинээр эхлүүлж үржүүлэн нэмэх харааг үгүй хийдэг. Хэдэн жилийн дараа тухайн шийдвэр Бурханы эрүүл бас өсөлт хоёрыг хүсдэг Христитгэлт Монгол чуулганы хөгжилд хүчтэй нөлөөлөх болно.

> Бурхан хайж буултыг үл шөвшөөрөх үгээр илэрхийлж ойлгох аргагүй дотоод хүч нь дотор нь байгаа хүмүүстээ өгдөг.

Шинэ үйлчлэлийг эхлүүлэх их төвөгтэй ажил. Шинэ чуулганыг тарих нь хүртэл замбараагүй болдог. Шинэ чуулганыг үрчлэн асрах нь хараа болон гишүүдээсээ золиос гаргахыг шаарддаг. Чуулганы удирдагчид, S“миний амьдралын хугацаанд л амар амгалан бас аюулгүй байвал боллоо” гэж хүсэх нь амархан. Дараагийн удирдагчдад “ядаргаатай байдлыг дамжуулах” аас илүү амар. Гэсэн хэдий ч, өнөөдөр ахархан харж шийдвэл маргааш Христитгэлт Монгол чуулганы хөдөлгөөнийг сааруулах болно.

> Манай чуулганд, амар амгаланг болон аюулгүйг бид хүсэх учиргүй, үүний оронд эрсдэл бас боломжийг өгөх хэрэгтэй!

Чуулганы удирдагч бидний дуудлага бол хэзээд шийдвэр гаргахдаа өнөө юу нь хамгийн шилдэг эсвэл амархан гэдгээс бус харин бидний хайрладаг чуулганы залгамж халаа үеийнхэнд юу хамгийн сайн бэ гэдэгт л суурилах ёстой. “20 жилийн өмнө тарьсан үр хамгийн сайн. Дараагийн хамгийн сайн зөв цаг бол одоо.” Өнөөдөр бол бидний өдөр! Манай чуулганд, амар амгаланг болон аюулгүйг

бид хүсэх учиргүй, үүний оронд эрсдэл бас боломжийг өгөх хэрэгтэй! Нөлөөтэй удирдагчид үргэлж урт хугацаанд хардаг. Тэд байгаа байдлаар нь хүлээж авч чадахгүй гэдгээ мэддэг. Чуулганы одоогийн хэвийн уламжлал, чуулганы байнгын л нөхцлийг л хүлээн авахаар тэд хүлэгдсэн бус. Бурханы хайраар дүүрч, хүсэл тэмүүллээр бялхаж, хэрэгтэй нөөц боломжийнхоо төлөө цуглан, уур амьсгалыг өөрчилж эхлэн, цаг хугацаа алсрахад Бурхан чуулганы шинэ уламжлалыг бий болгож байгааг харна!

Өнөөгийн удирдагчдын гаргаж буй шийдвэрийн ургацыг маргаашийн чуулган бас бүсийнхэн тэднийг явсны дараа хураах болно.
-

Христитгэлт Монгол Чуулганы хөдөлгөөний суурийг дүүргэдэг нь хайраар удирдан, гадагшаа харж, чуулганы тухайд баттай итгэлүүд, харилцан хамааралтай байж, нөлөөтэй чуулганы уламжлалыг барьж байгуулахын тулд өсөлтийн төлөө зориулдаг байх юм. Энэ номыг унших цаг гаргасанд баярлалаа. Дараах асуултуудын дагуу бусад чуулганы удирдагчидтай ярилцан эдгээр санааг хэрэгжүүлж үзээрэй. Библи биднийг зөвхөн сонсогчид бүү бай харин үйлдэгчид бай гэсэн (Иаков 1:22). **MULTIPLYNAZ** талаар өөр цуврал номууд бий. Та нарыг тэдгээр цувралаас авч уншин хамтдаа үргэлжлүүлэн сурна хэмээн итгэж байна. Бурхан та бүгдийг маань ивээх болтугай!

## Эргэцүүлэх Асуултууд - 7 Бүлэг

1. Танай чуулганы “уламжлал” ын тухай та анх удаа уншиж байна уу? Манай уламжлалд нөлөөлдөг ямар үйлдэл ба авир ааш бидэнд байна вэ?
2. “Гурван тойрог” болох хүсэл тэмүүлэл, нөөц боломж, уур амьсгалын талаар ярилцаарай. Зохиогч маань яагаад гурвуулаа байж нөлөөт уламжлалыг бий болгоно хэмээн үзсэн бэ? Гурваас хоёрыг нь авч үзвэл юу болох вэ?
3. Бурханы чуулганы цэнэглэн хөгжүүлдэг хүсэл тэмүүлэлд гурван зүйл мэдлэг, хараа, итгэл багтана хэмээн зохиогч үзсэн. Та үүнтэй санал нийлж байна уу? Яагаад эсвэл үгүй вэ?
4. Насан туршдаа суралцаж, мэдлэг олж авах нь маш чухал хэмээн зохиогч онцолсон. Заах чадвартай, заахуй, залруулахуй, зөвт

байдалд сургахуйд цангасан хүмүүс. Зарим нь зүгээр л байгаагаараа байх хүсэлтэй байхад зарим нь сурахаа хэзээ ч зогсоохгүй үргэлж өлсөж цангаж байдаг тэдний нөхцөл байдал ба баримтуудыг юу гэж бодож байна вэ?

5. Энд буй асуултуудад 1-10 гэсэн үнэлгээгээр хэмжиж үнэлээрэй (хамгийн доогуур гэснээ 1, хамгийн их хүсдэгээ 10). Эрүүл өсөлттэй чуулганд оролцоход хэрэгтэй мэдлэгийг хэр их эрэн хайхад тэмүүлж байна вэ? Есүс Эзэнээр өөрчлөгдөн залруулагдахыг хэр их хүсч байна вэ? Танд өнөө байхгүй байгаа мэдлэгийг хүлээн авч өсөхийн тулд суралцах хэр их хүсэл танд байна вэ? Санаагаа хуваалцаад таны төлөө залбирахыг хэн нэгнээс хүсээрэй.
6. Чуулганы харааг хөгжүүлэхэд мэдлэгийг дагуулдаг. Бурханы бүрэн дүүргэсэн арга замаар хэрэв чуулган гайхалтайгаар эрүүл болсон бол ямар харагдах болоо? Хүмүүс юу бодож үйлдэх болоо?
7. “Бидний бодож гуйхаас илүү бялхлаар” Бурхан хэрвээ ажиллаж хөдөлвөл (Ефес 3:20), үүнийг болж байгааг бид хэрхэн мэдэх вэ? Манай чуулгануудад болон уламжлалыг шинэчлэхээр Бурхан агуу хүчээрээ ажиллавал ямар харагдах болоо?
8. Залбиралдаа итгэх гэсэн хэсгийг уншсан уу? Танд ямар бодол төрж байна? Үүнийг уншихад шинэ зүйл нь юу вэ? Танд юу харагдаж байна?
9. “Итгэлийн төвшин” гөө та хэрхэн дүгнэх вэ? Дагалдагчидтай адил итгэлээ өсгөхийг Эзэн Есүсээс гуйх уу? Бүх зүйл боломжтой, Бурхантай хамт туршиж, итгэхийн тулд таны сүнсэнд юунаас эхлэн өөрчлөлт хийх вэ?
10. Залбиралдаа итгэснээр зөвшилцсөн төлөвлөгөөг бий болгох Ариун Сүнстэй хамтран ажиллах чуулганыхаа хэсэг нь та байсан уу? Хэрэв тийм бол, энэ ямар байсан бэ? Багтаа санаа бодлоо хуваалцаарай.
11. Чуулганы нөлөөт уламжлалыг бий болгодог, нөөц боломж, хүсэл тэмүүлэл, уур амьсгал болсон чуулганыхаа ямар нэгэн үйл ажиллагаанд оролцож байсан уу? Хэрэв тийм бол багийнхандаа ийм чуулганыг дүрслэн хэлээрэй.
12. “Төлөвлөгөөгөө халуун сэтгэлтэй холбох” хэсэгтэй танилцаарай. Танд ямар харагдаж байна? Танд юу нь шинэ өмнө хэзээ ч сонсож байгаагүй зүйл вэ? Төлөвлөгөөгөө тэмдэглэхээс чухалчлан сурсан зүйл нь юу вэ?
13. Урт хугацааны төлөвлөгөө ягаад удирдагчид харж бодох ёстой вэ?

14. Есүс Эзэний таниас хүсч буй дараагийн алхам юу болохыг бодоорой. Чуулганы нөлөөтэй уламжлалыг бий болгоход оролцох нөхцөл байдлыг ойлгон эхлүүлэх зүйлс та нарт одоо байна, Есүс Эзэн яг юу гэж хэлж байна вэ? Таны үйлчилдэг чуулганыг "нөлөөтэй" болгоход ямар алхмуудыг та авч хэрэгжүүлэх вэ? Үүний төлөө залбираарай. Бид бас таны төлөө залбирч байна. Чуулганаа хайрладаг танд баярлалаа. Гайхалтай өдрүүд урд маань байна!

**Санал болон Залруулгыг хүлээн авна**

Өмнөх үгэнд, энэ цуврал ном дуусах **болоогүйг** танд хэлж байсан. Янз бүрийн оролцооны ОЛОН санааг оноог хүлээн авч улам сайжруулан хөгжүүлэхийг бид хүсч байна. Энэ номын талаар уншсан пастор, ахлагч, удирдагч БҮРИЙН саналыг хүлээн авахыг хичээх болно! Чуулган цөөн хэдэн хүнд бус бүх хүнд хамаатай. Дэлхий даяар хүн бүр түүхийг бичиж байна. 30.000+ чуулган бүрт болж буй гайхалтай ажлуудыг бүгдэд мэдэгдэж хуваалцахын тулд бид суралцаж хэвлэн нийтлүүлэх болно!

**MULTIPLYNAZ** төсөлд хамтран оролцож, шүүмжлэл болон санаа оноогоо хариулт болгон илгээгээрэй хэмээн танд хүсэж бас талархаж байна. Бидний хайж буй бүх зүйл дэх хэм хэмжээ нь "Түүний үйлдсэн болгон сайн ажээ. ... үнэнхүү гайхаж байв (Марк 7:37) гэгдэх Есүс Эзэний хийсэн үйлчлэлтэй адил хэмжүүр хэмээн олох болно.

**MULTIPLYNAZ** цувралын талаар www.multiplynaz.org энэ сайтны **About section** хэсэгт хариултаа бичих хуудас байгаа. Тэр хуудсанд цувралуудын талаар өөрийнхөө санал онол, залруулгаа бичээрэй. Тодорхой ном болон бүлэг дээр таны өөрчлөхийг хүссэн санаа оноог бичихдээ мэдээллээ оруулахыг хүсч байна. Энэ загварыг өөр баталгаа болгон хэрэглэж болно. Энэ хуудаст зөвхөн англиар бичих боломжтой байгаад хүлцэл өчье.

Энэ ном хэдэн арван чуулганы удирдагчдын санаа оноо, залруулгаар сайжруулан хөгжиж байгааг хэлэхэд таатай байна. Сурахаа хэзээ ч дуусгаж болохгүй бөгөөд илүү сайн аргачлалд хүрэх хүртлээ үргэлжлүүлэх болно. Таны бичсэн үг ба өгүүлбэр бүрт бид анхааралтай хандах болно. Таны оролцоонд дахин ТАЛАРХЛАА илэрхийлье.

**Дэлхий даяарх Материалын Нөөцийг Хангах Хараа**

Ихэнх хүмүүс Wikipedia-ийн тухай сонссон байх. Википедиа бол цахим ертөнцийн хамгийн том тайлбарт толь бичиг бөгөөд системийн засварын агуулгад тулгуурласан нээлттэй харилцаанд суурилсан. Бүх л дэлхий даяарх хамгийн том бас алдартай сүлжээ болж маш олон хэлцийг багтаасан. Алексагийн шалгаруулалтаар хамгийн нэртэй сайтаар шалгарсан. Чөлөөт агуулгатай, худалдааны сонирхолгүй, хандивлагчдын хөрөнгө оруулалтаар бий болсон төрийн бус байгууллагын санхүүжилттэй сайт юм.

Дэлхийн төгс чуулганд, цахим сүлжээ Википедиатай адил олон хэлээр буулгаж болдог, онцгойлон Христитгэлт Монгол эрүүл өсөлттэй чуулганы төлөөх загвар дэлхий даяар түгэхийг хүсч байна. Эрүүл, өсөлттэй чуулганы нөөц материалыг бий болгож мөн адил үйлчилж буй бүсийн чуулгануудад хүргэх харилцааг бий болгохыг зорьж байна. Бидний хийсэн оролдлогуудыг боломжгүй болгохгүйн тулд бид нийтлэг хэлтэй болох нь зүйтэй (Эхлэл 11:6). АНУ-ын Цэргийн Инженерийн хэлтсийн уриалга болох “бид хэцүүгээ даруй эхэлнэ, боломжгүй нь удахгүй арилах болно” гэсэн үгээр номоо төгсгөе. **MULTIPLYNAZ** цуврал ном даруухнаар эхэлж байна.

Бурханы хөдөлгөөн ба Бурханы хүмүүсээр дамжин өнөө 212 хэлээр Бурханыг бид магтаж, видео болон хэвлэсэн материалыг 95 хэл дээр бэлтгэж байна. Олон хэлээр магтаал хүндлэлийн, сайн мэдээний сургалт, дагалдагч бэлтгэх, удирдлагын хөгжил ба теологи гэх мэт агуулгатай зуу зуун ном хэвлэгдэн гарч байна. Бүгдэд цэнэглэгдэхэд туслахын тулд бид тодорхой, энгийн суурийг тавьж Ерөнхий Удирдлагын Зөвлөлөөр дамжуулан эрүүл, өсөлттэй Назарын чуулганууд болон бүсийг бий болгохоор зорьж байна. **MULTIPLYNAZ** нь “үндэстнийг Христтэй адил дагалдагч бэлтгэх” бүс болон чуулганд тус дэм болохоор олон аргачлал хөдөлгөөнийн нэг нь л юм.

**MULTIPLYNAZ** цуврал номын талаар **ХЭЗЭЭД** таны санал, залруулга, хариуг хүлээн авах болно. Манай энэ сайтыг www.multiplynaz.org бусаддаа дамжуулаарай. Таны үйлчлэлд хамтрагч болохдоо баяртай байна. Хамтдаа хамгийн сайнаар хийх нь бидний чин хүсэл. Хамтдаа хийж болох илүү сайн арга зам байвал бидэнд мэдэгдээрэй. Гайхалтай өдрүүд урд маань байна.!